

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-51

I. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан 4-51

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороодын
хамтарсан хуралдааны 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн
товч тэмдэглэл***

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 36 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 42 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Болорчулуун, Ц.Идэрбат, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аюурсайхан, Д.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Ц.Мөнх-Оргил.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Нэг.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга И.Батхүү, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Очирваань, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Аудитын менежер Б.Долгорсүрэн, ахлах аудитор М.Наранжаргал, аудитор Б.Булган, А.Мөнхбадрал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Гүнболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эрчим хүчний яамны Төрийн нарийн

бичгийн дарга Н.Тавинбэх, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бямбадагва, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Баасанпүрэв, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Л.Идэрцогт, Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Ш.Цэрэндулам, Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга Б.Буяннэмэх, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын Засгийн газрын референт С.Нямбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын тандалт судалгааны багийн ахлагч, судлаач Б.Анар, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Үнэлгээ, мониторингийн багийн ахлах референт А.Цэвээнгэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, *Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга* Х.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны зөвлөх Б.Нандингэрэл нар байлцав.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд хийсэн аудитын тайлангийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Н.Ганибал, Б.Баттөмөр, Г.Ганболд, М.Оюунчимэг, Д.Тогтохсүрэн, Ч.Ундрам, Н.Энхболд, О.Цогтгэрэл, Ц.Мөнхцэцэг, Ц.Цэрэнпунцаг, Т.Доржханд, Ж.Батсуурь нарын тавьсан асуултад Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

П.Сайнзориг, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, *Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга* Х.Гантулга, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцлээ.

Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хорооноос *гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.*

Уг асуудлыг 14 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 07 минут үргэлжилж, 36 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 14 цаг 39 минутад өндөрлөв.

Хуралдаан даргалсан:

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ
УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр,
Мягмар гараг

Төрийн ордон “Жанжсн Д.Сүхбаатар”
танхим 11 цаг 42 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114.3-д Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн тухайн жилийн гүйцэтгэлийн явцтай нэгтгэн гаргасан тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.1-д заасны дагуу хэлэлцэнэ гэсэн ийм заалттай. Тэр заалтын дагуу сая дурдсан асуудлуудыг хэлэлцэхээр өнөөдөр Байнгын хороо хуралдаж байна.

Хуралдааны ирц хүрсэн байна. Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан 2023 оны 3 сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэнэ. Энэ дээр мөн бас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйл 17, 18.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн хэрэгжилтийн явцын тайланг улсын хөгжлийн тэр жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн хамт хамтарч хэлэлцэнэ гэсэн ийм заалттай.

Үүний дагуу Монгол Улсын 2021-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2022 оны биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020, 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг өнөөдрийн хамтарсан хуралдаанаар хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хуулиараа ийм юм байна. Тийм. Бүгд хуулиар хамтраад хэлэлцэнэ 2 Байнгын хороогоор. Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ 7 төрлийн материал маш зузаан том материал байна. Ийм материал өчигдөр өдөр өгсөн. Тэгээд энийг ямар ч оюун ухаантай, ямар ч хүн өнөөдөр 10 хэдэн цагийн дотор уншаад, энийг бүгдийг нь өнөөдөр энд ярих боломж байхгүй. Урд талын энэ нэг 50 хэдэн хувьтай, 60 хэдэн хувьтай л гүйцэтгэлүүд явж байна шүү дээ.

Тэгээд юун дээрээ алдав, яав гэдэг юмыг чинь нэлээн сайн яримаар байх юм. Яагаад ингээд энэ 7, 7 юмыг ингээд л авч ирээд, суулт асуух гэхлээр 7 юмнаас нэг нэг асуулт асуух юм уу хаашаа юм. Энэ чинь төлөвлөгөө тэр чигээрээ явж байна. Төсвийн бодлого тэр чигээрээ явж байна, мөнгөний бодлого явж байна, Санхүүгийн зах зээлтэй холбоотой бүх асуудлууд явж байна. Яамнуудын энэ төлөвлөгөөний яамнууд явж байгаа. Энийг яаж ярих юм бэ? Энийг салгаж барьж ярьж болдоггүй юм уу?

Тухайлбал 22 оны гүйцэтгэлээ яриад, аудитынхаа дүгнэлттэй яриад ингээд яриад байвал арай илүү юун дээрээ алдав, юун дээрээ онов, цаашид яах ёстой юм? Ингээж ярихгүй юм уу? Энэ ийм хууль дэгтэй юм уу? Яадаг ч юм? Энийг сайн мэдэхгүй юм. Энэ бол дэндүү их бөөндөөд, халтуурдаад явчхаж байх санагдаад байх юм. Яримаар юм маш их байх юм энэ дотор. Яах ёстой юм бол энийг? Дарга

нараа хариулт өгөөч. Дэг журам нь ямар байдаг юм? Яах юм?

Н.Энхболд: Би түрүүн зориуд чуулганы хуралдааны дэгийн тухай тэгээд энэ асуудлуудыг хэлэлцэх дэгийн талаар бас танилцуулсан. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа Дэгийн тухай хууль Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу, Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн дагуу энэ асуудлуудыг хэлэлцэх асуудлыг хамтатгаад Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтарч хэлэлцэнэ гэсэн заалттай.

Мөн дээр нь хэрэв шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлуудынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хэлэлцэж болно гэсэн ийм заалттай шүү Баттөмөр гишүүн. Тэгээд хэрэв жишээ нь. Тийм ерөөсөө л бүгдээрээ. Яах вэ, тэгээд Байнгын хороод болгон өөрс өөрсдийнхөө чиглэлээр тодотгоод хэлэлцэж болох байх л даа. Шаардлагатай гэж үзвэл. Санал гаргаад тэгнэ гэвэл бид нар өнөөдөр хэлэлцчихээд, дараа нь тэр Байнгын хороод дээрээ хэлэлцээд, эргээд саналаа нэгтгээд Улсын Их Хуралд оруулах, танилцуулах ёстой. Хугацаатай өөрөө, хуулийн хугацаатай. Тэгээд энэ хугацаандаа хэлэлцэнэ дээ.

Хэрэв үнэхээр энэ асуудлуудыг илүү дэлгэрэнгүй явж байх шаардлагатай. Илүү тодотгож хэлэлцэж байх шаардлагатай гэж үзвэл хэдүүлээ Дэгтээ өөрчлөлт оруулаад энэ асуудлыг шийдэж болно. Яг өнөөдрийн байдлаар ийм л хуулиар хэлэлцэж явна. Тэх. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Энэ бол юу шүү дээ.

Энэ 21-25 оны үндсэн чиглэл, 20-24 оны үйл ажиллагааны хөтөлбөр дотроос 22 оных нь хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг ярих ийм хэлэлцүүлэг хуралдаан болж байгаа.

Холбогдох материалуудыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Ингээд

хэлэлцэх асуудалдаа оръё. Өнөөдрийн хамтарсан хуралдаанд оролцох ажлын хэсгийг танилцуулъя.

Шадар сайд бөгөөд Эдийн, засгийн хөгжлийн сайд Хүрэлбаатар, Эдийн, засаг хөгжлийн дэд сайд Түвдэндорж, Эдийн, засаг хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Батхүү, Эдийн, засаг хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний дарга Очирваань байна. Мөн яамны бүс нутаг аж үйлдвэрийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Сугар, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Оюун-Эрдэнэ.

Үүнтэй холбогдуулж Үндэсний Аудитын газраас бас танилцуулга хийх ёстой. Үндэсний Аудитын газраас Ерөнхий аудитор Занданбат, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Аудитын менежер Долгорсүрэн, ахлах аудитор Наранжаргал, аудитор Булган, аудитор Мөнхбадрал нар бусад яамнаас Засгийн газрын гишүүн сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Булгантуяа, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Сүхбаатар, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Сумъяабазар.

Хотоос хэн байна вэ Сумъяабазар даргын оронд? Сүхбаатар гишүүнийг дуудаарай. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сайнзориг, Сангийн яамны Төрийн бичгийн дарга Ганбат, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн бичгийн дарга Магнайсүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цогтгэрэл, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганхуяг, Боловсрол, соёл, шинжлэх

ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Цэдэвсүрэн, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Бямбадагва, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Өнөрбаяр, Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батцэцэг, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Төгсдэлгэр, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга Баасандорж, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн ахлах судлаач Анар, мөн газрын хуулийн багийн ахлах зөвлөх Ариунхур, мөн газрын Үнэлгээ мониторингийн багийн ахлах референт Цэвээнгэрэл, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга Идэрцогт, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Цэрэндулам, мөн яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга Буяннэмэх, Барилга, хот байгуулалтын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Гүнболд, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сүх-Очир, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ерэн-Өлзий, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын Төрийн өмчийн удирдлага төлөөллийн албаны дарга Дарханбаатар нарын хүмүүс ирсэн байна.

Одоо Монгол Улсын 2021-25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 22 оны биелэлт, Засгийн газрын 20-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 22 оны хэрэгжилт Монгол Улсын хөгжлийн 22 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгыг Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Хүрэлбаатар хийнэ. Хүрэлбаатар сайдыг урьж байна.

Ч.Хүрэлбаатар: Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга нар, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хуулийн хугацаанд гарган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсний дагуу танилцуулж байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл нь 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2022 оны явцын дундаж үнэлгээ 74.2 хувьтай гарч байна.

Монгол Улсын 2021 оноос 2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 9 бүлгийн хүрээнд 150 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2022 оны явцын дундаж үнэлгээ 45.7 хувьтай байна. Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 6 бодлого 259 зорилтын хүрээнд 1087 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2022 оны байдлаар 69.8 хувийн өссөн дүнгээр 39.3 хувь хувийн хэрэгжилттэй байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд 6 бодлогын хүрээнд 23 зорилт дэвшүүлж, 300 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2022 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 67.5 хувьтай байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүлэг тус бүрээр бүрээр авч үзвэл КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг нийгмийн

хүндрэлийг даван туулах бодлого 89.3 хувьтай, хүний хөгжлийн бодлого 66.5 хувьтай, эдийн засгийн бодлого 61.2 хувьтай, засаглалын бодлого 70.1 хувьтай, ногоон хөгжлийн бодлого 69 хувьтай, нийслэл ба бүс нутгийн хөгжлийн бодлого 84.5 хувийн хэрэгжилттэй байна.

Хэдийгээр цар тахал, дайн, улс орнуудын өмнө тулгамдаад байгаа инфляц зэрэг хүндрэлүүд байсан хэдий ч 2022 оны 1 дүгээр улиралд хасах 3.8 хувьд хүрч унаад байсан эдийн засаг 2022 оны эцэст 4.8 хувийн өсөлттэй гарсан.

Монгол Улсын Засгийн газраас экспортыг эргэн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны эхний хагаст 8.1 сая тонн буюу өмнөх оноос 12.7 хувиар агшаад байсан нүүрсний экспорт 2022 оны эцэст 31.6 сая тоннд хүрч, 2021 оноос даруй 2 дахин өссөн дүн гарч байна.

Зэсийн баяжмалын хувьд 1.4 сая тонныг экспортолж өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар өссөн. Ингэснээр өссөн дүнтэй байна. Ингэснээр АМНАТ-ын орлого 2.7 их наяд төгрөг, уул уурхайн орлого 4.1 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 750 орчим тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарсан.

Засгийн газраас 2022 оны 10 дугаар сард гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах арга хэмжээний тухай 362 дугаар тогтоол гаргаж хэрэгжүүлсэн нь гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэхэд нөлөөлж улмаар Эрдэнэс Тавантолгой ТӨК, Эрдэнэт үйлдвэр, Монголросцветмет, Дарханы төмөрлөгийн үйлдвэрүүд болон Оюутолгой нийт 1.1 тэрбум америк долларыг улсад төвлөрүүлж, 2022 оны эцэст валютын нөөц 3.4 тэрбум ам долларт хүрээд байна.

Та бүхэнд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл,

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тараасан.

Байнгын хорооны хурал дахь салбарын сайд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нар ирж оролцож байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Хүрэлбаатар Шадар сайдад баярлалаа. Одоо Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд хийсэн аудитын тайлангийн танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Занданбат хийнэ. 4 дүгээр номерын микрофон өгөөрэй. Занданбат даргад микрофон өгье.

Д.Занданбат: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1-д заасан төрийн аудитын байгууллагын чиг үүрэг, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд аудит гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмжийг гаргалаа.

Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг 6 бүлэг, 23 зорилго бүхий 300 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 11.7 их наяд төгрөгийн хөрөнгө шаардлагатай байхаар баталж, гүйцэтгэлээр богино хугацааны зорилго, зорилт, төсөл арга хэмжээний хэрэгжүүлэхэд нийт 3.8 их наяд төгрөгийг зарцуулсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний зорилго, зорилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг үнэлэхэд 82 буюу 27. хувь нь үр дүнтэй, 71 буюу 23.7 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 88 буюу 29.3 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 59 буюу 19.7 хувь нь үр дүнгүй, зорилтот шалгуур үзүүлэлт хүрэх түвшнийг хангаагүй байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнгийн дундаж үнэлгээ 60.1 хувьтай байгааг бодлогын зорилт тус бүрийн үнэлгээ дараах байдалтай байна. Үүнд:

КОВИД-19 Халдварт цар тахлаас үүдэлтэй Эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого 98 хувьтай, Хүний хөгжлийн бодлого 65.хувь, Эдийн засгийн бодлого 51.2 хувь, Засаглалын бодлого 60.5. хувь, Ногоон хөгжлийн бодлого 49.5 хувь, нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого 83.5 хувийн тус тус хэрэгжилттэй байна.

Аудитаар цуглуулсан нотлох зүйлс аудитын дүнд үндэслэн дараах гол дүгнэлтийг гаргаж байна.

1.Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт 5 жилийн хүрэх түвшинээр батлагдсан нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т заасны дагуу төсөл, арга хэмжээ тус бүрийг хувиар харьцуулан үнэлж, дүгнэх боломжгүй байна.

2.Засгийн газрын 2020-24 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 285 төсөл, арга хэмжээг уялдуулан боловсруулж, харин 15 төсөл, арга хэмжээ буюу Хүний хөгжлийн бодлогын 6, Эдийн засгийн бодлогын 8, Нийслэл ба бүс нутаг, бүс, орон нутгийн

хөгжлийн бодлогын төсөл, арга хэмжээг тус тус уялдуулаагүй байна.

3.Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд туссан зарим төсөл, арга хэмжээ нь хэрэгжээгүй нь Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд санхүүжих эх үүсвэрийг тусгаагүй, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуультай нийцүүлээгүй байна.

4.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журамгүй, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг шинэчлэн батлаагүйгээс Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хөгжлийн урт, дунд, богино хугацааны болон салбар, бүс, орон нутагт мөрдөж буй бодлогын баримт бичгийн бүртгэл, мэдээллийг нэгтгэх, бодлогын уялдааг ханган төлөвлөлт хийх, хэрэгжилт, үр дүнг нэгтгэх, түүнд хяналт тавих нөхцөл бүрдээгүй байна.

5.Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулахдаа зарим төсөл, арга хэмжээний суурь түвшин, зорилтот түвшнийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүй, богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн тайлагнал, хэрэгжилтийн хүртсэн түвшний талаарх мэдээллийн үнэн зөв эсэхийг нягтлан шалгах, хяналт хангалтгүй, шат шатын хяналт, шинжилгээ үнэлгээг нотолгоонд үндэслэж хийгээгүйгээс бодит үнэлгээ болоогүй байна.

6.Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн урьдчилсан тооцоолол судалгаа хийгдээгүй, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулаагүй зэрэг хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгасан

нь бодлогын зорилго, зорилт, хүрэх үр дүн, биелэх нөхцөлийг бууруулж байна.

Мөн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Улсын Их Хуралд 1 асуудал, нийт 13 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд өгсөн байна.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдад 5, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад 3, Сангийн сайдад 1, Үндэсний статистикийн хороонд 2, төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2 зөвлөмжийг тус тус өгсөн байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Занданбат даргад баярлалаа. Одоо танилцуулгуудтай холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрээ өгье. Доржханд гишүүнээр тасаллаа. Булгантуяа сайд асуулт асууя. Танай тайланг хэлэлцэж байгаа шүү дээ уг нь.

Х.Булгантуяа: Би зүгээр энэ жилийн гүйцэтгэл дээр ямар нэгэн шинэ аргачлал бас ашигласан уу гэдэг ийм асуултыг тавих гэсэн юм. Яагаад гэвэл бидний зүгээс зарим юунууд дээр жишээлбэл Тавантолгойн 450 мегаваттын цахилгаан станцын дэд бүтэц, станц холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх гээд тэгэхэд эхлээгүй байгаа гэсэн мөртөө 66.6 хувьтай энэ тэр гээд тавьчихсан байх юм. Тэгээд бид нар өмнө нь ярьж байсан гол асуудлууд нь энэ хэрэгжилтийн үнэлэлт дээр бид нар арай л өөр ажилламаар байна гэж өмнө нь ярьж байсан. Тэгээд үүн дээр шинэ аргачлалыг бид нар ашигласан уу? Төлөвлөлт дээр нь сайжирсан юм байна. Тэгээд аудитын зүгээс энэ аргачлалын шинэчлэл хийгдсэн үү гэдэг энэ асуултуудыг асуух гэсэн юм.

Н.Энхболд: Занданбат дарга 4 номер, 5 номер. Хариулж байгаа хүмүүс нэр, албан тушаалаа хэлээд яваарай.

Д.Энхболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал Энхболд байна. Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын үнэлгээгээр Тавантолгой 450 мегаваттын цахилгаан станц холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх гэдэг ажлын хувьд бол Үндэсний аудитын газраас энийг бол хэрэгжилт хангалтгүй буюу 0 гэж үнэлсэн байгаа. 66 хувийн үнэлгээ манайхаас өгөөгүй байгаа.

Аудитыг гүйцэтгэх аргачлалын хувьд бол хэрэгжилтийг гаргахдаа Засгийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээний аргачлалын зөрөөг гаргахгүйн тулд суурь болгоод, аудитын аргачлалын стандартын дагуу нотлох баримтад үндэслэн хүрэх түвшнийг тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг одоогийн хүрсэн түвшинтэй харьцуулж хэрэгжилтийг гаргасан байгаа. Энэ дээр төлөвлөгөөний хэрэгжилтийг тусгайлсан аргачлалыг Үндэсний аудитын газраас гаргаагүй байгаа.

Н.Энхболд: Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Би нэг л асуулт асуух гэсэн юм даа. Энэ эрчим хүчтэй холбоотой л асуулт асуух гээд байгаа юм л даа. Эрчим хүчний суурилагдсан хүчин чадлаараа 100 хувийн үр дүнтэй ажилласан гээд. Тэгээд импортын эрчим хүч гээд 30 хувийн үр дүнгүй гээд. Тэгээд энэ юу гэж энийгээ үр дүнгүй гээд 30 хувь гээд тавьчихсан байгаа байхгүй юу. Юу гэж ойлгох юм? Бага импортолсон гэж үзэж байгаа юм уу, аль эсвэл импортолж болохгүй байсан юмыг импортолчихсон гэж үзэж байгаа юм уу?

Ер нь сая өнгөрсөн энэ КОВИД-ын 2 жилийн хугацаанд бид нар яг эрчим хүчний дутагдал, дулааны дутагдал гэдгийг нэлээн сайн ойлгохуйц л хэмжээнд л хүрсэн байх гэж би найдаад байгаа юм л даа. Тэгээд яг энэ 22 онд яг эрчим хүчний

дутагдлыг арилгах чиглэл дээр яг ямар ажил хийгдсэн гэдгийг тодорхой мэдээлэл авчихмаар байна. Энэ шинэ үйлдвэр барина гэхээр л ер нь эрчим хүчний асуудал үүсдэг. Одоо бараг шинэ том хот, томоохон хэмжээний хотхон барихад хүртэл эрчим хүч, дулааны асуудал үүсэхээр байгаа байхгүй юу. Одоо яг аялал жуулчлалын хууль гээд ороод ирчихсэн байдаг. Тэгээд тэн дээр чинь одоо казино эд нар гээд л яах вэ нэлээн том эрчим хүч, дулааны хангамж шаардлагатай байдаг. Тэгээд энэ дээр бэлтгэл ажил ер нь хангагдсан байдаг юм уу? Хангагдаагүй байдаг юм уу? Энэ тал дээр мэдээлэл авчихмаар байна.

Н.Энхболд: Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ерэн-Өлзий 1 номерын микрофон ажлын хэсэг дээр.

Б.Ерэн-Өлзий: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний Бодлого төлөвлөлтийн газрын даргыг эргэн хэлэлцье. Өнгөрсөн онд гол дулааны цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн нөөц бүрдүүлэлт чиглэлд хийгдэж байгаа гол ажлууд

Н.Энхболд: Жоохон чанга яриарай Ерэн-Өлзий.

Б.Ерэн-Өлзий: Гол ажлууд Улаанбаатар хотод Амгалангийн Дулааны цахилгаан станцыг 100 мегаваттын 3 зуухтай хотын зүүн хэсгийг авч явж байгаа ийм 100 станц байгаа. Энийг яг ижил нэг зуухаар өргөтгөх ажлыг барилга угсралтын ажлыг эхлүүлээд байгаа. Дулааны цахилгаан станц.

Н.Энхболд: Жоохон тод микрофондоо ойрхон шиг ярь. Наад яриа чинь дуулдахгүй байна. Ерэн-Өлзий дарга.

Б.Ерэн-Өлзий: Дулааны цахилгаан станц-III-ын дэд бүтцийг ашиглан суурилагдсан хүчин чадлыг өргөтгөх 250 мегаваттын шинэ станцаар өргөтгөх

ажлыг Оросын Холбооны Улсын техникийн зээлээр хэрэгжүүлэх хүрээнд Оросын холбогдох байгууллагуудтай хэлцэл хийж ингэж ажиллаж байгаа.

Орон нутгийн дулаан хангамжийн хувьд одоо 10 аймгийн дулааны станц өөрөөр хэлбэл төвлөрсөн дулаан хангамжийн системгүй үлдсэн 10 аймагт шинэ дулааны станц барих ажлын 9 аймагт нь барилга угсралтын ажил эхэлсэн. Өнгөрсөн оноос суурийн ажлууд хийгдсэн. Энэ ондоо яг үндсэн тоног төхөөрөмжийг татах ийм ажлууд хийгдэж байна.

Н.Энхболд: Тодруулах уу? Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Тайлан хэлэлцэж байгаа болохоор хаашаа юм, ирээдүйн төлөвлөгөөг чинь асуухад бас хаашаа ч юм. Гэхдээ энэ өнгөрсөн хугацаанд би бас нөгөө энэ ирээдүйн энэ эрчим хүчнийхээ дутагдлыг нөхөх энэ ТЭЗҮ эд нарыг хийсэн байдаг юм уу гэдэг л асуултын хариултыг сонсох гэж л оролдсон юм л даа. Тэгээд яриа чинь ерөөсөө сонсогдохгүй байна. Өнөөдөр нүүрсний цахилгаан станцад олон улсын банк санхүүгийн байгууллагууд санхүүжилт гаргахаа больчихсон байгаа шүү дээ.

Ер нь цаашийн хэтийн төлөвлөгөө яг юу байгаа юм бэ? Тэгээд тэрэндээ энэ чинь та нар ТЭЗҮ бэлдэж барьдаггүй юм уу? Энэ чинь энэ ажлын хийсэн тайлан чинь ордоггүй юм уу л гэдэг л асуулт байгаад байгаа юм л даа. Тэгээд дараагийн манай эрчим хүч болон дулааны эх үүсвэр юу байх юм бэ? Нүүрс гэдэг нь санхүүжилт байхгүй. Нэг бол одоо нүүрсний цахилгаан станц барина гэх юм бол 100 хувийн бэлэн мөнгөөр л барих асуудал байгаа байхгүй юу. 100 хувийн бэлэн мөнгөөр шийдэж чадахгүй юм бол өөр алтернатив.../үг тасрав./

Н.Энхболд: 1 номерын микрофон. Наад микрофондоо ойрхон шиг суугаад

чангахан хариулахгүй бол дуулдахгүй байна шүү.

Б.Ерэн-Өлзий: Дэлхийн улс орнууд ногоон эрчим хүчний шийдэл рүү бодлого гараад ингээд шилжсэн ийм шилжилтийн үед байна. Монгол Улсын тухайд бол өөрийн гэсэн онцлог байгаа юм. Яагаад гэвэл -40 градус хүрч хүйтэрдэг, жилийн 12 сарын 9 сард нь дулаан хангамж шаарддаг ийм онцлогтой.

Дунд хугацаандаа бол хот суурин газрын дулаан хангамжийн шийдэл бол нүүрс л байна. Өөр одоо санхүү эдийн засгийн үр ашгийн хувьд сонголт байхгүй. Гэхдээ алсдаа юу гэдэг юм нүүрсний хүлэмжийн хийн үйлдвэрлэлийн татвар нэмэгдэж байгаа. Санхүүжилт дэлхийн банк санхүүгийн байгууллага энэ чиглэлд бол санхүүжилтийг хориглож байгаатай холбогдуулан дараагийн хувилбарууд нь газрын гүний дулаан гэсэн энэ чиглэл, нар салхины эрчим хүчний эх үүсвэрийг цахилгаан.../минут дуусав./

Н.Энхболд: Гишүүд 2 дахин тодруулга гаргах эрхтэй байгаа шүү. Хангалтгүй бол. Яах юм. Ганхуяг гишүүн. Ганхуяг гишүүн яах вэ?

Х.Ганхуяг: Хариулт тодорхойгүй болон хариулт хангалтгүй байгаа болохоор тодруулаад байгаа юм би. Тэгээд яагаад тодруулаад байна гэхээр 2022 оны байдлаар яг эрчим хүчний систем бол 80 гаруй тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаад, тэгээд дараагийн алтернатив вариант нь ногоон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг л яриад байна л даа. Тэгээд тэр нь болохоор ашигтай ажиллаад байгаа юм.

Манай эрчим хүчний сэргээгдэх эрчим хүчний хууль нь, тариф нь асар өндөр үнэтэй байдаг тэгээд тэрнийхээ зохицуулалтаа ерөөсөө хийдэггүй. Тэгээд ингээд яриаг нь сонсвол ирээдүйн төлөвлөлтөө ерөөсөө хийхгүй байна л гэж надаа сонсогдож л байна л даа. Энэ чинь өнгөрсөн хугацаанд ядаж шинэ

цахилгаан станцаа эхлүүлдэггүй юм бол энэ чинь тооцоо судалгаагаа, ТЭЗҮ хийгээд бэлэн болчихсон. Яг миний асуултад хариулж л байх ёстой л доо. Нүүрсний эрчим хүчээ шийдэж чаддаггүй юм энэ чинь дараа нь юу байх вэ л гэдэг асуудал шүү дээ. Энэ дээр ямар шийдэл байгаа юм бэ л гэдэг л асуултыг асуугаад байгаа юм л даа.

Н.Энхболд: Хамгийн ойрхон барихаар төлөвлөж байгаа цахилгаан станцуудынх дулааны станцынхаа талаар төлөвлөж бодсон юм байвал тэрийг л товчхон хэлчхээч. 1 номерын микрофон.

Б.Ерэн-Өлзий: Одоо Чойбалсангийн Дулааны цахилгаан станцын 50 мегаваттын өргөтгөл хийгдэж байна. Бөөрөлжүүтийн цахилгаан станцын барилга угсралт эхэлчихсэн байна. Шинээр төлөвлөж байгаа нүүрсний эх үүсвэр гэвэл дагуул хотуудыг түшиглээд дунд хугацаанд дулааны станц, урт хугацаанд дулаан цахилгаан хослон үйлдвэрлэх томоохон эх үүсвэр барина гээд ТЭЗҮ нь гарчихсан. Өмнөд бүсэд бол Тавантолгойн дулааны цахилгаан станцын тендерийг дахин судалж байж зарлах ийм ажил хийгдэж байна. Эхлүүлчихсэн төслүүд. Тийм. Бөөрөлжүүтийнх болохоор хувийн хэвшлийн санхүүжилтээр явж байна. Дорнодын станцынх болохоор Хятадын Хөгжлийн банкны санхүүжилтээр.../минут дуусав./

Н.Энхболд: Ганибал гишүүний микрофоныг өгье.

Н.Ганибал: Энэ бид хэд Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт хүртэл оруулчхаад байгаад энэ хөгжлийн төлөвлөгөө Засгийн газар жил болгон Улсын Их Хурлаар оруулаад, түүнийгээ тайлагнуулаад, гүйцэтгэлийг нь хянуулаад, ер нь бид нар аливаа асуудлыг хуульд оруулахдаа олон сайхан юм ярьдаг л даа. Ийм төлөвлөгөө оруулаад ирэх юм бол энэ төлөвлөгөөнийхөө дагуу улс орон

явбал төр засаг энэ ажлаа хийх юм бол тэгээд Монгол Улс үсрэнгүй хөгжинө гээд л. Тухайн үед ярьж байсан үгийг нь би зүгээр төсөөлүүлээд хэлчихье. Харамсалтай нь яг энэ өнгөрсөн жил энэ Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг баталж байх үед шалтаг бол Эдийн засгийн яам байгаагүй. Тухайн үед Засгийн газар оруулж ирэхэд ийм олон дарга нар ч байгаагүй. Тэгээд хэдхэн зүйл, заалттай өөрсдийнхөө өдөр тутам хийдэг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон бүх л асуудлуудаа оруулж ирээд ингээд батлуулсан. Тэгээд харамсалтай нь гүйцэтгэлийн хэрэгжилт 60.1 хувьтай л гээд байна. Эргээд сайн шахах юм бол энэ бараг 50 хүрэхгүй л байгаа л даа.

Тэгээд Их Хурал хөгжлийн энэ төлөвлөгөө гэдэг юмыг батлаад Засгийн газар түүнийг нь хэрэгжүүлдэггүй. Тэгээд бид нар энийг хэлэлцэх нь ч шаардлага байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Тэгээд дараагийн хөгжлийн төлөвлөгөөг үнэхээр жилийн төлөвлөгөө юм бол тэр жилдээ хийгдэж болох боломжтой. Тэгээд энэ өөрөө эдийн засгийнхаа хувьд томоохон үр ашгуудыг өгч болдог. Гол нь бид батлаад өгөнгүүт Засгийн газар нь түүнийг хэрэгжүүлдэг байх юм бол бид нар энэ Үндсэн хуулийнхаа энэ заалтын дагуу бас эрх үүргээ биелүүлээд явах нь зөв байх л даа. Тэгээд энэ дээр зүгээр нэг жишээ хэлчих.

Дарханы арьс ширний үйлдвэр паркийг барьж байгуулна гээд ингээд оруулчихсан. Тэгээд харамсалтай нь Засгийн газар нь бүтэн жил энд ямар нэгэн асуудалд нь оролцоогүй. Энэ өөрөө ингээд зогсонги байдалд орчихсон шүү дээ. Энэ чинь 0 хувь байгаа байхгүй юу. Ганц хийгдсэн юм бол аягүй бол аудит тэн дээр дүгнэлтээ гаргаж гаргасан гэж сонссон. Тэгээд түүнийх нь дагуу цаашир нь Засгийн газар нь хэрэгжүүлээд явах ийм боломж байдаг юм уу, үгүй юм уу мэдэхгүй байна.

Хоёр дахь асуудал энэ дээр хамгийн их ямар ч эхлээгүй ажил нь энэ эрүүл мэндийн салбарын асуудал байна л даа. Уг нь сая Эрүүл мэндийн сайд байж байсан. Хамгийн олон. Гэхдээ энэ эдийн засаг хөгжилтэй холбоотойгоор хийгдэх асуудлууд гээд. Тэгээд энэ нь ер нь сүүлийн үед орон нутгаас манай сонгогч нараас 2 хүсэлт л байнга ирж байгаа.

Нэг нь Улаанбаатар хотод эмнэлэгт хэвтэхэд минь тусалж өгөөч гээд.

Хоёр дахь нь манай хүүхдийг Солонгос руу явуулж өгөөч энэ дээр дэмжиж өгөөч гээд. Энэ бол бид бүхэн дээр ирж байгаа сонгогчдоос, иргэдээс ирж байгаа хамгийн 2 том хүсэлт. Эрүүл мэндийнх нь сайд нь орон нутгийнхаа эмнэлгүүдийг улс төрийн учир шалтгаар юм уу, ямар байдлаар юм, хамгийн муухай болохгүй, бүтэхгүй гэдгийг нь хамгийн чангаар хэлдэг. Алдаа дутагдлыг нь.

Тэгээд буцаагаад түүнийгээ засаж залруулах ажлаа хийдэггүй. Өнөөдөр манай Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг дэх сувилагч нар маань ажлаасаа гарах өргөдлийг олноороо өгч байгаа юм. Цалин муу, дээрээс нь дарамт их. Ийм л асуудлууд байна л даа. Тэгээд энэ болгоныг эцэст нь тодруулаад хэлэхэд ер нь Эдийн засгийн яамтай болсон. Энэ салбарын яамнууд тухайн салбарын бодлогыг л гаргаж байгаа байх. Энэ хүмүүс эд нараас, яамнуудаас энэ тендер зарладаг, байшин барилга барьдаг энэ асуудлуудыг нь татаж аваад.../минут дуусав./

Н.Энхболд: Дарханы хөдөө аж ахуй түүхий эд боловсруулах үйлдвэртэй холбоотой асуудлаар хэн хариулах вэ? Хүнс, хөдөө аж ахуйн яам, Хүрэлээ сайд хариулах уу? Хүнс, хөдөө аж ахуйн яам хариулах уу? Жамбалцэрэн Төрийн нарийн бичгийн дарга. 7 дугаар микрофон өгөөрэй.

Т.Жамбалцэрэн: Ганибал гишүүний асуултад хариулъя. Дарханы арьс ширний цогцолбор үйлдвэр байгуулах ажил ТЭЗҮ нь хийгдчихсэн, тоног төхөөрөмжийн судалгаа сонголтууд нь хийгдчихсэн байж байгаа. Дээр нь хувийн хэвшил бүтээн байгуулалтын ажил хийж байгаатай холбоотой Эрчим хүчний сайд, Барилга, хот байгуулалтын яамны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар ажлын хэсэг гарчихсан. Хувийн хэвшлийн хийж байгаа бүтээн байгуулалт дээр тодруулга хийж байгаа. Энэнтэй холбоотой хувийн хэвшлийн хийсэн бүтээн байгуулалтын ажлыг ТӨК-тай нийлүүлэх суурь дэд бүтцийн ажлуудыг нь шилжүүлж авах ажлууд хийгдээд явж байгаа.

Н.Энхболд: Хэзээ ер нь ашиглалтад орно гэж тооцож байгаа юм та нар?

Т.Жамбалцэрэн: Энэ өөрөө хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хийсэн ажлууд нь өөрөө хууль хяналтын байгууллага дээр шалгагдаж байгаа. Дээр нь Хөгжлийн банкин дээр бас нэлээд асуудалтай байгаа учраас энэ ажлаас болоод жоохон хүлээгдэж байгаа. Ямар ч байсан энэ ондоо багтаад ажлыг нь эхлүүлээд явна гэсэн юм.

Т.Жамбалцэрэн: Тодруулах уу Ганибал гишүүн? Ганибал гишүүн.

Н.Ганибал: Ер нь тэгээд эдийн засгийн яамтай болсон. Тэгээд Хүрлээ сайдаа ер нь энэ салбар салбараар нь асуудлуудыг нь яг үнэхээр тэр хөгжлийнх нь зураглалуудыг нь гаргаж өгөхгүй бол нөгөө олон жилийн ингээд явсан. Одоо энэ тайлан хийдэг, яамнууд дээр чинь үндсэн чиглэлийг хариуцсан нэг мэргэжилтэн, үйл ажиллагааг хариуцсан нэг мэргэжилтэн. Аягүй бол одоо энэ хөгжлийн төлөвлөгөө хариуцсан нэг мэргэжилтэнтэй байгаа шүү. Би мэдэхгүй байна. Тэгэхдээ бараг багцаалдаж байна. Тэгээд энэ Төрийн нарийнууд бүгдээрээ сууж байна.

Хувийн хэвшилээ дэмжсэн тэр хувийн хэвшилүүдийн хийх боломжийг нь хангасан магадгүй төр хариуцсан тодорхой ажлууд дээрээ хариуцлагаа хүлээнэ биз. Ер нь эдийн засгийнх нь үр өгөөжтэй байлгах тал дээр эрүүл мэнд, хөдөө аж ахуй бүгд, бүгдээрээ эдийн засгийн үр өгөөжтэй л байх ёстой. Ингэж байж л цаашаа явна гэдгийг бас хэлье.

Н.Энхболд: Санал шахуу юм даа. Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ дэгийнхээ хуульд өөрчлөлт оруулж энийг жоохон үр дүнтэй хэлэлцэх талаас нь анхаармаар юм шиг байна. Энэ ингэж бас тийм халтуур маягтай ингэж явж болохгүй л дээ. Алдаа энэ тэрээ бол сайн харж, дүгнэлт хийх ёстой гэж бодож байгаа юм.

22 оны төлөвлөгөөний биелэлт 67.5 хувьтай, 300 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс 22 арга хэмжээ нь байхгүй гэж байгаа юм. Тасарсан гэж. 300 төсөл, арга хэмжээг 11.7 их наяд төгрөгөөр санхүүжүүлнэ гэсэн чинь 4.1 их наяд төгрөгөөр нь 35 хувийг л санхүүжүүлсэн юм байна л даа. Төсвийн орлого давж биелж байгаа шүү дээ. Яагаад ингэхэв, юунаас болов? КОВИД-ын аюул чинь жоохон холдчихсон байна шүү дээ. Энэ 2022 онд чинь юунаас болж байгаа юм? Энд хариулт өгөөч нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь энэ 2020-24 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлт 39 хувьтай явж байгаа юм байна л даа. 1087 арга, хэмжээ төлөвлөснөөс 153 төсөл арга хэмжээ нь тасарсан гэж байгаа юм. Энэ дотор нөгөө эрхтэн суулгах, шилжүүлэн суулгах төвийн ажил таг байгаа юм байна. Сүрьеэгийн эмнэлэг байгуулна гэсэн таг байгаа юм байна. Шинжлэх ухаан, технологийн зардлыг 4 дахин нэмэгдүүлнэ гэсэн байхгүй байгаа юм байна. Асгатын ордыг ашиглах гээд ингээд байхгүй. Барилгын хавтгай шилний

үйлдвэрийг ашиглалтад оруулна гэсэн байхгүй. Энэ юу юунаас болоод ингэж байна? Энэ үлдэж байгаа хугацаанд хийх боломж байгаа юм уу гэсэн ийм хоёр дахь асуулт байна.

Гурав дахь асуудал Монгол Улсад яг миний ойлгож байгаагаар 2 хөгжлийн их том баримт бичиг байгаа гэж ойлгож байгаа. Нэгдүгээрт нь бол энэ Нэгдсэн Үндэстний байгууллагаар дэмжигдэж загвар нь гарсан. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 гэж баримт байгаа. Хоёр дахь нь бол “Алсын хараа-2050” гэж байгаа. Энэ Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 бол би хүчингүй болоогүй гэж би сонсоогүй. Энд бол 2030 он гэхэд 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 17500 болно гэж байгаа юм. Энэ үлдэж байгаа энэ хугацаанд эдийн засгийн өсөлт хэд хүрч байж энэ 17.5 мянга хүрэх вэ? Монгол хүний дундаж наслалт 78 хүрнэ гээд энэ төлөвлөгөөнд заачхаж. Энэ юу болж байгаа вэ? Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт 30 болно гэж байгаа юм. Оноо нь 30 болно гэсэн энэ юу болж байгаа вэ? Цөлжсөн газар нутгийн хэмжээ 78-аас 68 болгож багасгана гэж байгаа юм. Энэ юу болж байгаа вэ гэх мэтээр. Энэ хөгжлийн үзэл баримтлалын энэ үзүүлэлтүүд маань энэ юу болж байна? Үүний дараагаар 2050 гээд гарчихсан.

Тэгээд бид нар ингээд төлөвлөгөө хийгээд хаяад байдаг, хаяад байдаг оновчтой, оновчгүй. Энэ тэр одоо бол энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр, энэ төлөвлөгөөнүүд ер нь хэр зэрэг тусаж явдаг юм бэ? Энэний биелэлтийг үздэг, хардаг, барьдаг янз бүрийн юмнууд байна уу? Ийм гурав дахь асуудал.

Дөрөв дэх нь бол энэ Санхүүгийн зохицуулах хорооноос хүн байна уу, үгүй юу? Санхүүгийн, өөрөөр хэлбэл банкны бус санхүүгийн салбарын хөрөнгийн үнэлгээ 25.7 хувь болсон гэж байгаа юм. Яах вэ тоон үзүүлэлт тийм байдаг байж. Эдийн засгийн өгөөж нь юу байгаа юм?

Татварт хэдэн төгрөг орсон байна? Монгол Улсын төсөвт хэдэн төгрөг орсон бэ? Ер нь цаашидаа ямар хандлагууд ямар байна вэ, 24 хоног хүртэл юу бодож байгаа вэ гэсэн дөрөв дэх асуудал.

Тав дахь асуудлын Зөвшөөрлийн хууль гээд гарсан. Энэ зөвшөөрлийн хуультай энэ Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа зөрчилдөж байна гэсэн ийм мэдээлэл надад хүн өгсөн л дөө. Тухайлбал, тэр мөнгө угаах, терроризмтой холбогдсон, энэ банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны зөвшөөрөл олгохтой холбогдсон ийм юм үнэхээр байна уу?

Н.Энхболд: Хүрэлбаатар сайдаас эхэлье эхний 3 асуултад нь. Дараа нь бэлдэж байгаарай 2 асуултад нь.

Ч.Хүрэлбаатар: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Жилийн төлөвлөгөө дээр суусан арга хэмжээнүүд зарим нь огт хэрэгжээгүй байна. Төсвийн орлого давж биелээд байгаа учраас энийг санхүүжүүлж болохгүй байсан уу гэдгийг эхний асуултад хариулъя.

Тэгээд сая аудитын дүгнэлт дээр ч гарсан. Яг жилийн төлөвлөгөө тусгагдсан арга хэмжээнүүд дараа 11 сарын 15-наас өмнө төсөв батлагдахдаа тэр арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх эх үүсвэрийг нь тавиагүй. Тийм учраас тэр арга хэмжээнүүд тухайлбал, хэд хэдэн эмнэлгийг бас урьд нь дурдагдаж байсан. Тэд нарыг санхүүжүүлэх тийм эх үүсвэр байхгүй гэдэг үүднээс тэр ажлууд ингээд огт хийгдээгүй гээд орхичихсон байгаа.

Тэгэхээр төсвийн орлого давж биеллээ ч гэсэн Засгийн газарт энийг өөрөө санхүүжүүлэе гээд мэдээд явчихдаг тийм эрх мэдэл байхгүй. Дандаа Улсын Их Хурлаар төсөвт сууж батлагдаж явдаг гэдгийг би энд хэлмээр байна.

Заримынх нь хувьд хэдийгээр төсвийн эх үүсвэр нь батлагдсан шийдэл

нь гарчихсан байлаа ч гэсэн бас хэрэгжээгүй зүйлүүд бий. Тухайлбал, түрүүн Эрчим хүчний яамныхан дэндүү хариуцлагагүй л хариулж байна лээ тэр Тавантолгойн цахилгаан станцын тендерийг 2 удаа зарлаад, оролцсон компани шалгаруулахгүй буцаагаад л байгаа юм байна лээ. Тэгээд дахиад шинээр зарлах гээд байдаг. Тийм үйл явц 22 оны турш яваад өнгөрчихсөн. Ийм юм байгаад байдаг.

Тэгэхээр эх үүсвэр нь байгаа, бүх юм нь, боломж нь байгаа ч гэсэн бас хэрэгжүүлэх дээрээ тендертэй нь холбоотой юм уу, яадаг юм тэр нь хэрэгжээгүй гэх мэтийн ийм зүйлүүд энэ дээр байгаад байгаа. Түрүүн Ганибал ч гишүүн ч гэсэн бас нэлээд ярьж байна. Эдийн засгийн хөгжлийн яам энэ жилийн жилийн төлөвлөгөө дээр нэлээд сайн анхааран сууж ажиллаж байгаа. Дараа нь энэ яамнуудыг яг тэр жилийн төлөвлөгөөгөө хийсэн үү, үгүй юу гэдгээр нь л эргэж бид нар хариуцлага тооцдог, ажлыг нь дүгнэдэг ийм тогтолцоо руу бүрэн хэмжээгээр хийж та бүгдэд энэ тараасан энэ материал бол ерөөсөө бүгдийг нь эргэж харж үзсэн ийм зүйл байгаа.

НҮБ-тэй хамтраад баталсан тэр 2020, 30 он тогтвортой хөгжил гэдэг энэ бодлогын баримт бичгүүд хүчинтэй хэвээрээ л байж байгаа. Үзүүлэлтүүд дотор байгаа зарим зүйл дээр ялангуяа энэ корона, дайнтай холбоотой энэ өнгөрсөн хөл хорио хорьсон цар тахалтай холбоотой 3 жилийн хугацаанд бас нэлээдгүй хэд хэдэн үзүүлэлтүүд хойшоо суусан зүйлүүд байгаа гэдгийг хэлье. Тэгээд ажлын хэсгээс тодруулаад хариулаарай.

Н.Энхболд: Хэн нэмэх юм? Баасандорж дарга 3 номер.

Б.Баасандорж: Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Баасандорж. Баттөмөр гишүүний зарим асуултад хариулъя. Манай зарим асуулт нь байгаль

орчны чиглэлийн асуулт асуусан байна. Тэрэнд дараа нь нэмж хариулах байх хуралдаан даргалагч зөвшөөрвөл.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой асуусан. Үйл ажиллагааны хөтөлбөр 39.2 хувьтай байна. Энэ үлдсэн жилүүдэд энийгээ хийж амжих уу гэж гишүүн асуусан. Үйл ажиллагааны хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх ажлыг 60.8 хувиар үнэлж Их Хуралд мэдүүлсэн байгаа.

39.2 бол 2020 оны 8 сарын 2-нд батлагдсан үйл ажиллагааны хөтөлбөр өнөөдрийг хүртэл хэрэгжихэд Засгийн газар 39.2 хувьтай байна. Гэхдээ бас харьцангуй бага хувьтай байна. Үлдсэн жилүүдэд энийгээ яг хүрэх түвшиндээ хүргээд хийхээр төлөвлөж байгаа.

22 оны төлөвлөлт бол 60.8 хувьтай байгаа. Нийт 1087 арга хэмжээнээс 131 арга хэмжээтэй холбогдуулж гишүүн асуусан. Үүний хүчин зүйлүүд гэвэл янз янзын хүчин зүйлүүд байна л даа. Нэгт төлөвлөлттэй холбоотой асуудал байна.

Хоёрт нь яг өнгөрсөн цаг хугацаанд нөгөө төрийн хэмнэлтийн тухай хууль, санхүүгийн санхүүжилтийн эх үүсвэртэй холбоотой гэдэг юм уу, КОВИД-ын нөхцөл байдалтай холбоотой гэдэг юм уу тийм хүчин зүйлүүд байна. Бас зарим зарим нь ажлууд дээр үнэхээр салбарынхан бас арай цаг хугацаанаас болоод харьцангуй гүйцээж ажил ажиллаж амжаагүй тийм хүчин зүйлүүд байна. Янз янзын хүчин зүйлүүдээс болж энэ 131 арга хэмжээн дээр асуудал үүссэн гэж хэлье.

Тогтвортой хөгжил 2020, 30 бол өнөөдрийн байдлаар хүчингүй болсон. 2020 оны 5 дугаар сарын 3-нд “Алсын хараа 2050” бодлогын баримт бичиг батлагдахад энэ баримт бичиг дагаад хүчингүй болсон байгаа гэдгийг хэлье.

Тэр зөвшөөрлийн хуультай холбоотой Санхүүгийн зохицуулах хороотой зөрчилдөж байгаа зүйлүүдийг Баттөмөр гишүүн ээ яг Санхүүгийн зохицуулах хороотой энэ асуудлаар яг тухайлан яг нарийвчилсан мэдээллийг аваад танд эргэж танилцуулъя гэдгийг хэлье. Байгаль орчны яамнаас нэмж хариулах уу?

Н.Энхболд: 1 номерын микрофон Цогтгэрэл.

С.Цогтгэрэл: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Цогтгэрэл. Баттөмөр гишүүний асуусан асуултад хариулъя. Цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, цөлжилтийг бууруулах чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын яаман дээр бол нэлээдгүй олон ажлууд хийгдэж байгаа.

Хөрсний үржил шим, чийгийг хамгаалах, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэх, эвдрэлд орсон доройтсон газрыг нөхөн сэргээж аж ахуйн эргэлтэд оруулна гэсэн ийм зорилт арга хэмжээний хүрээнд хөрсний үржил шим, чийгийг хамгаалах, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэх, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээх зорилгоор цөлжилтөд нэн хүчтэй дунд зэрэг өртсөн Дундговь, Дорноговь, Өвөрхангай, Баянхонгор аймагт цөлжилт, газрын доройтол бууруулах, элсний нүүдлийг сааруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 22 оны А233 дугаар тушаалаар 32 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулахад зориулан 370.1 сая төгрөгөөр бол ажил хийсэн байна.

Дорноговь, Дундговь, Өвөрхангай аймагт бол Дундговь аймагт 8 га, Дорноговь аймагт 6 га, Өвөрхангай аймагт 8 га, Баянхонгор аймагт 5 га талбайд цөлжилтийг сааруулах, хамгаалах арга хэмжээнд нийт тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж ажлууд хийгдсэн байна.

Мөн цөлжилтийг бууруулахад гол бас хийж байгаа ажлуудын нэг бол “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэж байгаа ажлууд байгаа. Одоогийн байдлаар бол 39 төрлийн мод, сөөгийн 121 тонн үрийн нөөц бид нар бүрдүүлээд байна. Энэ нь бол өмнөх онтой харьцуулахад 4.5 дахин өссөн ийм үзүүлэлт байгаа.

Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 11.7 сая мод тарьж, арчилгаа ургах энэ ажлыг нь хийж байна. Ийм хариулт өгье.

Н.Энхболд: Тэр Санхүүгийн зохицуулах хороотой бусад байгууллагууд Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам үйл ажиллагаагаа яаж зохицуулж, уялдуулж байна гэдэг талаар бас гишүүн асуулт тавьсан. Тэнд хэн хариулах уу? Ганбаатар дарга хариулах уу? Зохицуулах Хорооноос хүн байхгүй байх шиг байна. Байна уу? Хэн бэ? Хууль зүйн яам 7 номерын микрофон.

П.Сайнзориг: Асуултад хариулъя. Баттөмөр гишүүний асуултад Санхүүгийн зохицуулах хороо ерөнхийдөө Засгийн газрын байгууллагуудтай бас олон салбарт бас хамтрах зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа.

Ер нь сүүлийн үед бас мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх, энэ үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотойгоор бас Санхүүгийн зохицуулах хорооны бас чиг үүрэг нэлээн нэмэгдсэн байж байгаа. Энэнтэй холбоотойгоор бас Санхүүгийн зохицуулах хороо маань бас орон нутагт ерөнхийдөө бас хүний нөөцийн хомсдолтой буюу салбар байхгүйгээс шалтгаалж бас зарим энэ хууль тогтоомжийн бас хяналт хэрэгжилтийн асуудал дээр бас нэлээдгүй асуудлууд гарч байгаа.

Ер нь хууль, эрх зүйн шинэчлэлийн хувьд бид бас хоорондоо ярилцаад

тодорхой зүйлүүдийг хамтраад ингээд боловсруулаад явдаг. Яг Зөвшөөрлийн тухай хуулийн асуудал дээр Санхүүгийн зохицуулах хорооноос тодорхой ажлын хэсэгт санал өгсөн боловч тэрийг нь бас Зөвшөөрлийн тухай хуульд тусгасангүй гэдэг мэдээллийг бас манай яаманд ирүүлсэн.

Бид судлаад шаардлагатай, үнэхээр зайлигүй шаардлагатай зохицуулалтууд байвал Зөвшөөрлийн хуульд нэмж оруулах ийм ажиллагааг бас Хууль тогтоомжийн тухай хуульд заасан процессын дагуу эхлүүлэх энэ чиглэлд хамтарч ажиллахаар төлөвлөж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье.

Ер нь зүгээр мөнгө угаах энэ санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд нэлээдгүй ажиллаж байна. Энэ койны асуудал буюу энэ криптовалютаар холбоотой асуудал, сүүлд бас Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль гэж батлагдсан. Энэ тогтвортойгоор ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг мөнгө зээлдэг хүмүүс болон ломбардуудын үйл ажиллагаанд бас хяналт тавих, бүртгэлжүүлэх энэ асуудал дээр бас Санхүүгийн зохицуулах хороо ерөнхийдөө Засгийн газрын байгууллагуудтай бас хамтраад ингээд явж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье.

Н.Энхболд: Тодруулах уу? Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ чуулганы хуралдаанд энэ Санхүүгийн зохицуулах хорооны энэ дарга нарыг байлгаарай. Банкны бус салбарын гол үйл ажиллагаа энд явж байгаа шүү дээ. Бид чинь ингээд эндээ урьж оролцуулдаггүй, дуудлага өгдөггүй энэ нь ингээд гадаа энд улс орны эдийн засгийн чухал юм ярьж байдаг Санхүүгийн зохицуулах хороо нь байхгүй ийм байж болохгүй шүү дээ энэ чинь.

Энэ Хүрэлбаатар сайдаас ганц асуулт асуучихъя. Энэ цаг бага байгаа учраас. Энэ бүтээмж 2.1 хувиар өссөн

гэж байгаа юм 2022 онд. Энэ яг бүтэц нь ямар яаж өссөн байна яах вэ? Дотоодын нийт бүтэц бүтээгдэхүүнд ажиллагсдынхаа тоог хуваачихсан л байх л даа.

Гэхдээ ажиллагсдын тоо багассан байгаа шүү дээ. Монголд өгөөжгүй гадагшаа гарчхаж байгаа энэ бүх юм чинь орчхож байгаа юм. Тэгээд бүтээмж өсөхгүйгээр цалин хөлс нэмээд л энэ манай Монгол төгрөгийн ханиш гэдэг юм чинь унаад байгаа шүү дээ.

Өөрөөр хэлбэл эдийн засгийг улс төржүүлж байгаа байхгүй юу. Одоо дахиад цалин нэмэх шаардлагатай, тэтгэвэр нэмэх шаардлагатай бүтээмж одоо ямар байна, ямар бодлого барих гэж байна гээд.

Н.Энхболд: Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Яг ийм байгаа юм. Яг 2022 онд манай улсын эдийн засаг 4.8 хувиар өссөн байгаа юм. Гэхдээ 2020 онд 4.6 хувиар уначихсан тэгээд 2021 онд 1.6 хувиар өссөн. Ингээд үзэхээр ерөөсөө цар тахлын өмнөхөөс Монгол Улсын эдийн засаг 1.8 хувиар л өссөн байгаа юм эдийн засаг нь. Цар тахалтай харьцуулбал. Үндэсний статистикийн гаргасан тооноос үзэхээр Монгол Улсын хэмжээнд нийт Монгол өрхийн орлого 0.7 функтээр буучихсан. Тэр дотроо хөдөөгийн иргэдийн орлого илүү ихээр уначихсан байж байгаа. Яг ийм нөхцөл байдалд аваад үзэхээр төрийн албан хаагчдын цалин ч тэр. Яагаад гэвэл цалин нь хувийн хэвшлийнхэн ч ялгаагүй тэр ажил хийж байгаа хүмүүсийн хувьд орлого нь ингээд тогтмол байгаад байдаг.../минут дуусав./

Н.Энхболд: Болно. Хүрэлбаатар сайдын микрофон өгчих гүйцээгээд хариулчихъя. Дараа нь Баттөмөр гишүүн нэмээд асуугаарай.

Ч.Хүрэлбаатар: Тэгэхээр ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүсийн хувьд

болохоор орлого нь хэвээрээ байгаад байдаг хэрэглэж байгаа бараа бүтээгдэхүүнийх нь үнэ өсчихсөн байгаа учраас энэний зөрөөгөөрөө тухайн өрхийн орлого дээр дарамталж амьдралд нь төвөгтэй байдлууд хүндэрлээ гээд үүсгээд байгаа юм.

Ийм учраас энэ асуудлыг яаж богинохон хугацаанд шийдэх вэ, үүнтэй холбоотойгоор цалин орлого бага байна гээд Баттөмөр гишүүн хэлж байгаа. Энэ яг бодитой яг ийм нөхцөл байдал үүсчихсэн байж байгаа. Тэгсэн мөртөө бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт байдаг. Бид бүгд өнгөрсөн оны 9 сард гэхэд чинь ер нь энэ цар тахал, дайнтай холбоотойгоор ер нь дефолт болчих юм биш биз гэсэн ийм болгоомжлолтой бүх юмандаа хандаж байсан бол одоо ингээд эргээд аваад үзэх юм бол эдийн засгийн өсөлт өндөр гарахаар тийм дүр зураг харагдаж байгаа учраас ард иргэдийнхээ өрхийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авах, хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа.

Бүтээмжийн талаар яг тэр энэ бүтээмжийн төв билүү тэр Баасандорж хариулаарай.

Н.Энхболд: Аль микрофон нь вэ?

Б.Баасандорж: Энд асчихсан байна. Баттөмөр гишүүний асуудалд хариулъя. Яг бүтээмжтэй холбоотой асуудал байгаа юм. Яг бүтээмж гээд ярихаар яг саяын гишүүдээс хэлж байгаа саналуудтай зарим талаар санал нэг байна. Яг 2015 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийг баталж өгсөн. Ингээд 2020 оны улс Улсын Их Хурал буюу яг энэ хуулиуд нэлээн томоохон зарчмын нэмэлт, өөрчлөлтийг оруулж өгсөн байгаа. Яг энэ нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбоотойгоор Их Хурлаас 5 жилийн, 1 жилийн, мөн үйл ажиллагааны хөтөлбөрүүдтэй холбоотой ажлын төлөвлөгөөнүүдийг жил бүр баталсан.

Энэ жилийн бид нарын яг энэ Их Хуралд Засгийн газраас өргөн мэдүүлээд хэлэлцэж байгаа зүйл бол яг 2 дахь удаагаа Улсын Их Хуралд энэ дунд хугацааны, 1 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны урт хугацаандаа болон тухайн жилдээ ямар үйл ажиллагаа хийсэн юм бэ гэдэг энэ зүйлүүд дээр яаж байгаа. Яг энэ зүйлүүдээ Засгийн газрын зүгээс энэ бүтээмжээ нэмэгдүүлэх үүднээс Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгийг 2021 онд баталсан. Их Хурлаас үүний дагуу Засгийн газарт нэг том үүргийг өгсөн байгаа.

Засгийн газрын оновчтой үр ашигтай бүтцийг бий болгоорой Засгийн газар гэдэг үүргийг өгсөн. Яг энэ ажлын хүрээнд энэ төрийн бүтээмжийг, төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд хийгдсэн ажил байгаа. Яг энэ хүрээнд Засгийн газраас ер нь Засгийн газрын оновчтой үр ашигтай бүтцийг бий болгох хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрыг Их Хурлаас хуулийг нь баталж өгсний дагуу байгуулсан.

Ер нь цаашидаа бид нар энэ ер нь яг энэ тухайн жилийн ажлуудаа хэрхэн яаж оновчтой үр дүнтэй үнэлэх юм бэ, хэрхэн яаж дүгнэх юм бэ гэдгээр яг зайлиггүй олон улсын жишигт хүрсэн өөрчлөлт хийх зайлиггүй нөхцөл нь хүрчихсэн. Жишээ нь сая түрүүн гишүүдээс ч бас асуусан яг энэ ажлуудыг үнэлэхэд Үндэсний аудит, Улсын Их Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон яамнууд 2020 оны 206 дугаар журмыг хэрэглэдэг. Энэ журам дээр бол хүрсэн сайн түвшин ч байгаа, мөн яг олон улсын түвшинтэй нийцүүлэх зүйлүүд ч байгаа. энэ талууд дээр Үндэсний аудитын газартайгаа санал солилцож байгаа.

Мөн яг энэ зүйл тайлагнах явцад Их Хурлын шинэ бүтэц бий болсон. Их Хурлын Хяналт шалгалтын газруудтай ярьж байгаа. Яг энэ бүтээмжийг энэ үнэлэх, төлөвлөх зүйлүүдээ яг оновчтой, үр ашигтай болгох юм бол яг энийгээ дагаад бас бүтээмжийн асуудал дээр

дорвитой үр дүн өгөх болов уу гэдэг зүйлүүд дээр харж байгаа.

Мөн процесс дээрээ гэдэг юм уу, үйл ажиллагааныхаа процесс дээр яг ямар дүн шинжилгээ хийх вэ тэр зүйлүүд дээр яг шинэ Сэргэлтийн бодлогын баримт бичиг, Алсын хараа гэдэг юм уу энэ баримт бичгүүдийнхээ хүрээнд Засгийн газрын зүгээс үе шаттай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа гэсэн хариултыг хэлье.

Н.Энхболд: *Баттөмөр гишүүн бол төрийн ажлын бүтээмж гэхээсээ илүү эдийн засаг талаас нь, хөдөлмөрийн бүтээмж талаас нь асуултаа тавьсан шүү. Тийм. Баттөмөр гишүүн.*

Б.Баттөмөр: *Энэ манай Засгийн газрынхан энэ бүтээмж гэдгийг эхлээд сайн ойлгох ёстой байх. Эдийн засгийн маш чухал үзүүлэлт өөрөөр хэлбэл үр ашгийн үзүүлэлт байхгүй юу. Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг ажилчдын тоонд хуваадаг. Тэгээд энэ 2.1 хувь өссөн гээд тийм тоо яваад байдаг. Дотор талд нь тэр параметрууд, задаргаа ерөөсөө байдаггүй. Ажилчдын тоо хэд байгаад хэд болсон юм, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөс яасан юм, энэ инфляц энэ тэрээ яаж тооцсон юм? Ямар ч юм байхгүй. Энэ цалин хөлс нэмнэ, тэтгэвэр нэмнэ энэ чинь бол ерөөсөө бүтээмжтэйгээ холбоно.*

Монгол төгрөгийн ханиш яагаад унаад байна гэхээр энэ бүтээмжтэйгээ холбодоггүй, тэгээд улс төрийн шийдвэр гаргаад цалин тэд нэмнэ, тэтгэврийг тэгнэ гээд. Гэтэл бүтээмж гэдэг юм нь ингээд хаягдчихсан.

Тийм учраас манай энэ Засгийн газрыг сая ч тэр хариулахдаа дандаа өөр юм л хариулаад байна л даа. Тэр Бүтээмжийн төвийнхөө улсуудыг авч ирээд номоор нь асуу. Орц, гарц гээд энэ чинь их нарийн нарийн юмнууд байж байгаа шүү дээ. Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг.

Санал уу? Баярлалаа. Ганболд гишүүн асууя.

Г.Ганболд: *22 оны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэж байна л даа. Энэ өөрөө сонгуулийн мөрийн хөтөлбөр шүү дээ. 2020 оны сонгуулийн дараа бид нар бүгдээрээ баахан мөрийн хөтөлбөр дэвшүүлж ирээд л энийгээ 4 жилд хэрэгжүүлнэ гээд л Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болгосон.*

Тэгээд 1200 орчим томоохон ажлууд төлөвлөөд тэрийгээ 4 жилдээ хуваагаад, жилд 300 орчим ажил хэрэгжүүлнэ гээд төлөвлөсөн байгаа. 21 оны хэрэгжилт бол тааруу байсан. Одоо 22 он дээр аудитын зөвлөмжөөр бол 60, миний дүгнэж байгаагаар бол энэ 100 гэдгүүдийн нэлээн ихийг хасах юм бол 50 руу орох юм байна. Хойтон 23 онд яг энийг хэлэлцэхээр бол энэ 0 рүү тэмүүлнэ.

Яагаад гэхээр энэ жил улсын төсөв дээр хөрөнгө оруулагч байхгүй учраас 0 болно. 24 оны эхэнд бид нар бол энийгээ дүгнэж чадахгүй сонгууль руу орно. Тэгэхээр зэрэг энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр ер нь томсгосон дүнгээрээ яг өнөөдрийн хувьд хэдэн хувьтай байна? Би энэ дүнгээрээ бараг 24 он руу очих юм байна гэж харж байна л даа.

Тэгэхээр энэ дээр Шадар сайд тодорхой хариулт өгөөч. Том дүнгээрээ 4 жилээр нь авч үзэх юм бол ер нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр орно гээд яг хэдэн хувьтай яваа юм бэ? Энэ жилийнхийг бол дүнг нь харахад түрүүн гишүүдтэй би санал нэг байна л даа. Аудитын байгууллагын зөвлөмжтэй ч санал нэг байна. Төлөвлөлт буруу, санхүүжилт байхгүй баахан юмнууд тавьснаас болоод ингээд дүгнэхэд ч төвөгтэй. Шалгуур үзүүлэлтүүд нь тодорхойгүй. 4 жилээр нь шалгуураа тавьсан юм уу, жил жилээр нь шалгуураа тавьсан юм уу гэдэгт тодорхойгүй байгаа байхгүй юу.

Энэ өөрөө яагаад гэхээр бид нар зарим төслүүдээ 20-24 онд гээд 4 жилд хэрэгжихээр тавьсан байгаа юм. Заримыг нь бол зөвхөн 1 жил дээр нь тавьсан байгаа юм. Эд нарын шалгуур үзүүлэлтүүд өөр учраас ингээд өөр дүн гараад байна. Энэ утгаараа харж үзэх юм бол чухал салбарууддаа бид нар ерөөсөө хөрөнгө оруулалт тавьж чадахгүй байна. Эрүүл мэндийн салбар дээр манай саяын гишүүдийн хэлсэн яг үнэн. Өнгөрсөн жил эрүүл мэндийн салбар дээр тавьсан энэ төлөвлөгөөнд тавьсан зүрх судасны барилга ноль, эрхтэн шилжүүлэх төвийн барилга ноль, сүрьеэгийн эмнэлэг, Элэг бүтэн Монгол, халдвартын эмнэлэг, хавдрын эмнэлэг, баруун бүсийн БОТ гээд дандаа эрүүл мэндийн салбарынхан нь бүгд 0, бусад нь янз бүрийн эх эх үүсвэрээс 153 төгрөг олж байгаад төсөл, хөтөлбөрөөс хэрэгжүүлээд явчихсан байгаа юм.

Тэгээд энэ чиглэл рүү ер нь хэдүүлээ энэ хөдөөгийнхний чинь ирж байгаа санал бол энэ эрүүл мэндийн салбар руу жоохон хөрөнгө оруулаач, эмнэлгүүдийн чинь ачаалал асар их байна гээд байгаа учраас ирэх жилийн төлөвлөлт дээр бид нар энэ улсын хэмжээнд томоохон улсынхаа бараг бүх хөрөнгө төсвийг тавьж байгаад ч хамаагүй энэ томхон эмнэлгүүдийг нь Улаанбаатар хотын захад тавьж, тэнд нь хөдөө орон нутгаас ирэх хүмүүс нь байрладаг зочид буудалтай ийм томоохон юмнуудыг хийхгүй бол улсын төсвийн ард иргэдийн чинь гар дээр байгаа мөнгөний дийлэнх хувь нь энэ гадагшаа явчхаад байна. Энэ дээр бас би салбарын сайдыг бас ирэх оны энэ Засгийн газрын 23 оны төлөвлөгөө дээр бас онцгой анхаарал, 24 оных дээр ч юм уу ингээд анхаарал хандуулж яваач гэж хэлэх гээд байгаа юм.

Ер нь бол бид нар энэ хөтөлбөрийг хараад явах юм бол бас Их Хурлын зүгээс, Байнгын хороодын зүгээс энэ үнэлгээнүүд дээр ер нь бол жаахан Их Хурал нэгэнт үнэлэлт гаргах учраас энэ дээр зүгээр

хийсвэр дүгнэлтүүд зөндөө байна. 100 гээд тавьчихсан. Тэгэхдээ бид нар биш энийг чинь ард түмэн дараа нь угаасаа энэ 4 жилийн гүйцэтгэлээр, жилийн гүйцэтгэлээр ингээд хараад явах учраас Их Хурал дээр уг нь орж ирэхийн өмнө бас энэ Байнгын хороодоос ажлын хэсэг ч юм уу гараад энэ үнэлгээнүүд дээр нь бас тайлбар аваад, дүнг нь тавих юм бол илүү үр дүнтэй байгаа байхгүй юу.

Тэгэхгүй бол бид нар зүгээр ард иргэдэд Засгийн газрын орж ирсэн тоог бид нар баталгаажуулах гэж сууж байгаа биш, бас үнэхээр бодит байдал дээр энэ хэдэн хувьтай хэрэгжсэн юм, хэрэгжээгүй бол тэр нь яагаад.../минут дуусав./

Н.Энхболд: Чинзориг сайд. Хүрэлбаатар сайд тэгээд дараа нь Чинзориг сайд төсвийн төлөвлөлттэй холбоотой, ирэх оны зорилтуудтай холбоотой.

Ч.Хүрэлбаатар: Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт өссөн дүнгээрээ 39.3 хувийн хэрэгжилттэй байна гэж дүгнэсэн байгаа. Яг таны хэлдэг түрүүн Зүрх судасны төв, Хавдар судлалын төв, Сүрьеэгийн төв, Эрхтэн шилжүүлэх төв зэрэг ийм эмнэлгүүдийг барина гээд хөтөлбөрүүддээ орчихсон.

Гэхдээ энийг санхүүжүүлэх эх үүсвэрийг нь болохоор улсын төсөв дээрээ тавиагүй. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлнэ гээд тэгэхээр Монгол Улсын Засгийн газрын гадаад өрийн хэмжээ нь нэлээд дээшээ өндөр нөгөө босго руугаа нэлээд дөхчихсөн байсан учраас энэ дээр ерөөсөө янз бүрийн олон улсын банк санхүүгийн байгууллага зээл хөөцөлдөж ер нь янз бүрийн яриа хөөрөө явагдаагүй байгаа юм байна лээ.

Тэгээд одоо яг энэ 24 оныхоо жилийн төлөвлөгөө дээр ажиллаж байна. Тэгээд дахиад л энэ асуудлууд яригдаад санхүүжилтийн асуудлаа ер нь яаж

шийдэж болох вэ гэсэн байдлаар яригдаж байна. Энэ маргаашийн Засгийн газрын хуралдаан дээр танилцуулга хийгдэнэ. Түүний дараа танд дэлгэрэнгүйгээр хариулт өгье.

Н.Энхболд: Чинзориг сайдын микрофоныг.

С.Чинзориг: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Энэ эрүүл мэндийн байгууллагуудад зайлиггүй хөрөнгө оруулалттай холбоотой хэдэн барилгын асуудал байгаа юм. Миний мэдэх л 16 оны сонгуулиас хойш л яригдаж байгаа юм. Ялангуяа энэ Хавдрын эмнэлэг, ХӨСҮТ-ийн эмнэлэг эд нар гээд энэ асуудлууд өнөөг хүртэл шийдэгдээгүй л байгаа юм.

Ер нь бол бид энэ эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт оруулахгүй бол ачаалал маш их өндөр байна. Хоёрдугаарт хавдрын өвчлөл маш их өндөр, хавдрын улмаас бас хавдраар өвчилсөн иргэдийн нас баралт бол бас нэлээн өндөр, бас дэлхийд бас нэлээд эхэнд бас бичигдэж байгаа тийм асуудлууд байгаа.

Тийм учраас бол Засгийн газар дээр яриад ямар ч байсан хуралдааны тэмдэглэл гаргуулсан л даа. Тэгэхэд энэ нь яг тийм бодитой ажил болох нь бас хэр үр дүнтэй юм гэж бодож байгаа. Гэхдээ яах вэ бас улс төрийн шийдэл нь бас хэрэгтэй юм гээд л байгаа.

Энэ авлига албан тушаалын хэргийн улмаас улсыг хохиролгүй болгох замаар энэ төвлөрүүлж байгаа орлого, төрд хураагдсан хөрөнгийг эхний ээлжид эрүүл мэндийн салбарт ялангуяа эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулахад, хавдрын эмнэлгийн барилга барихад, эрхтэн шилжүүлэх төвийг бас барихад шаардлагатай тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын зардалд нь эхний ээлжид зарцуулж байх ийм хууль, эрх зүйн орчин бас бүрдүүл гэсэн ийм Ерөнхий сайдын үүрэг өгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гаргасан.

Одоо Хууль зүйн яаман дээр ийм төрлийн гэмт хэргийн улмаас улсыг хохиролгүй болгож байгаа энэ орлогыг, хөрөнгийг хэрхэн яаж захиран зарцуулах вэ гэдэг бас хуулийн төсөл бичиж байгаа юм. Нямбаатар сайд уржигдар надтай ярьсан юм. Удахгүй Засгийн газарт оруулна гэж байгаа юм байна лээ.

Тэгвэл бас ядаж бас энэ эмнэлгийн тусламж, үйлчилгээг бас сайжруулах чиглэлээр хүртээмжийг нь нэмэгдүүлчихээр зэрэг энэ эхний ээлжид зайлиггүй шаардлагатай байгаа хавдрын эмнэлэг, Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгыг барих асуудлыг эх үүсвэрийг нь шийдэх нь зүйтэй гээд ийм бас асуудал яригдаж байгаа.

Сангийн сайдтай хамтраад ажлын хэсэг гаргаад энэ ялангуяа энэ хавдрын эмнэлэг, Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн эмнэлгийг бас барих эх үүсвэрийг судалж санал боловсруулах гэсэн ийм ажлын хэсэг бас хоёр сайдын тушаалаа гаргаад ажиллаж байна. Ийм чиглэлүүдээр ажиллаж байгаа. Тэгээд Ерөнхий сайдаас өгсөн үүрэг бол ядаж Эрхтэн шилжүүлэх төвийг ирэх оны төсвийн төсөлдөө бас оруулж иргэдэг ийм зүйл яригдаж байгаа.

Хүрэлбаатар сайдтай би урьдчилж бас ярьсан. Энэ жилийн, 24 оны жилийн төлөвлөгөөнд эрүүл мэндийн салбарт хийх хөрөнгө оруулалт дээр бол энэ Хавдар эмнэлгийн асуудал, Эрхтэн шилжүүлэх төвийн асуудлыг зайлиггүй бас эхний ээлжид оруулах ёстой шүү гэдэг зүйл яриад ойлголцсон. Ингээд бас энэ орж ирэх болов уу гэсэн иймэрхүү явцтай бол байна.

Ний нуугүй хэлэхэд бол энэ эрүүл мэндийн салбарт хийх хөрөнгө оруулалтын юм ийм жаахан хоцрогдолтой, удааширалтай байгаа юм байна лээ.

Сүүлийн 2, 3 жил байдгаа л бүхнийг нөгөө фронтод гэдэг шиг бүхнийг л энэ КОВИД-той тэмцэхэд гэж ингэж явсаар байж байгаад энэ бас хөрөнгө оруулалт нэлээн бас хойшилчихсон юм байна гэдэг ийм бас байдалтай байна.

Н.Энхболд: Тодруулах уу? Ганболд гишүүн.

Г.Ганболд: Ер нь томсгосон дүнгээрээ бол 39 хувьтай л яваа юм байна гэж ойлголоо л доо. Эхний 2 жилийн гүйцэтгэл. Тэгэхээр 23 онд бол 0 рүү бараг дөхнө. Тэгэхээр гүйцэтгэл 50 хувьтай л гарах нь дээ л гэж би санаа зовж байна л даа. Тэгэхдээ одоо яах вэ нэгэнт энэ КОВИД-ын нөхцөл байдал бас энэ улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай үед бол заавал тэрийг 100 болгох гээд их алалдаад байх ч юм алга.

Өнгөрсөн оны ингээд хөрөнгийн хуваарилалтыг нь харахаар бол энэ тухайн салбарыг удирдаж байгаа сайд нарын овсгоо самбаатай юм уу эсвэл Засгийн газар дээрээ нөлөөлж байгаа нөлөөллөөс болдог юм уу хөрөнгийн хуваарилалтууд харилцан адилгүй байгаа юм.

Тэгэхээр зэрэг би Хүрэлбаатар сайдыг энэ 24 оны төлөвлөлт хийхдээ тухайн салбарынхаа онцлогийг яг үнэхээр ард иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлаа жаахан эрэмбэлж энд хөрөнгө оруулалтдаа жаахан анхаарал хийхгүй бол та нар өнгөрсөн оны хөрөнгө оруулалтын юмнуудыг хараарай. Энэ эрүүл мэндийн салбар 200-хан.

Н.Энхболд: 1 минут нэмээд өгчих болох уу? Санал юм байна. Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Бид Монгол Улсын хөгжлийн 2022 оны гүйцэтгэл гээд, үр дүн гээд маш чухал асуудал хэлэлцэж байна. Бид нар энэ өмнө нь ч яриад байгаа шүү дээ. Ер нь тоо бодит байж, бодит судалгаа, анализ хийж байгаад бодит

төлөвлөлт хийж байгаад юун дээр бид нар ирэх жилд хөрөнгө оруулалтаа төсөв батлах үедээ хэлэлцэх үү, мөнгөний бодлого дээрээ юу гэж чухалчлах вэ гээд энийгээ яг тусгаад явъя гээд. Тэгээд энэтэй холбоотой хөгжлийн баримт бичгээ хүртэл гаргасан. Тэгээд 22 оны өнөөдрийн энэ гүйцэтгэлийн үр дүнг хараад сууж байхад бас төлөвлөгөө, уялдаа холбоо байхгүй, нөгөө л бахь байдгаараа л орж ирж байна л даа.

Тэгээд Эдийн засгийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо гээд 2 том Байнгын хороо хэлэлцээд байж байдаг. Тэгээд ингээд л хэлчихсэн болоод явах уу? Би сая өмнөх зарим гишүүдийн ярьж байгаатай санал нэг байна л даа. Энэ 60 хувьтай байгаа гэдэгтэй би бол санал нийлэхгүй байна. 50 хүрэхтэй үгүйтэй байгаа.

Нөгөө талаасаа мэдээж КОВИД-ын энэ хүнд нөхцөл байдлаас дөнгөж гарсан хил гааль хаалттай байж байгаад сая нээгдсэн гээд бид нарт бас мэдээж шалтгаан байгаа. Гэхдээ 22 он бас ч гэж гэрэл дохь гарсан ийм үе шүү.

Одоо сая хэлж байна эрүүл мэндийн салбарын гээд Чинзориг сая саяхан болсон болохоор бас энэндээ анхаарах байх. Өөрөө Байнгын хорооны гишүүн байхдаа бид нар мэднэ. Яг энэ бүгд Сангийн яаман дээр танагдаад ороод ирлээ, Засаг дээр уначихлаа гэхэд бид Нийгэм бодлогын байнгын хороон дээр энэ зүрх судасныхыг, Элэг бүтэн Монголынхыг, тэр эх нялхсын өргөтгөлийн мөнгийг нь хөөцөлдөж хөөцөлдөж салбарын Байнгын хорооноос тусгасан. Тэгсэн яасан танагдчихсан. Яагаад танагдаж байгаа юм бэ бид нар та нарын мөнгийг суулгаж өгсөн шүү дээ гэсэн. Тендер дээр маргалдсан, Сангийн яаман дээр энэ зураг төсөл ингэсэн гээд буцаагаад мөнгөө татуулчихсан гэдэг юм уу гээд явахгүй байна шүү дээ. Ингэж болохгүй.

Тэгэхээр Чинзориг сайд иймэрхүү зүйл дээр анхаарахгүй бол бид нар ингээж хөрөнгө мөнгийг нь суулгаж өгдөг энэ ажил болдоггүй. Өнөөдөр хавдрын эмнэлэг дээр өглөөний 6, 7 цагаас эхлээд хүмүүс очерлоод очероосоо болж бараг бие биеэ асуудалд ороход бэлэн болж байна шүү дээ. Ийм байж болохгүй шүү дээ. Эх нялхсын ч байдлыг харъя.

Хоёр дахь нь энд ингээж байгаа юм. Хүний хөгжлийн бодлого дээр манай улс үнэхээр ингээд орхичхоод байна л даа. Манай бүх Шадар сайд маань сууж байна. Энэ бүх хүмүүс гол удирдаж байгаа хүмүүс сууж байна. Бид нар яг нийгмийн салбарыг үнэхээр орхигдуулчихлаа. Эрүүл мэнд, нийгмийн дундаж давхаргыг бий болгоно гээд. Энэ дээр бүр зорилт тавьчихсан байгаа байх. Хүний хөгжлийн бодлогын 2.5 дахь зорилт гээд 22 онд гэж байгаа шүү. Хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлж Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлсэн байна гэсэн. Энэ хэрэгжээгүй.

Тэгсэн хэр нь энийгээ бас 81 хувьтайтай гэж бичсэн байгаа юм. Энэ яаж ийм дүн гарсан юм бол энд хариулах хүн байна уу? Аудитын газар энэ дээр хариулж өгөөч. Та нар дүн шинжилгээ хийхдээ энэ дээр ямар бодолтой ингээж хандсан юм бол нэгд.

Хоёрт нь энэ Магнай дарга сууж байна. Энэний 5.1.18 дээр гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартад нийцүүлж өөрчилсөн байна. Энэ нэг ч хэрэгжээгүй. Харин ч бүүр төрийн хэмнэлтийн хуулиар бүүр байхгүй болчихсон. Одоо сая хөрсний бохирдлоос болж энэ хавар, энэ өнгөрсөн өвөл хүүхдийн өвчлөл эмнэлгүүдэд ямар түвшинд хүрэв? Тэгсэн хүний цусан дахь хүхрийн хэмжээ байх ёстойгоос 5-7 дахин их байна. Энэ нь өөрөө Монголд хавдрын өвчлөл дэлхийд эхний 1, 2, 3 гэдэгт ороход хүргэлээ гээд эрдэмтэд маань, эмч, багш нар маань бүгд өөрсдөө хэлж байна шүү дээ.

Тэгээд яагаад бид нар ингээж хүний хөгжлийн асуудалдаа анхаарахгүй байгаа юм бэ? Яагаад нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх иймд ингээд ач холбогдол өгөхгүй байгаа юм бэ? Яагаад энэ дээр танаад байгаа юм бэ? Сангийн яамныхан маань юм уу эсвэл?

6.1.1 Дэнжийн мянга төв, Дамбадаржаа дэд төвүүд газар нь шийдэгдээд ашиглалтад орсон байна гэсэн. Өнөөдөр энэ шийдэгдээгүй. Магнай дарга энд хариулт өгөөч. Энэ ямар шатандаа явж байна? Энийг хэн хийх вэ? 22 онд ингээж хэрэгжээгүй явж байна. энэ 23 онд энэ хийгдэх үү? Энэ асуудлууд дээр би эхлээд хариулт авчхаад дараа нь тодотгоё гэж бодож байна. Баярлалаа.

Н.Энхболд: Занданбат даргын микрофон 5 номер. Хүний хөгжлийн асуудалтай холбоотой асуудал.

Д.Энхболд: Оюунчимэг гишүүний асуултад дүгнэлттэй хариулъя. Хүний хөгжлийн бодлогын эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа гэдэг арга хэмжээн дээр 33 арга хэмжээ орсон байгаа. Энд зорилтоор нь авч үзвэл өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна гэсэн 15 төсөл арга хэмжээ бол хэрэгжээгүй.

Хүн бүрд чанартай боловсрол эзэмших, тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ гэсэн. Энэ зорилтын хүрээнд 5 төсөл арга хэмжээг хэрэгжээгүй.

Мөн энэ хүний хөгжлийн бодлогын хүрээнд дэх нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх, нийгмийн халамжийг оновчтой болгож, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын өсөлт, хүн амын хөгжлийг хангаж дундаж

давхаргын хүрээг өргөжүүлэн Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ гэсэн ийм зорилтын хүрээнд тусгасан б төсөл арга хэмжээ бол хэрэгжилт хангалтгүй гэсэн ийм үнэлгээг Аудитын газар өгсөн.

Дээр нь мөн түрүүний дурдсан Эрүүл мэндийн яамны хүрээнд хэрэгжих ёстой эмнэлгүүдийн барилгуудын ажил дээр бол хэрэгжилтгүй байгаа гэсэн ийм үнэлгээнүүдийг аудитын байгууллагаас өгсөн.

Н.Энхболд: Магнайсүрэн дарга 7 номерын микрофон өгөөрэй.

С.Магнайсүрэн: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яам Магнайсүрэн. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлэх энэ арга хэмжээний хүрээнд бид нар 2000-аас доошгүй жорлонг стандартын шаардлагад нийцүүлэх ийм уг нь зорилт тавьсан.

Тэгээд бас олон шалтгааны улмаас өнөөдрийн байдлаар 3230 нүхэн жорлонг шинэчилнэ гэж тооцсон боловч 22 онд 1760-ыг шинэчилсэн. Энэ хүрээнд Оюунчимэг гишүүн яг Чингэлтэй дүүрэгт бас төсөв хөрөнгийн асуудлыг биечлэн шийдүүлж багагүй энэ асуудлыг шийдүүлсэн байж байгаа.

Мөн Сонгинохайрхан дүүрэгт бас шийдэгдсэн. Мөн Орхон аймагт 1000 жорлонг бол шийдүүлэхээс 540 нь бол шийдэгдсэн ийм дүнтэй.

Яг өнөөдрийн байдлаар 22 оны сүүлийн тоо 1760-ыг л бид шийдүүлжээ. 3230-ийг шийдүүлэх ийм хөрөнгө мөнгөнийхөө бололцоонд ийм тооцоо гаргасан. Энэний тоон дүнг хэлэхэд ийм байгаа юм.

Ер нь зүгээр тус яамнаас нүхэн жорлонгийн нэг маягийн зураг, стандарт, норм дүрмийг нь 22 ондоо баталж

чадсан. Одоо бол нэг маягийн зураг шууд аваад хэрэглэх ийм сонголттой зургууд бол бэлэн байж байгаа.

Дэд төвүүдийн газар чөлөөлөлттэй холбоотой асуудлаар газар чөлөөлөлттэй холбоотой гол асуудал бол газар чөлөөлөхөд гарах зардал, төсвийн хөрөнгийн эх үүсвэрийн асуудал байж байгаа. Тэгээд энэ бол манай яамны буюу сайдын багцад ямар нэгэн хөрөнгө суугаагүй. Нийслэлийн засаг даргын төсвийн багцад тодорхой хөрөнгө суудаг. Энэ суусан хөрөнгийнхөө хэмжээнд чөлөөлөөд явж байгаа боловч өнөөдрийн байдлаар яг бүрэн чөлөөлж чадаагүй байна. Баярлалаа.

Н.Энхболд: Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Нийслэл Улаанбаатар хотоос энд хүн байгаа юу? Хотоос яг дэд төвүүдийг хариуцсан хүн нь байна уу айн? Ер нь энэ тэнд зогсож байгаа хүн нь хэн байна? Энхболд даргаа би бас энэ ганц Барилга, хот байгуулалтын хэмжээний ажил биш, Улаанбаатар хот дээр ялангуяа газар чөлөөлөлттэй холбоотой асуудлууд байгаа. Яг энэ дэд төв энэ тэр дээр хяналтаа тавиад, яамтайгаа үед уялдаа холбоотой ингэж ажиллах ёстой.

Тэгээд энэ хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг харахад манай яамнууд, тамгын газруудын хоорондын уялдаа холбоо үнэхээр байхгүй байна. Уялдаа холбоо байхгүйгээр төлөвлөлт бие биетэй уялдаж хийхгүйгээр улс орон хөгжихгүй шүү дээ. Хөгжихгүй байгаа шалтгааныг нь бид өөрсдөө яг ингээд харж байна л даа. Иргэд ч тойрог, уулзалт болгон дээр ярьж байна. Тэгээд бид нар энэ төлөвлөгөөгүй мөнгөгүй юмнуудыг тусгаад тэгээд эндээ болохлоор 20 хувьтай байна, 60 хувьтай байна, 81 хувьтай байна гэж тусгаж болохгүй л дээ.

Сая энэ хэлж байна шүү дээ эрүүл мэнд, боловсрол тэгш хүртээх, нийгмийн халамж чинээлэг дундаж давхарга бүгд хэрэгжээгүй байна гээд сая аудитын хүн хэлж байна. Тэгээд энийг

Н.Энхболд: Хотоос сая хэн байна? 7 номер. Нэр, албан тушаалаа хэлээд.

Х.Гантулга: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Гантулга гэж хүн байна. Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол нийслэл Улаанбаатар хот дээр нийтдээ энэ бүтээн байгуулалтуудын дэд төвүүдтэй холбоотой төсөл хөтөлбөрүүд дээр газар чөлөөлөлтийн зардал бол 68 орчим тэрбум төгрөг хэрэгцээ шаардлагатай гэдэг ийм тооцоо судалгаа бол гарсан байдаг.

Өнөөдрийн байдлаар бол нийслэлийн төсөвт тусгагдаж байгаа газар чөлөөлөлтийн зардал бол 5-10 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ийм хөрөнгө оруулалтын ажил туссан. Энэнтэйгээ уялдуулж бол тодорхой хэмжээнд бол дэд төвүүдийн 2 байриил дээр газар чөлөөлөлтийн ажлуудыг бол хийгээд явж байгаа гэсэн ийм тоо мэдээлэл байгаа.

Н.Энхболд: Оюунчимэг гишүүн дахиад 1 минут тодруул.

М.Оюунчимэг: Энэ ажлууд маань хийгдэх ёстой. Тэнд ард иргэд маань хүлээгээд байж байна. Дэнжийн мянгын дэд төвийн тухай, Дамбадаржаагийн дэд төвийн тухай, гэр хорооллын энэ хөрсний бохирдлыг бууруулах тухай бид хийж чадна гээд та бүхэн маань ажлаа хийгээд явж байгаа.

Тэгээд ингээд зураг төслийг нь хэрвээ та нар газар чөлөөлөлтийн мөнгийг нь 68 тэрбум гэхээр 68 тэрбумыг юунд зарцуулж байна гэдгээ нэг тайлагнах хэрэгтэй байна л даа. Энэ хүрэхгүй шүү дээ угаасаа. Тэгэхээр та нар

энэ 22 онд яг Дамбадаржаа юм уу, энэ Дэнжийн мянгын дэд төв дээр газар чөлөөлөлтөд ийм мөнгө хэрэгтэй энийг бид тусгая энийгээ 22 онд бид биелүүлнэ гэж тооцоолж эндээ тусгасан баймаар юм. Тэгээд та нар гүйцэтгэл дээр ч гэсэн өндөр дүн тавьчихаад орж ирж байна л даа. Энэ хэзээ хийгдэх вэ? Газар чөлөөлөлтийн мөнгийг нь ирэх онд тусгах уу? Энэ 22 онд энэ чинь хийгдэнэ гээд ороод ирчихсэн. Та нар эндээ гүйцэтгэлийг нь бараг 60 хувьтай гээд байгаа орж ирсэн байна шүү дээ.

Тэгсэн хэр нь сая газар чөлөөлөлтийн мөнгө нь ч байхгүй тухай ярьж байна л даа. Яагаад энд тусчихсан хэр нь 68 тэрбумаас энд мөнгө нь тусгагдаагүй юм бэ гэдэгт хариулт өгөөч. Цаашидаа яах вэ?

Н.Энхболд: Хариулъя. 7 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Ер нь бол одоогийн байдлаар бол 2022 онд бол Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд бол туссан зорилтын хувьд бол дэд төвүүдийн үйл ажиллагааг үргэлжлүүлнэ гэдэг төлөвлөлт орсон. Газрын чөлөөлөлттэй холбоотой зардал дээр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр бол хийгдээд ингээд чөлөөлөлтүүд нь яг энэ дэд төвүүдийн хувьд тухайлсан ингээд явж байгаа.

Ирэх жилүүдэд бол нийслэлийн төсөвт тодорхой хэмжээний мэдээж зардлууд суугдах байх. Бүрэн хэмжээнд бол бүх дэд төвүүдийн газрыг бүрэн чөлөөлөх хэмжээний төсөв болоод суухад бол хүндрэлтэй байх болов уу л гэсэн ийм тооцоо байгаа.

Н.Энхболд: Дэнжийн мянга Дамбадаржаа 2 дээр.

С.Магнайсүрэн: Дамбадаржаа, Дэнжийн мянга төвийн яг ажлын явцын тухайлсан мэдээллийг би танд албан ёсоор хүргүүлъя.

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр тэр дотроо 22 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж байгаа юм. Энэ манай Улсын Их Хурлаас баталсан Улсын Их Хурлын хянан шалгалтын хуулиар Засгийн газар тавьж байгаа хамгийн том хяналтын нэг нь энэ л дээ. Тэгээд би хэдэн асуулт асууя. Амарбаясгалан дарга байхгүй болохоор тэгээд хэн хариулах юм бол доо.

Нэгдүгээрт яг өнөөдөр сая энэ 23 оны, 22 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр яг хэдэн хувьтай явж байна гэдгийг нэгдүгээрт их тодорхой хэлмээр байна.

Хоёрдугаарт нь энэ үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт салбар салбараар янз бүр байна. Зарим нь ч гайгүй, зарим нь ч тааруу. Дээр нь аудитын дүгнэлтэд бас дурдагдсан байна. Дотоодын хяналт шалгалт тааруу байсан гэсэн тийм дүгнэлт байна лээ.

Тэгэхлээр ер нь Засгийн газрын зүгээс салбаруудын яамнууд, агентлагуудад энэ төлөвлөгөөний биелэл хэрэгжилтийг муу биелүүлж байгаа энэ бол Засгийн газрын үндсэн ажил байхгүй юу. Энэ төлөвлөгөөний хэрэгжилтийг муу хэрэгжүүлсэн хүмүүс дээр хариулах тооцоо асуудал байна уу? Хариуцлага тооцоо асуудал.

Гуравдугаарт Хүрэлбаатар сайд хариулах уу? Инфляцын түвшин 13.2 хувьтай байсан өнгөрсөн онд. Бид нар чинь энэ төлөвлөгөө дээр ч байгаа, мөрийн хөтөлбөрт ч байгаа. Инфляцын түвшинтэй уялдуулж цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж явна гэсэн ийм хөтөлбөртэй хүмүүс. Тэгээд яах вэ, өнгөрсөн онд бид нар тэтгэврийг нэмсэн. Тэр 13-аас, 15-аас илүү нэмэгдсэн. Тухайн үедээ 500-аас дээш мянга төгрөгийн

тэтгэвэртэй хүмүүс чинь 15 хувь нэмэгдсэн шүү дээ. Тэр инфляцын түвшин гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ өнгөрсөн онд нөгөө төрийн албан хаагчдын цалин нэмэгдээгүй байхгүй юу. Инфляцын түвшинтэйгээ уялдаагүй. Энийг цаашид ер нь яая гэж бодож байгаа вэ гээд байх асуудал байгаа юм.

Дөрөв дэх асуудал нь зээлтэй холбоотой асуудал байгаа юм. Одоо бизнес эрхлэгчид яах вэ, энэ өнгөрсөн жилүүдэд 20, 21, 22 он хүнд байсан ойлгож байгаа. КОВИД үргэлжлээд дэлхий нийтийн хэмжээнд болсон энэ дайн, инфляцын өндөр эрсдэлүүд гээд зөндөө юмнууд байгаа.

Гэхдээ сүүлийн үед нөгөө банкны бодлогын хүү өндөр байгаатай холбоотойгоор арилжааны банкнуудын зээл зогсчихоод байгаа юм. Зээл эрс багасчихаад байгаа юм. Ийм учраас нөгөө бизнес эрхлэгчид жаахан гайгүй болох гээд байдаг, нөхцөл байдал нь гайгүй болж ирэх гээд байдаг. Гэтэл нөгөө эргэлтийн хөрөнгөгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ 2023 онд энэ арилжааны банкнуудаас гарах зээлийн өндөр хүүтэй ч байсан хамаагүй энэ зээлийн олдоц маш муу эрсдэл ихтэй байгаа учраас энэ зээлийн асуудал дээр ер нь Засгийн газраас ямар бодлого барьж байна вэ гэдэг асуудал.

Дараагийнх нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний асуудал байгаа. Сүүлийн 2, 3 жил энэ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд экспорт нь хаагдсан. Одоо арай дээр болох гэж байх шиг байна. Засгийн газрын зүгээс энэ чиглэлээр ямар арга хэмжээ авч байна? Тухайлбал мах, махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур. Ноолуур дээр тодорхой арга хэмжээ авсан байна лээ.

Эдийн засгийн хөгжлийн яамны саналаар. Тэр болж байгаа юм энэ жилийн хувьд. Бусад түүхий эд бүтээгдэхүүнийг гаргах энэ экспортыг

нэмэгдүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч байна вэ? Холбогдох байгууллагуудтай ялангуяа Бүгд Найрамдах Хятад Ард Улс ч юм уу, холбогдох улсуудтай гэрээ хэлэлцээр хийгээд түргэн шуурхай явж байгаа юм байна уу? Бид нар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж валютын нөөц нэмэгдэнэ. Хэдэн үйлдвэрүүд чинь жаахан дээрдэж өгнө. Малчид болон түүхий эд.../минут дуусав./

Н.Энхболд: Хүрэлбаатар сайд эхлээд эхний 3 асуултад хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Тогтохсүрэн даргын инфляцтай холбоотой асуултад хариулъя. Яг 22 оны эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт 39.3 хувийн хэрэгжилттэй байгаа. Ер нь энэ жилийн төлөвлөгөөгөө биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтүүдийг хараад биелэлт муутай байгаа Засгийн газрын хамгийн доод талын 5 сайд дээр хариуцлага тооцох тухай асуудал яригдаж байгаа гэдгийг би хэлье. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ 23 оны төсөв дээр цалин эд нарыг яг тусгайлан тэдэн хувиар нэмэхдээ 200 гаруй орчим тэрбум төгрөгийн эх үүсвэр тавигдсан салбар салбараар урамшуулалтай холбоотойгоор тэр нь нэмэгдээд явж байгаа гэдгийг би хэлье.

24 оны хувьд гэвэл бас энэ чиглэлээр Засгийн газар тооцоо судалгаа хийгээд явж байгаа. Маргааш Засгийн газрын хурал дээр энэ 24 оны жилийн төлөвлөгөө яригдана. Энэ үедээ энэ тухай асуудал яригдаад тодорхой шийдвэр гарахаар та бүгдэд эргээж хариулъя гэж бодож байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг чиглэлээр Засгийн газар 2 шийдвэр гаргасан.

Нэгдүгээрт арьс ширтэй холбоотойгоор 2013 оны 8 дугаар сард энэ арьс ширийг экспортлохыг хориглосон шийдвэрүүдийг хүчингүй болгосон байгаа. Үүнтэй холбоотойгоор хилээр энэ бүтээгдэхүүнүүд гарч эхэлж байгаа. Би энэ 3 сарын 18-ны өдрийн мэдээг би зүгээр авсан мэдээг танд уншаад танилцуулчихъя.

Нийтдээ 10 тээврийн хэрэгслээр мах, 251 тонн мах экспортлогдсон байгаа. Энэ зөвхөн 1 өдрийн арьс шир 16 тээврийн хэрэгслээр 439 тонн боловсруулалт хийгдээгүй ийм арьс шир гарсан. Хагас боловсруулсан арьс шир 2 тээврийн хэрэгслээр гаргасан байх жишээтэй. Ноос ноолуур 2 тээврийн хэрэгслээр 33 тонн, дэл сүүл 2 тээврийн хэрэгслээр 46 тонн гээд.

3 сарын 19-нд мөн ялгаагүй мах 3 тээврийн хэрэгслээр 75 тонн, арьс шир 9 тээврийн хэрэгсэл боловсруулалт хийгдээгүй нь 243 тонн, хонины арьс шир 3 тээврийн хэрэгслээр 81 тонн гээд ийм бүтээгдэхүүнүүд гараад эхэлчихсэн байгаа.

Тэгэхээр энэ Засгийн газар сар гарны өмнө авч хэрэгжүүлсэн энэ шийдвэр одоо бодитойгоор болж байгаа нь эргээд хөдөөгийн малчдын орлого нэмэгдэх, экспортын орлого нэмэгдэх, валютын урсгал наашаа орж ирэх ийм нөхцөлийг бүрдүүлж байгаа гэдгийг хэлье.

Махан дээр хуучин квот гээд тогтоогоод Хүнс, хөдөө аж ахуйн яам зөвшөөрөл өгөөд байдаг байсан. Энийг бүгдийг нь больчихсон байж байгаа. Тэгэхээр шаардлага хангасан л бол өөрсдөө энийгээ экспортлох ийм боломжийг бас бүрдүүлж өгсөн гэдгийг хэлье. Хүнс, хөдөө аж ахуйн яам энэ дээр санал санаачилгатай ажилласан гэдгийг би хэлмээр байна.

Ноолуур мөн ялгаагүй зөвхөн самнасан ноолуур гаргана гэдэг энэ шийдвэрийг мөн болиулсан байж байгаа.

Тэгэхээр энэ нь эргээд зах зээл дээрээ бас их эерэг нөлөө үзүүлж байгаа. Энэ бүгдийг яагаад авч хэрэгжүүлээд байгаа юм бэ гэхээр энэ корона, дайнтай холбоотойгоор 3 жилийн хугацаанд малчин өрхийн орлогууд нэлээд буусан байгаа.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор энэ арга хэмжээнүүдийг нэлээд шуурхай авч хэрэгжүүлж байгаа гэдгээ хэлье. Үр дүн гарч байгаа гэдгийг би хэлмээр байна.

Бодлогын хүүгийн хувьд инфляцын түвшинтэй уялдуулаад буулгах уу гэж байна. Тэгэхээр яг өнөөдрийн байдлаар инфляцын түвшин

Н.Энхболд: Хүрэлбаатар сайдын микрофоныг нэмээд өг. 1 минут сунгаадах.

Ч.Хүрэлбаатар: 12.2 хувьтай байгаа. Манай яамныхны хийж байгаа тооцоогоор энэ жилийн эхний хагастаа нэг оронтой тооллого орчих болов уу гэсэн ийм тооцоог хийж байгаа гэдгийг хэлье. Сая Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл хуралдаад бодлогын хүүг хэвээр нь үлдээнэ гэдэг ийм шийдвэр гаргаад явж байгаа.

Яагаад гэхээр бас энэ инфляц мөн зээл олгох гээд олон олон асуудлууд байдаг. Тэгэхээр энэ дотроосоо бид нар энэ бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй тэнцэх. Энэ үнийн өсөлтийг бууруулах гэсэн энэ зорилтоо хатуу хэрэгжүүлж явуулахын тулд мөнгөний бодлогыг буулгах боломжгүй байгаа гэдэг гэдгийг би хэлье.

Хэрвээ бодлогын хүүг буулгах юм бол энэ төгрөгийн ханиш дахиад цаашаа үргэлжлүүлээд унана, инфляц нэмэгдэнэ, тэгээд үүнтэйгээ дагаад баахан зардлууд нэмэгддэг. Тэгэхээр энэ бодлогын хүүг эхлээд энэ инфляцын

Н.Энхболд: Сүхбаатар сайдын микрофоныг өгчхөөрэй. Сүхбаатар сайдын микрофон. Бүртгэлд орсон уу?

Ж.Сүхбаатар: Тэгэхээр Тогтохсүрэн даргын асуултад хариулахад яг маргааш Засгийн газрын хуралдаанд Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлт, Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн асуудлыг маргааш Амарбаясгалан сайд оруулна. Сүүлийн 3 удаагийн Засгийн газрын хуралдаан дээр энийг таны хэлж байгаа асуудлаар Засгийн газар энэ хийж хэрэгжүүлж байгаа ажлынхаа юмыг сайд болгон дээр ингээд төлөвлөгөө гаргах ёстой гээд тэгээд энэ бас нэлээн нүсэр ажил юм байна гээд. Засгийн газрын нөгөө шинээр байгуулагдсан Хяналт шалгалтын газар энэ дотоод хяналтынхаа хүрээнд Хэрэг эрхлэх газартай ажиллаад бас нэлээн шахаж ажилласан чинь нүсэр ажил байна гээд. Ингээд өнгөрсөн хуралдаанд биш маргааш орж байгаа.

Ер нь Ерөнхий сайдын өгсөн үүрэг Хэрэг эрхлэхийн сайдад болоод бидэнд хэлж байгаа юм ингээд сайд болгон дээр хараад хангалтгүй биелүүлж байгаа тэр ажлууд дээр шаардлага тавиад Ерөнхий сайд шаардлагатай бол бас хариуцлага тооцно шүү гэдэг ийм юмыг Засгийн газрын хуралдаан дээр хэлсэн.Өгсөн үүргүүд бол заавал.../минут дуусав./

Н.Энхболд: Дотоод хяналт шалгалттай асуудлаар сая Сүхбаатар сайд хэлчихлээ дээ Ер нь бол ийм сонголт хийж байгаа, тайлан сонсож байгаагийн гол үр дүн нээрээ үнэхээр ажил төрөл нь болохгүй байгаа, хийж чадахгүй байгаа тэр хүмүүстээ ямар нэгэн байдлаар хариуцлага тооцох асуудлыг л эцсийн дүндээ ярих ёстой шүү дээ тийм ээ? Сая Хүрэлбаатар сайдын амнаас бас тийм үг гарч байна, тоо хэлж байна тодорхой. Жилийн төлөвлөгөө, мөрийн хөтөлбөрт туссан зүйлүүдээ хийж гүйцээх тал дээр хариуцлагагүй ажилласан хүмүүстээ ямар нэгэн байдлаар хариуцлага тооцох

тухай асуудал яригдаж байгаа гэж ярьсан. Энийг бас Их Хурал, Байнгын хороо анхааралдаа авлаа шүү гэдгийг хэлчихье. Ундрам гишүүн.

Ч.Ундрам: Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд Үндэсний Аудитын газраас хэрэгжилтийг 60.1 хувьтай зорилтот үр дүнд хүрээгүй байна гэж дүгнэсэн байна. 60.1 хувь гэдэг бол одоо “D-” бараг л “F” гэсэн үг шүү дээ. Тэгэхээр маш муу ажилласан гэдгийг эндээс харуулж байгаа. Тэгээд яах вэ энэ дээр бид нар дүгнэлт хийх ёстой л доо.

Нэгдүгээрт сая ингээд гишүүдийн асуулт, хариулж байгаа хүмүүсийг ингээд сонсохоор мөнгийг нь санхүүжилтийг нь тавьж өгөөгүй ч гэдэг юм уу ингээд ийм асуудлууд байна. Тэгэхээр бид нар дараа дараагийн төлөвлөгөөгөө яаж боловсруулах вэ гэдэг дээрээ нэлээн анхаарах ёстой гэдгийг нь харуулж байгаа юм.

Төлөвлөгөө чинь биелэгдэхүйц, хэмжигдэхүйц, санхүүжилттэйгээ уялдаатай байх ёстой гээд ийм зарчмууд байгаа шүү дээ. Тэгэхээр захын нэг компанийн бизнес төлөвлөгөөнөөс долоон дор төлөвлөгөө бид нар боловсруулчхаад, тэгээд дараа нь энийгээ муу авсан байна уу, сайн авсан байна уу гээд үнэлээд явахад хэцүү. Тэгэхээр энэ дээрээ бид нар анхаарах ёстой гэж харагдаж байна.

Хэд хэдэн асуулт байна. Нэгдүгээрт энэ Алтанбулаг боомтын шинэчлэлийн асуудал ямар түвшинд явж байна вэ. Яг энэ Дарханы зам шиг хамаг боомтынх нь барилгыг нь нураачхаад тэгээд нэг хагас дутуу каркас босгочихсон тэндхийн ажилчид нь контейнерт өнөөдөр өвөлжингөө ажил хийгээд нөгөө хүний эрх, Хөдөлмөрийн тухай хууль огт хэрэгжихгүй маш хүнд нөхцөл байдалтай ингээд 2 жил явж байна.

Тэгэхээр энэ Алтанбулаг боомтын шинэчлэлийн асуудал дээрээ яг ямар анхаарал тавьж, юу хийсэн юм бэ гэдгийг нэгдүгээрт асуумаар байна. Яг энэнтэй уялдаа уялдаатай Алтанбулаг чөлөөт бүсийн бас асуудал байна. Тэнд нэг хаашаан дотор хэдхэн байшин байна. Тэгээд яг улс орны ямар бодлогоор тэнд ямар бодлого зохицуулалт хийх гээд байгаа юм. Ямар төсөл хэрэгжих гээд байгаа юм ойлгомжгүй. Тэгээд Алтанбулаг боомт чөлөөт бүс тэгээд Алтанбулаг сум чинь нэг газар нутаг дээр байгаа шүү дээ. Тэгээд хоорондын уялдаа холбоо байхгүй. Чөлөөт бүс дээр 35 киловаттын цахилгаан станц барина гээд. Тэгээд боомт дээрээ бас энэ цахилгааны эх үүсвэр яригдаад, сум дээрээ дахиад цахилгаан станц яригдаад ингээд байж байдаг.

Тэгэхээр энэний уялдаа холбоог хангаж ажиллах тал дээр хариуцаж байгаа сайд нар нь ч байдаг юм уу, та хэд ер нь юу ярьж байгаа вэ гэдэг.

Асуулт дараагийн асуулт нь энэ Атарын 4-дүгээр аяныг хэрэгжүүлнэ гэсэн байна. Тэгээд гүйцэтгэл нь 42.6 хувьтай. Яг юу хийсэн бэ? Энэ аян гэдэг чинь улс орон дахиныг хамарсан том л их л том хүн болгон бараг мэдэрч ойлгоод хараад үр дүнг нь мэдрээд байх ийм ажил байх ёстой гэж бодоод байна л даа. Өмнөх Атарын аянууд хүн болгонд мэдрэгдэж байсан шүү дээ. Өнөөдөр энэ Атарын 4-дүгээр аян хэрэгжлээ яасан? Гурилын үнэ нэмэгдчихсэн байна.

Тэгэхээр яг юу хийсэн юм бэ, ямар дорвитой ажил хийсэн юм бэ гэдгийг асуумаар байна. Тэгээд энэ Атарын 4-дүгээр аяны хүрээнд энэ жишээлбэл Сэлэнгэ аймгийн Сант суманд энэ хөдөө аж ахуйн агротехникийн үйлчилгээний төв барина, МСҮТ байгуулна гэсэн Хөдөө аж ахуйн сургуулийн салбарыг түшиглээд гэсэн ийм ажил байгаа юм. Тэгсэн мөртөө хүсэлт Германы хамтарсан Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил төслийн хүрээнд хүсэлт гаргасан байна. Тэгээд

сургалт 2 удаа хийсэн ч гэнэ үү ийм хачин юм энэ тайланд тусгахаас ичээч та нар. Би бол бүр уншаад бичиж байна шүү дээ. Тэгээд энэ материал нь саяхан ирж байгаа шүү дээ. Бид нарыг унш гээд. Тэгээд бүхэл бүтэн Засгийн газрын жилийн үйл ажиллагааг 5 минутын өмнө материалыг нь өгөөд хэлэлцсэн бол, асуусан бол гэж байгаа юм шиг, хүн доромжилж байгаа юм шиг ийм юм ирсэн байгаад байгаа.

Энэ зөвшөөрлийн тухай хууль амьдрал дээр хэрэгжихгүй байна? Би сая бүх сумдаараа ороод ажиллаад ард иргэдтэйгээ энэ хуулийн тухай бас яриад ирсэн. Тэгээд яг амьдрал дээр ард иргэд.../минут дуусав./

Н.Энхболд: Би Булгантуяа сайдыг дуудуулчхаад байж байна. Тэр Атарын 4-дүгээр аяын талаар Хөдөө аж ахуйн яам Жамбалцэрэн. Яг бодитой юу хийчхэв, дараа нь Эрчим хүчний яамныхан бэлдэж байгаарай. Тэр 1 газар 2 эх үүсвэр байгаа, яагаад байгаа юм уялдаа холбоо байна уу, үгүй юү гэж асууж байна. Ажлын хэсэг.

Т.Жамбалцэрэн: Ундрам гишүүний асуултад хариулъя. Газар тариалангийн Атрын 4-дүгээр аяны хүрээнд буюу Үндсэн чиглэлийн 22 онд хэрэгжүүлсэн ажил дээр газар тариалангийн үйлдвэрлэлийн салбарт 22 оны үндсэн гүйцэтгэлээр 1.5 их наяд төгрөг болж өссөн байгаа. Өмнөх оноос 8.2 тэрбумаар буюу 0.6 хувиар нэмэгдсэн ийм үзүүлэлттэй байгаа.

Өнгөрсөн 22 онд газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх үрийн шинэчлэл хийх ажлууд тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд шинэчлэлүүдээ хийсэн. Ургац хураалтын дүн бол хүнсний ногоон дээр нэлээдгүй амжилт үзүүлсэн. Энэ нь дотоодын хэрэгцээгээр 75 хүртэл хувиар хүнсний ногоогоо хангах ийм боломж бүрдсэн.

Дээр нь техник технологийн шинэчлэл хийх зорилгоор Атрын 4-дүгээр аяныг хэрэгжүүлэх зорилгоор газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлүүдийг гаргасан. Энэ зээлийн хүрээнд тухайн жилд авч байгаа дотоодын хэрэгцээнд гурилын улаан буудайныхаа хэрэгцээг бүрэн авсан ийм үзүүлэлттэй байгаа. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд КОВИД цар тахлын нөлөөгөөр инфляцаас үүсэлтэй хамааралтайгаар энэ гурилын үнэд тодорхой өөрчлөлтүүд гарсан. Тухайлах юм бол шатахууны үнэ нэмэгдсэн үзүүлэлтүүд, дээр нь ургамал хамгааллын бодис энэ чиглэлийн үнэ одоо дэлхийн зах зээл дээр бас 2-3 дахин нэмэгдсэн ийм үзүүлэлтүүд энэ газар тариалангийн үйлдвэрлэлийн салбар дээр бас нөлөөлсөн гэдэг асуудлыг хэлэх нь зүйтэй.

Дээр нь энэ хүнсний хөтөлбөртэй Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг орон даяар өрнүүлэхтэй холбоотой, дээр нь Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолтой холбоотой газар тариалангийн үйлдвэрлэлтийн бүлэг багц хөтөлбөр тусгагдсан. Энэ хүрээндээ энэ оны тухайд 1 их наяд төгрөгийн нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй арилжааны банкны эх үүсвэртэй зээлийг гаргахаар шийдвэрлэсэн. Энэ чиглэлд одоо 400 орчим сая төгрөг тэрбум төгрөгийг цэвэр газар тариалангийн үйлдвэрлэлд зарцуулах, ингэхдээ тоног төхөөрөмжийн шинэчлэл, техник технологийн шинэчлэл, үр сортын шинэчлэл энэ чиглэлийн зардлуудыг тусгаж өгсөн бай байгаа.

Хүнсний хөтөлбөртэй холбоотой Боловсрол шинэчлэх ухааны сайдын багцад 1.8 тэрбум төгрөг тусгагдсан. Энэ чиглэлээр салбарын боловсон хүчнийг чадавхжуулах, саяын таны асуултад дурдсан энэ Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа хүрээлэн байгуулах, энэ Сантад байгаа техник мэргэжлийн сургуулийг шинэчлэх энэ чиглэл дээр тодорхой

зардлуудыг шийдвэрлэхээр тусгагдсан ийм юутай байна.

Н.Энхболд: Эрчим хүчний яамныхан тэр Алтанбулаг дээр сум, боомт 2 дээр хоёр хоёрын зэрэг тийм эрчим хүчний эх үүсвэрийн асуудал яригдаад байгаа нь ямар учиртай юм бэ? Тайлбар өг гэж байна.

Б.Ерэн-Өлзий: Алтанбулаг чөлөөт бүс дээр ямар цахилгаан станцын төлөвлөсөн төсөл хувийн хэвшилээс Эрчим хүчний руу хандаагүй. Эрчим хүчний яамны зүгээс ямар нэгэн тэнд цахилгаан станц барина гэж төлөвлөсөн зүйл байхгүй байна.

Алтанбулаг чөлөөт бүсийн энэ цахилгаан хангамжийн асуудал өнгөрсөн онд Эдийн засгийн хөгжлийн яамнаас тендерээр зарлагдсан. Энэ Сүхбаатар дэд станцыг өргөтгөөд Алтанбулаг хүртэлх 35-ын шугамын утсыг сольж, дамжуулах чадлыг сайжруулах, боомт дээр 35.6 киловольтын дэд станц барих ажлууд одоо барилга угсралтын ажил нь явж байгаа.

Сайнзориг дарга хариулах уу? Тэр Зөвшөөрлийн тухай хуультай холбоотой бас асуулт явчих шиг боллоо. Ганбат дарга Сангийн яам Төрийн нарийн бичгийн дарга.

Ж.Ганбат: Би энэ боомттой холбоотой Алтанбулаг дээр энэ дээр нь би тайлбар хэлье. Алтанбулаг хилийн боомтын зорчигч тээвэр, ачаа тээврийн барилгын ажлын гүйцэтгэгчээр нь “Монкон” гэж компани шалгараад ажлыг нь гүйцэтгээд явж байгаа. Энийг одоогийн байдлаар яг эхний батлагдсан төсвөөрөө бол 70 хувийн гүйцэтгэлтэй гэж байгаа.

Гэхдээ энэ дээр үнийн өсөлт болон анхны батлагдсан техник эдийн засгийн үндэслэлд өөрчлөлт оруулах ийм асуудлыг компанийн зүгээс тавиад байгаа учраас энэ асуудлыг Барилгын хөгжлийн төвөөр

магадалгаа хийлгэхээр ингээд ярилцаж байгаа.

Энэ төсөл маань өөрөө Азийн хөгжлийн банкаар яригдаж байгаа учраас бас энэ үнийн өсөлтийн асуудал, энэ төсөвт өртгийн нэмэгдлийн асуудлыг бид Азийн хөгжлийн яаманд тавиад энэ асуудлыг яаралтай шийдвэрлэж өгөөч гэдэг ийм хүсэлт тавиад байгаа.

Нөгөө талдаа би сая Эрчим хүчний яаман дээр яах вэ нэмэлт мэдээлэл өгөөд Эрчим хүчний яамнаас 22 оны 8 сард ингээд олгогдсон. Ингээд шинэчилсэн техникийн нөхцөлийн дагуу хийгдэх тэр орлогын кабель шугамыг хос болгох Алтанбулаг сумын 35 ваттын цахилгаан дэд станцын хүчин чадалтай. Ингээд тэд нарыг нэмэгдүүлэх энэнтэй шаардлагатай бас зардлын асуудлыг нь шийдвэрлэх ийм ийм асуудлууд байгаад байгаа. Энэ асуудлыг бас Азийн хөгжлийн яаманд тавьж энэ асуудал шийдвэрлүүлэх гэдэг ийм асуудал дээр бас жосоохон ажлын явц нь удааиралтай ийм байдал үүсээд байгаа юм.

Н.Энхболд: Сайнзориг дарга Зөвшөөрлийн хуулийн хэрэгжилттэй холбоотой асуулт.

П.Сайнзориг: Яг гишүүний бас асуултыг гүйцэж бас яг асуугдсангүй. Ер нь зүгээр бас хүндрэлтэй зүйлүүд байгаа юм байна гэж ойлголтоор би хариултыг өгье. Ер нь зөвшөөрлийн хуулиар хэрэгжээд бас удаагүй байгаа бас энэ хуулийг сурталчлан таниулах гэдэг ажил бас учир дутагдалтай байгаа гэдэгтэй санал нэгтэй байна.

Ер нь энэ хууль маань 1500 орчим байсан зөвшөөрлийг 360 руу оруулчихаад байгаа энгийн зөвшөөрлийг бас хугацаанд нь шийдээгүй олгосноор тооцно ч гэдэг юм уу бас яг энэ зөвшөөрлийг өгч байгаа төрийн байгууллага талдаа ч гэсэн мэдээллүүдийг хүргэх энэ юмнууд бас нэлээн сайжруулж хийх ёстой гэдэгтэй санал нэг байна.

Хоёрдугаарт бас өмнө нь явж байсан зөвшөөрлүүд дээрээ бас нэмж бас энийгээ олгох гэдэг юм уу, зөвшөөрлөө хадгалж үлдэх ийм практикууд бас энэ орон нутгийн түвшинд байгаад байгаа.

Тэгэхээр энэ хуулиас давсан шийдвэрүүдийг бас орон нутаг мөрдүүлж болохгүй гэдэг зүйлүүдийг бид нар бас хуулийг нь сурталчлан таниулах ажилтай хийнэ.

Хоёрдугаарт бас энэ зөвшөөрлийн асуудал маань Эдийн засгийн хөгжлийн яамны бас үндсэн асуудал байгаа. Энэ яаман дээр энэ зөвшөөрлийг бас цахимаар олгох нэгдсэн энэ платформ, программ хангамжийг бас шийдээд бас Цахим хөгжил харилцаа холбооны яамтай бас хамтран явж байгаа гэж ойлгож байгаа.

Ер нь бас энэ уг асуудлуудыг шийдээд явбал хуулийн бас хэрэгжилтийг сайжруулах бололцоо гарах байх гэж харж байгаа.

Бүр үнэхээр тулчихсан түрүүн бас Санхүүгийн зохицуулах хорооноос тавьж байгаа энэ мэт асуудлууд байх юм бол бид бас энэ богино хугацаанд хуулийн хэрэгжилтийг бас үнэлж, холбогдох шаардлагатай өөрчлөлтүүдийг бас Хууль зүй, дотоод хэргийн яамнаас анхаарч ажиллая гэдгийг танд бас хэлье.

Н.Энхболд: Ундрам гишүүн тодруулж асууя.

Ч.Ундрам: Энэ хөдөө аж ахуйн агротехникийн засварын үйлчилгээний төв МСҮТ-тэй холбоотойгоор Боловсролын яаманд 1.8 тэрбум төгрөг хуваарилж төсөвлөгдсөн гэж байгаа юм. Тэгээд энэ тайланд чинь 2 удаагийн сургалт зохион байгуулсан л гэдэг ажил байгаа байхгүй юу. Тэгэхээр 1.8 тэрбум төгрөгөөр 2 удаагийн сургалт зохион байгуулсан гэж ойлгож болох уу? Энэ бүүр арай л дэндүү сонсогдож байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ Алтанбулаг боомттой холбоотой энэ боомт, тэгээд чөлөөт бүс тэгээд энэ сумынхан ингээд хамтарсан нэгдсэн төлөвлөгөө та хэд хийгээд өгөөч, хоорондоо уулзаад өгөөч, хажууханд нь байгаа Сүхбаатар сум саяхан бас 50 мегаватт ваттын хүчин чадалтай шинэ дулааны цахилгаан станц барих ийм шийдвэр гаргачихсан тэгээд компанитай гэрээ хийгээд явж байгаа байхгүй юу.

Н.Энхболд: Тодруулчихъя 1 минут өгчих тийм.

Ч.Ундрам: Тэгэнгүүт одоо ингээд төсвийн мөнгөөр 35 киловаттын дэд станц барина, боомт дээр нь тэгнэ ингэнэ гээд ямар ч уялдаагүй ийм зүйл яваад байна.Тэгэхээр энэ хооронд нь нэг газар байгаа 3 захиргааны нэгжийг төлөвлөлтийг нь нэгтгээд өгөөч гэдэг ийм хүсэлт байгаад байна.

Н.Энхболд: Тэр асуудлыг нь яамтай холбоотой тийм юм хийгээд байдаг юм уу? Түрүүгээр өөрснөө дур дураараа тийм юм хийгээд яваад байдаг юм болов уу? Тэр дээр нь хариулт өгчихье. 7дугаар микрофон.

Б.Ерэн-Өлзий: Чөлөөт бүсийн цахилгаан хангамжид зориулж 35 киловольтын шугамыг өргөтгөх одоо Алтанбулаг боомт руу 35 шугам байгаа. Энд 35 шугамын утсыг солиод төгсгөл дээр нь гучин тав, зургаа киловольтын дэд хэс станц барих ажил одоо хийгдэж байгаа.

2016 онд хувийн хэвшлийнхэн Сүхбаатар сумд 50 мегаваттын дулааны цахилгаан станц барина гэж зөвшөөрөл авсан. Энийг холбогдох бүх зөвшөөрлүүдээ авсан байгаа. Энэ хувийн хэвшил, орон нутгийн хооронд яригдаж байгаа асуудал. Эрчим хүчний яамтай одоогоор энэ асуудал яригдаагүй байна.

Н.Энхболд: Би нэг юм энэ Хөдөө аж ахуйн яамныхнаас нэмээд асуугаадахъя. Тэр сая Ундрам гишүүн асууж байна 1.8 тэрбум төгрөг их наяд билүү, тэрбум билүү? Тэрбум төгрөг чинь хоёрхон сургалтад зарцуулчихсан юм уу? Эс үгүй бол одоо заримыг нь зарцуулаад, заримыг нь үлдэгдэл болоод хоцорчихсон юм уу? Энэ дээр тодорхой хариулт өгөөдхөөч.

Хоёрдугаарт энэ жил жишээ нь 4 зуугаад сая төгрөг хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ялангуяа төмс, хүнсний ногооныхонд тусдаа дэмжлэг үзүүлнэ гээд төсөвлөчихсөн байгаа гэж ойлголоо тийм ээ? Тэгэхээр энэ дотор чинь би одоо танай яаманд ганц би ч биш Төв аймгаас сонгогдсон гишүүд 2, 3 удаа хандаад байж байна. Борнуурын энэ усан хангамжийн ус хураагуур тэндээсээ тариалангийн талбайгаа усалдаг байгууламж эвдэрчихсэн байж байгаа.

Одоо ингээд шар усны үер эхлээд засах аргагүй болох нь. Та нар болохоор мөнгө байхгүй, дараа жилд ахиухан хэмжээгээр тавьж байгаад нэгмөсөн сайн засна гээд байгаа юм. Тэрийг чинь хүлээж аваад орон нутгийнхан тэгвэл бид нар өөрснөө тэрнээсээ анх төлөвлөж байсан 110 хэдэн саяасаа бага 10, 15 орчим сая төгрөгт ядаж энэ жилийнхээ усалгааны ажлыг зохицуулах, засвар үйлчилгээг нь хийчихье гэсэн ийм санал тавьсан. Бас боломж байхгүй гэсэн хариу өгсөн юм байна лээ. Борнуур бол улсын хэмжээний зөвхөн тэр сумын асуудал биш аймгийн, улсын хэмжээний хүнсний хангамж ялангуяа төмс, хүнсний ногооны хангамжид маш том үүрэг гүйцэтгэдэг ийм сумдын нэг.

Тэгээд ийм сум байхад энэ дээрээ тэр 400 саяасаа бага ч гэсэн хөрөнгийг нь гаргаад тэр юмыг нь засаад өгчих боломж байхгүй юу? Энэний цаана 400-гаад өрх Борнуур сумын тэр усан байгууламжаас хойшоо сувгийнх нь дагуу тариалан эрхэлдэг олон зуун хүний ажил,

амьдралтай холбоотой. Дээр нь төмс, хүнсний ногооны чинь ургацын баланстай холбоотой ийм асуудал гарах гээд байна. Үүнийг та нар анхааралдаа авсан уу? Тэгээд хариу өгсөн болоод хаясан уу? Энэ дээр нэг хариулт өгөөдхөөч. Гурав дахь удаагаа, дөрөв дэх удаагаа энэ асуудлыг тавьж байна шүү.

Ажлын хэсэг 7 дугаар микрофон.

Т.Жамбалцэрэн: Ундрам гишүүний асуултад гүйцээгээд хариулъя. Энэ оны төсөв дээр Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын багц дээр 1.8 тэрбум суусан юм. Сантын сургуулийн хувьд Хөдөө, аж ахуйн их сургуультай бид нар ярьж үзсэн юм. Хөдөө аж ахуйн их сургууль өөрөө элсэлт нь нэлээд хүндрэлтэй, хангалттай хэмжээний оюутан, суралцагч элсдэггүй ийм нөхцөл байдалтай.

Дээр нь салбар хэд хэдэн сургуулиудтай орон нутагт байгаа Баянхонгорын сургууль, Сантын сургууль гээд эдгээр сургуулиудыг авч явахад боловсон хүчний асуудал, суралцагчдын эрэлт хэрэгцээний асуудал гээд тулгамдаж байгаа асуудал их байна гэдэг асуудал ярьсан. Энэ чиглэлээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцад суусан ийм зардал байгаа. Хүнсний хөтөлбөртэй холбоотой. Энэ чиглэлээр энийг зарцуулаад наад сургуулиа тэр үйлчлэх дундын төвтэйгөө уялдуулаад ингээд ажиллах бололцоогоо салбарынхаа яамтай ажиллаач гэдэг асуудлаар Хөдөө аж ахуйн сургуулийнхантай ярьж байгаа.

Н.Энхболд: Микрофон, 7дугаар микрофон.

Т.Жамбалцэрэн: Атрын 4 дүгээр аянтай холбоотой энэ Атрын 4 дүгээр аяны үр дүнгүүд тухайн жилд авч байгаа ургацын хэмжээ, тухайн жилд техник технологио шинэчилж байгаа хувь хэмжээ, машин техникийнх нь хүчин чадал, агуулах зорь, хүртээмж нэмэгдэж байгаа байдал гээд энэ олон

ээрэг үзүүлэлтүүд гарч байгаа. Зөвхөн 22 оны байдлаар гээд л тэгэхэд агуулахын багтаам жодоо 1.5 мянган тонноор нэмэгдсэн байх жишээтэй. Техник технологийн шинэчлэл 2.6 хувиар өссөн байх жишээтэй. Ийм дүнгүүдийг дурдаж болно.

Энхболд даргын асуулт дээр бид нар Борнуурын чиглэл дээр манай яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрынхан тухайн газар дээр нь ажигласан. Түрүүний хэлдэг 400 сая гэдэг бол арилжааны банкны эх үүсвэрээр аж ахуйн нэгжүүд олгох ийм зээлийн эх үүсвэр. Нийтдээ 1 их наяд төгрөг үүний 400 орчим нь одоо газар тариалангийн салбарт олгогдох ийм зохицуулалттай явж байгаа.

Одоо улсын төсөв дээр энэ засвар үйлчилгээ хийх чиглэл дээр одоо төсөвлөгдсөн хөрөнгө байхгүй. Бид Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа усалгаатай газар тариалан төслийн хүрээнд нийт улсын хэмжээнд 12 услалтын систем барьж байгуулах ийм төлөвлөгөөтэй байгаа. 1 услалтын систем байгуулах ажил талбайн хэмжээ нь тухайн технологийг ашиглах бололцоо муутай юм гэдэг дээр дахин өөрчлөлтийг хийж байгаа.

Энэ хүрээндээ Борнуурын, Хэнтий гэдэг юм уу тодорхой бүс нутгуудад байршлыг сэлгээд зохицуулалт хийх ийм боломжийг судалж байгаа. Ойрын хугацаанд тухайн төслийн удирдах хороо хуралдаад тодорхой шийдэл гарах байх гэж бодож байна. Энэ чиглэлээр бас танд албан ёсны мэдээг бичгээр хүргүүлнэ.

Н.Энхболд: Одоо ингээд борооны улирал эхлээд, шар усны үер эхлээд ингэхээр нөгөөдөх чинь урсаад эхэлбэл засах боломж нь байхгүй болчихдог юм байна лээ шүү дээ. Тэгээд энэ тоо, хугацаа юмаа та нар сайн бас тооцож үзээрэй. Тэгээд энэ чинь бас том асуудал болчих

гээд байгаа шүү. Нөгөө хүнсний хөтөлбөрт хуртэл нөлөөлөх.

Цогтгэрэл гишүүн асууя.

О.Цогтгэрэл: Засгийн газрын үйл ажиллагааны тайлан гээд хуудсыг нь үзэхээр өөр 500-гаад хуудас материал байна л даа. Өчигдөр ирсэн 8 өнөөдөр хэлэлцээд, дүгнэлт гаргаад ингээд Байнгын хороогоор явна гэдэг үнэхээр бас цаг хугацааны хувьд зүгээр бид нар энийг хэлэлцэн болоод өнгөрөх ийм л нөхцөл байдлууд харагдаж байна. Энэ дээр байгаа тоо баримтуудыг харахлаар би заримыг нь андуураагүй бол өссөн дүнгээрээ гэдэг нь 20-24 оны Засгийн газрын үйл ажиллагааны биелэлт нь 30 гаруй хувьтай, 22 оны биелэлт өөрөө 60 хувьтай гэсэн ийм тоонууд харагдаж байна.

Тэгэхээр 60 хувь гэдэг чинь сурагчийн дүнгээр бол юу билээ? Дахиад 20-24 он, одоо 23 он гарчихсан байдаг 20-24 оны биелэлт 30 хувьтай гэдэг чинь үлдэх хугацаанд энэ бусад амласан амлалт, тавьсан ажил, төлөвлөсөн төлөвлөгөөг биелүүлэх боломж бололцоо олон зүйлүүд нь байдаг юм уу, үгүй юм уу? Үүний цаана нэг ийм учир шалтгаан бас байна уу? Энэ 500 хуудас тайлан дээр хэдэн мянган ажил ингээд биччихсэн энэ бүгдийг төр хийх ёстой гээд тэнд онол, ном л гаргаад биччихсэн. Энэ маань өөрөө хэр зэрэг зөв зүйтэй зүйл юм бэ?

Харин эндээс асуух гэж байгаа асуулт нь Хүрэлбаатар сайдаас ер нь манай Монгол Улсын эдийн засаг дахь төрийн оролцоо гэдэг үзүүлэлт хэрхэн яаж гарч байгаа вэ? Өнөөдөр хэдэн хувь байгаа вэ? Ямар ч байсан сүүлийн үеийн тоо баримтууд олон зүйлүүд дээр төрөөс эдийн засагт оролцож байгаа оролцоо төсвийн оролцоо жилээс жилд нэмэгдэж байгаа. ТӨК-удын төсөвт эзэлж байгаа хувь, хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа. Энэ бүх зүйлүүдийн цаана чинь л энэ олон зуун хуудас тайлан, олон зуун хуудас төлөвлөгөө тэгээд 60 хувийн

биелэлт, 30 хувийн биелэлт. Тэгээд одоо энэ дээр хариуцлага ярих юм уу, ярихгүй юм уу? 60 хувьтай сурагч дүн авсан сурагч бол бас л их эцэг эхээсээ хүртэл их хариуцлага яригддаг байх. 60 хувьтай ажлаа биелүүлж байгаад Засаг Их Хурлын өмнө ямар хариуцлага байдаг юм?

Тэгээд үүний учир шалтгааныг одоо яг юу гэж оношилж байгаа юм? Миний бодлоор бол явсаар явсаар байгаад тэр төрөөс эдийн засагт оролцоогоо яаж харж байгаа юм бэ? Энэ хөтөлбөрүүдэд яаж байсан? Дахиад дээрээс нь 22 онд төрийн өмчийг хувьчлах бодлого гээд баахан жагсаалтууд гарч байсан. Тэдгээрийн үр дүнгүүд юу болж байгаа? Тэр үр дүнгүүдийн хүрээнд яг энэ төрийн эдийн засаг дахь оролцооны асуудал хандлага маань яаж байгаа юм? Энэ бүгд дээр тодорхой хариулт өгөөч.

Бид нар бол ингээд харахаар их тийм баахан ингээд энийг харж байгаа тоо баримт хараад шүүмжилбэл зүгээр асуудлын илрэлийг баахан хүмүүс тойрч ярих болоод байдаг. Донхиход салхин тээрмийг тэр цавчилдаг шиг л, цаад тэр энерги, цаад урсац, цаад нөлөөлж байгаа хүчин зүйлүүд рүүгээ гол нь юу гэж харж байгаа вэ? Тэрнээс орж ирсэн энэ 500 хуудас тайлан дээр айхтар хоногийн дотор дүгнэлт хийгээд супер супер юм баахан юм яриад эндээс энэ тайлангууд чинь сая гишүүд ч бас өөрснөө яриад байна. Санхүүжилтийн асуудлаа шийдээгүй түвшинд байгаа төсөл, хөтөлбөрүүдийн гүйцэтгэл нь 60 хувьтай, 66 хувьтай гээд биччихсэн байна гээд л тойргийн ажлуудаа ч гэсэн зарим нь ярьж байна. Тэгэхээр энэ тоо баримт бол үнэхээр энэ дээр бол ач холбогдол өгч айхтар яриад байх зүйл бол хэцүү байна.

Тэгэхээр учир шалтгаан талаасаа, болоод хандлага талаасаа, бодлого талаасаа 22 оны тэр тавьсан зорилтууд талаасаа зарим тайлбаруудыг өгөөч.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс хариулах уу? Хүрэлбаатар сайдын микрофоныг нээе.

Ч.Хүрэлбаатар: Ер нь энэ төр, хувийн хэвшилээ хамгийн сайн хийж чаддаг зүйлүүд дээр төр оролцоод байх шаардлагагүй гэдэг ийм бодлогыг Засгийн газар хатуу барьж явж байгаа.

Ер нь ч сая бид нар энэ нүүрсний асуудалтай холбоотой юм, төр дээр тэгээд ил тод биш байдаг зүйл ямар их том асуудал дагуулдгийг бид нар бүгдээрээ харсан. Тэгэхээр төрийн өмчит аж ахуй нэгжүүдийг хувьчлах үүнийг ялангуяа Хөрөнгийн биржээр дамжуулж явуулах ийм ажлыг нэлээн цаашид идэвхтэй хийж явах ёстой. Шинээр ямар нэгэн төрийн өмчит аж ахуй нэгж байгуулахгүй, байгаагаа хувьчлах ийм бодлогыг цаашидаа нэлээн хатуу баримталж явна.

Тэгээд хувийн хэвшлийн гэхдээ би нэг зүйл дээр санал нэг байна. Хувийн хэвшлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ 80, 85 хувьтай байсан. Сүүлийн тооцоонуудыг харахад хувийн хэвшлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ бол 75 орчим хувь болж буурсан байж байгаа. Тэгэхээр энэ нь цаанаа юу байна вэ гэхээрээ нөгөө уул уурхай дээр холбоотой төрийн өмчийн аж ахуй нэгжүүдийн тухайлбал, Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Тавантолгой, Оюутолгой 3 хувь, 34 хувь нь төрд байх байдаг.

Тэгэхээр эд нарын үйлдвэрлэлийн хэмжээ өсөөд байгаа учраас энэ төрийн эзлэх хувь хэмжээ өндөр харагдаж байгаа. Ер нь цаашидаа бол, ер нь хувийн хэвшил хамгийн сайн хийж чаддаг зүйлүүдийг төр оролцохгүй, төрийн өмчит аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа бол ил тод, нээлттэй, борлуулалт, тайлан, эд нар нь ил тод байх ийм зайлшгүй шаардлага байгаа гэдгийг хэлмээр байна. Ингээд саяын хэлсэн тоонуудыг хариуллаа.

Ц.Цэрэнпунцаг: Цогтгэрэл гишүүнд микрофоныг нээе, 1 минут нэмж өгье.

О.Цогтгэрэл: Тэгэхээр саяын тоонууд болоод тэр ажлуудыг ингээд сонсоход 22 оны төлөвлөгөө дээр хэдэн билээ аж ахуй нэгжийг хувьчилна, олон нийтийн оролцоотой болгоно. Тодорхой хэрэг биржид гаргаад жишээ нь энэ дотор хэдэн ямар ч ашиггүй гэх юм юм уу, цаашидаа ч ашиг олох боломжгүй хэдэн ... компани гэх мэтийн хэдэн аж ахуй нэгжүүд харагдаж байсан.

22 онд хувьчлах олон нийтийн оролцоотой болох тэр аж ахуй нэгжүүдийн жагсаалтын тэрний биелэлт яг хэдэн хувьтай, хэд нь олон нийтийнх болсон юм? Хэд нь хувьчлагдсан юм, хэд нь тодорхой хэмжээгээр бирж дээр гарсан юм? Энэний үр дүн яг юу болсон бол?

Тэгэхээр 22 онд авах арга хэмжээний жагсаалтад тодорхой хэмжээний яг нэр бүхий аж ахуйн нэгжүүдийн санаж байгаагаар 30 гаран ч билүү аж ахуй нэгжийн жагсаалт байсан шүү дээ. Яг энэний биелэлтийн тухай мэдээлэл өгөөч.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Ажлын хэсэг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар байхгүй тийм ээ? Засгийн газрын Хэрэг эрхлэхээс байна уу? Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг нээе.

Б.Баасандорж: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр болон 22 оны төлөвлөгөөг сая Цогтгэрэл гишүүн хөндөж байна. Яг нийт дүнгээрээ 22 оны хувьд авч үзвэл 69.8 хувьтай буюу өссөн дүнгээрээ 39.3 хувьтай байгаа.

Гэхдээ 20 оноос өнөөдрийг хүртэл 2.5 жилээр нь үзэх юм бол яг 39.3 хувьтай. Одоо яг үл бүтэн 2023 он байгаа. Үүний

хэрэгжилтийг дахиж ярина. 24 оны хэрэгжилт яригдана. Ингээд үзэхээрээ үлдсэн хугацаанууд дээр бас нэлээд ажлуудыг 4 жилийн хугацаандаа төлөвлөсөн байгаа. Яг нарийвчлаад аваад үзэх юм бол КОВИД-19 цар тахал буюу нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын ажил бол 83.1 хувь буюу өссөн дүнгээрээ 60.3 гэдэг юм уу, хүний хөгжил 63.9 өссөн дүнгээрээ 33.3 гэдэг юм уу ийм 7 бодлогын хүрээнд бас ингээд нарийвчлаад юунууд байгаа.

Та бас хариуцлагын асуудал ярьж байна. Хариуцлагын асуудал бол чухал сая гишүүд.../минут дуусав./

Ц.Цэрэнпунцаг: Цогтгэрэл гишүүн та тодруулж асуух уу? Тодруулж 1 минут авах уу, тодруулж асуух уу? Хариулт энэ чинь хэдэн минут өгсөн юм бэ? 3 номер нэмж хариулах уу? Эсвэл та тодруулчхаад дараа дахиад хариулчих уу? Цогтгэрэл гишүүнд тодруулж 1 минут өгье. Тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Саяын тэр 69 гэдэг тоо гарсныг харахад тэрний 95 хувьтай нэг үзүүлэлт байгаа юм. Тэр нь КОВИД-ыг даван туулах КОВИД дотроо вакцинд 100 хувь хамруулсан гэдэг үзүүлэлт чинь бараг 69 гарахад чинь аймаар том нөлөө үзүүлчихсэн байгаа байхгүй юу. Бусад нь бага. Тэгээд бодоход жилийн дүн чинь 60 хувьтай. Дахиад тэр өссөн дүнгээр гэлээ 23 он гарчихсан байхад Засгийн газрын 4 жилийн хөтөлбөр чинь 30 хувьтай байна шүү дээ. Нөгөө хэдэн жилийн өмнө социалист хөдөлмөрийн баатар болохын тулд 1 жилд 5 жилийн ажил хийлээ гээд гэдэг шиг үлдсэн хугацаанд та бараг 3, 4 жилийн ажил хийж байж наад төлөвлөгөө чинь хүрэх юм уу? Бараг хүрэхгүй одоо.

Тэгэхээр хариуцлагын асуудал гэдэг дээр та бас нэг зүйл хэлчихвэл.

Хоёрдугаарт нь тэр 22 онд хувьчлагдах олон нийтийн оролцоотой болох компаниудын тавьсан

төлөвлөгөөний биелэлтийн тухай л тодорхой зүйл асуусан л даа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер Баасандорж тэр аж ахуй нэгжүүд хэчнээнийг хувьчилна гэгчихсэн юм? Хэчнээн нь хувьчлагдаж байгаа юм? Үүний явцыг асуугаад байна шүү дээ. Түүн дээр тодорхой хариулаад өгөх боломж байгаа юм уу? Сайн тодорхой хариулаарай.

Б.Баасандорж: 2 асуулт асуулаа. Би Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Тэр хариуцлагатай асуудлыг тодруулаарай гэж байна. Яг одоо би тэр сая нарийвчилсан дүнгээр нь хэлсэн. Эдийн засгийн бодлого, засаглалын бодлого, ногоон хөгжлийн бодлого өссөн дүнгээрээ ингээд яг 7 бодлогын хүрээнд яг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа. Энэ өргөн мэдүүлэх энэ процесс бол өөрөө Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан журмын дагуу явсан. 2 сарын 1-ний дотор Засгийн газар хэлэлцээд Үндэсний аудитын газар, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлдэг.

3 сарын 15-нд энэ яг бүх баримт бичгүүдийг өргөн мэдүүлсэн байгаа. Яг үүний дагуу ингээд өргөн мэдүүлэхэд зарим зүйлүүд дээр тантай санал нэг байна. 39.3 хувь гэдэг бол одоо 50-60 хувьтай явж байхад харьцангуй бага үзүүлэлттэй хэрэгжилттэй явж байгаа.

Гэхдээ үлдсэн жилүүд дээр нэлээд ажлуудыг шахаж хийхээр төлөвлөсөн байгаа. Хариуцлагын асуудал бол маш тодорхой байдаг. Засгийн газрын энэ бодлогын баримт бичиг.../минут дуусав./

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээгээд хариулчихъя. 3 номер дээр гүйцээгээд хариулъя.

Б.Баасандорж: Хариуцлагын асуудлыг бол Засгийн газраас баталсан энэ бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн яаж

үнэлэх юм, дүгнэх юм. Хэрвээ энэ асуудлыг хэрэгжүүлээгүй холбогдох салбарын хүмүүст ямар хариуцлага тооцох юм гэдэг 2020 оны 206 дугаар журмын 12 дугаар бүлэгт заасан хариуцлагын асуудал байдаг.

Жишээлбэл одоо яг яригдаж байгаа энэ бодлогын баримт бичгүүдийг үйл ажиллагааны үнэлгээг нь хангалтгүй үнэлгээ авсан, эс үгүй бол эдийн засгийн нийгмийн хөгжлийн үзүүлэлт нь буурсан яамны холбогдох сайд, холбогдох албан тушаалтан болон Засаг дарга нар болон холбогдох төрийн байгууллагын албан тушаалтнуудад хариуцлага тооцох асуудлыг маш тодорхой зааж өгсөн байдаг. Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудаар нь.

Та мөн хувьчлалын асуудлыг сая хөндлөө. 2022 онд хэд хэдэн хувьчлалын асуудлыг яг энэ төсөл дээр, төлөвлөгөө дээр суулгаж өгсөн байгаа. Үүнээс ингээд дурдах юм бол үүнд Монголын хөрөнгийн бирж, Монголын цахилгаан холбоо, Мэдээлэл холбооны сүлжээ, Мэдээлэл технологийн үндэсний парк төрийн өмчит үйлдвэрийн энэ компаниуд гэх мэт энэ хуулийн этгээдүүдийн хувьчлалын асуудлыг нь шийдвэрлэсэн байгаа. 2022 онд. 20 онд туссан туссан төлөвлөгөөний дагуу. Төрийн өмчийн бодлого зохицуулалтаас байвал нэмчхээрэй.

Ц.Цэрэнпунцаг: Нэмж хариулах ажлын хэсэг дээр байна уу? Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирсэн юм уу? Байхгүй байна. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр улсын хилийн аюулгүй байдал болон батлан хамгаалах салбарын аюулгүй байдалтай холбоотой асуултауд байна.

Дэлхий дахинд геополитикийн нөхцөл байдал өөрчлөгдөж, хөрш орон дайны нөхцөлд татагдан орсон энэ цаг үед Монгол Улсын аюулгүй байдал тэр

дотор батлан хамгаалах болон хилийн аюулгүй байдлыг бид нар эргэн харах шаардлагатай технологийн болон бусад шинэчлэлийг цаг алдалгүй хийх шаардлагатай байгаа. Хууль зүйн байнгын хорооны гишүүд бид ажил үүргийн шугамын дагуу хилийн заставууд дээр ажиллаж ирсэн.

Энэ хугацаанд ингээд харахад бол Монгол Улсын хил хамгаалах систем хилийн хамгаалалт дахь технологи инновацын дэвшилийг яаралтай хийх шаардлагатай байна. Бид нар одоо хүний хүчээр буюу хилийн хэдэн цэргийнхээ хүчээр энэ хил хамгаалдаг байдлыг яаралтай засах хэрэгтэй байна. Хилийн зурвасын дагуу хамгаалалтын шинэ системүүдийг нэвтрүүлэх, хил хамгаалах техник хэрэгсэл, хүний нөөц, тэр дотор технологийн шинэ дэвшилийг яаралтай нэвтрүүлэх шаардлагатай байна. Цаг үеийг ч ингэж шаардаж байна. Бид нарт ерөөсөө энэ Засгийн газрын тайлан дотор улсын хилтэй холбоотой 8 зорилтот ажлууд 90-70 хувьтай хэрэгжсэн байх шиг байна. Тухайлан асуухад энэ улсын хил хамгаалалтын зориулалттай инженер техникийн байгууламжийг шинэчлэх ажил 90 хувьтай явж байна гэж байна.

Хэрвээ 90 хувьтай явж байгаа бол үнэхээр сайшаалтай. Энэ дотор яг ямар ажлууд хийгдээд байна? Бид нарын нэхээд л байгаа тэр хил хамгаалах шинэ технологи, хилийн зорилт инженерийн байгууламжууд маань хэр шинэчлэгдэв? Мөн хилийн заставуудын барилга объектуудын шинэчлэл 70 хувьтай гэж байна. Их олон удаа застав дээр энэ бас л хэцүү байгаа. Яг ямар шаардлагад хийгдсэн гэдэг Хууль зүй, дотоод хэргийн яам, Хил хамгаалах газраас байвал хариулах шаардлагатай.

Мөн хил хамгаалах асуудал аюулгүй байдал дээр хилийн цэргийн эхний нийгмийн асуудлууд, тэр дотроо хил хамгаалах албан алба ажилтнуудын нар гэрийнхний асуудал, тэнд сурч байгаа

хүүхдийн боловсролын асуудал бас хэцүү байдаг.

Тийм учраас Хил хамгаалах ерөнхий газраас хилчдийн нийгмийн хамгаалал гээд хөтөлбөр хэрэгжүүлж байгаа гэсэн мэдээлэл байгаа. Энэ хөтөлбөр хэр явж байгаа юм? Ер нь хил хамгаалах орчинд байгаа хүмүүсийн нийгмийн хамгаалал, хүний хөгжлийн гол индексийг бид нар бас зайлигүй төрөөс онцгойлон үзэх шаардлагатай. Энэ тал дээр хариулт авмаар байна.

Мөн Батлан хамгаалахын яамнаас энэ цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, технологи, инновацыг нэвтрүүлэх замаар батлан хамгаалах аж үйлдвэрлэлийн эхлэлийг тавина гэсэн. Энэ ажил 90 хувьтай гэсэн ийм тайлан байна. Тэгвэл энэ чиглэлээр ямар ажлууд хийгдэж байна? Монгол Улсын батлан хамгаалах салбар маань технологийн хувьд дэлхий дахины хөгжилтэй хэр ойртож чадах вэ? Энэ тал дээр Улсын Их Хурал хууль тогтоох байгууллагад шаардлагатай эрх зүйн болон ямар дэмжлэгүүд хэрэгтэй байна гэдгийг мэдээлэх хэрэгтэй байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс энэ яах вэ? Ажлын хэсгээс тэр хаана хаана тэр 7 номерыг суллагчхсан байна уу? 4 юм биш үү? 7 номерыг суллагчхсан байна. 7 номерыг нээгээрэй. Ажлын хэсэг 7 номер дээр ээлжлээд хариулаад явчихъя. Энэ хилийн цэргийнхнээс байна уу энд байна уу? Дараа нь хариулбал 7 дээр ээлжлээд хариулчхаарай. 7 номерыг нээе.

П.Сайнзориг: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бас нэг гол чиг үүрэг бол энэ Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах энэ чиг үүрэг байгаа.

Ер нь ойрын үед бас энэ самар жимстэй холбоотойгоор хил хамгаалалтын асуудал бас ярвигтай түвшинд бас энэ баруун бүсийн ялангуяа Сэлэнгэ, Булганы чиглэлээр Хэнтийн

чиглэлээр бас ярвигтай зүйлүүд одоо гарч байгаа. Энийг бас 2 улсын хилийн байгууллагууд хилийн төлөөлөгчийн шугамаар дор бүр нь шийдээд явах асуудлууд байгаа. Энэ дээр бид хэд бас яг асуудлуудын нарийн учрыг ингээд харахаар бас яг таны ярьж байгаа, хөндөж байгаа энэ асуудлууд бас зайлиггүй яригдана.

Өөрөөр хэлэх юм бол энэ хил хамгаалалтын асуудлыг бас хүний хүчээр хамгаалах гэхээсээ илүүтэй техник технологийн давуу талыг нэвтрүүлэх энэ чиглэлийн юмнуудыг нэлээн судалж байгаа. Бид хэд бас Францын болоод бусад Израил ч гэдэг юм уу, хэд хэдэн орнуудын энэ хил хамгаалалтын энэ технологи буюу энэ дулаан мэдэрч ойр орчмынхоо хилийн аюулгүй байдлыг бас хангах энэ чиглэлийн технологиудыг судалж бас гадаадын зээл тусламжийг бас Монгол Улсын хууль тогтоомжийнх нь дагуу шийдвэрлэх боломж юу байна гэдэг дээр нэлээн судалж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье.

Ер нь зүгээр хил хамгаалалтын тэр инженерийн барилга байгууламжийн асуудал энэ тэр бас тодорхой түвшинд ахицтай яваа гэдэг зүйл байгаа. Ер нь хойд хилээр бид нар бас энэ торон саад буюу энэ зүйлүүдийг нэлээн бас өргөжүүлж бас шинээр суурилуулах асуудал байгаа. Энэний ач холбогдол мэдээж хил хамгаалалтын зөрчлөөс гадна бас энэ салхи шуурга гэдэг юм уу байгалийн онц байдлын үед бас мал хуй бас хил давж гарах энэ нөхцөл байдлуудаас бас урьдчилан сэргийлэх бас хил орчмын айл өрхүүдийн бас эд хөрөнгийг хамгаалах энэ чиглэлдээ нэлээн чухал арга хэмжээ байдаг.

Хил дээр одоо бас нэгэн шийдэгдэх асуудлууд юу гэхээр энэ цахилгааны асуудал байгаа. Эргээд техник, технологи, инновацыг оруулахтай холбоотойгоор цахилгааны найдвартай эх үүсвэрийг шийдэхгүйгээр хилийг бас бас аюулгүй байдлыг бас технологи

нэвтрүүлэхэд бас хүндрэлтэй зүйлүүд байна. Өнөөдөр одоо 70 орчим хилийн заставууд өндөр хүчдэлд холбогдсон найдвартай эх үүсвэртэй 40 орчим хилийн застав бас сэргээгдэх эрчим хүчээр ажиллаж байна. 42 хилийн застав үндсэндээ дизель түлшээр буюу мотор асаасан байдалтай бид хэд ерөнхийдөө хил хамгаалалтын аюулгүй байдлыг хангаж байна.

Тэгээд цаашидаа энэ нь төр хувийн хэвшлийн түншлэл энэ хил дагасан аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотойгоор бас энэ зүйлүүдийг бас шийдвэрлэх арга замуудыг бас бид бас эрэлхийлж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье.

Дээрээс нь хил хамгаалалтын байгууллагын энэ асуудлыг хэт бас энэ цэрэгжсэн байгууллага гэхээсээ илүүтэйгээр бас хууль сахиулах чиглэл рүү нь орох, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, энэ чиглэлийнхээ чадавхыг нэмэгдүүлэх асуудлыг бид бас бүрэн судалж байгаа.

Мөн энийгээ дагаад бас нийгмийн асуудлыг зайлиггүй шийдэх асуудлууд байна. Эргээд энэ хилчдийг бас эрүүл мэндийн үзлэгт бас 1 удаадаа оруулах, явуулын гэдэг юм уу нэлээн тийм эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх боломжтой бас явуулын энэ лаборатори, эмнэлгийг бас бий болгох энэ асуудлыг бид бас судалж байгаа.

Ер нь цаашидаа бас Австрийн хөнгөлөлттэй зээлээр бас энэ асуудлыг шийдвэрлэх ингэж байж хилийн байгууллагад бас ажиллаж байгаа алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн асуудлыг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх гэх зэрэг бас олон асуудлууд шат дараатайгаар хийхээр ингээд төлөвлөж байгаа.

Энэ онд бас Монгол Оросын Холбооны Улсын хилийг шалган баталгаажуулах ажил бас хийгдэж, Гадаад хэргийн яамтай бас нэлээн

иуурхай хамтран ажиллаад явж байгаа. Хойд хил орчмын бас энэ баганыг шинэчлэх буюу эргээд энэ торон саад бүх зүйлүүдээ бас эргэж нягтлах энэ зүйлүүд дээр бас Засгийн газрын түвшинд бас шат дараатай арга хэмжээнүүдээ аваад явж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Тийм байна. Ажлын хэсгийн 1 номер дээрээс нэмж хариулъя. 1 номерын микрофоныг нээе.

Д.Ганхуяг: Батлан хамгаалахад яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал гишүүний асуултад хариулъя.

Ер нь батлан хамгаалах салбарын зэвсэг техникийн шаардлага үүсээд байгаа. Энэ геополитикийн ч хүрээнд өнөөдрийг хүртэл ямар нэгэн шийд шинэчлэж аваагүй. Бид Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр танилцуулгаа хийсэн. Төсвөөс, улсаас одоо сумны үйлдвэрийг хөрөнгө оруулалт дээр тавьж өгсөн. Бид одоо сумны үйлдвэрийг 10 сар гэхэд бүрэн ашиглалтад оруулна. Дотоодынхоо хэрэгцээнд сум, галт хэрэгслээ үйлдвэрлэдэг болно.

Мөн батлан хамгаалах салбар нийт 39 оронтой цэргийн хамтын ажиллагаатай ажилладаг. Энэ хүрээндээ бид одоо өөрсдийн бололцоогоо ашиглаж энэ хүн нэг бүрийн зэвсэг техникээ шинэчилж байна. Хүн нэг бүрийн буудлагын зэвсгийг шинэчилж байна.

Мөн бид 25 нэгж хуягт тээвэрлэгчийг өөрсдөө дотоод бололцоогоо ашиглаж үйлдвэрлээд бүх шаардагдах зөвшөөрлийг нь авчихсан. Өнөөдөр Нэгдсэн Үндэстний байгууллагад түргэн байрлах хүчний рот үүрэг гүйцэтгэхэд бэлэн. Мөн 2 дугаар шатны эмнэлэг мөн бэлэн. Бид 2 дугаар үеийнх нь шалгаралт дээр явж байгаа. Ийм байдалтай байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Би тэгвэл өөрийнхөө асуулыг асуучихъя. Энэ жил

бид нар анх удаагаа энэ 2 Байнгын хороо ингээж хамтарч 1 жилийн энэ Засгийн газрын үйл ажиллагаа, 1 жилийн хийсэн ажлын тайланг нь сонсож байгаа юм. Энэ бол урьд өмнөхөөсөө дэвшилттэй. Өмнө нь одоо Эдийн засгийн байнгын хороон дээр энэ тайланг хальт сонсоод өнгөрдөг байсан бол энэ жил энэ шинэ дэгийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулиар бид нар бас энэ дэвшилттэй энэ бас тайланг нь ингээж бас нэлээн дэлгэрэнгүй сонсож байгаа юм.

Тэгэхдээ зарим гишүүд маань бас энэ дэндүү богино хугацаатай байна, энэ шахуу байна гэж түрүүн Баттөмөр гишүүн бас саналаа хэлсэн. Тэгэхээр ер нь цаашидаа хэрвээ гишүүд маань энийг нэлээн дэлгэрүүлж чиглэл чиглэлээрээ Байнгын хороодоор нь хэлэлцүүлж оруулж өгье гэвэл бид нар дэгийнхээ хуульд, хяналт шалгалтынхаа хуульд тийм өөрчлөлт оруулаад энэ 4 сарын, 3 сарын 15-нд өргөн мэдүүлж 4 сарын 1-ний дотор хэлэлцэх ёстой. Үүнийг цааш нь бас хугацааг нь сунгаад ингээд тавиу хэлэлцэж болох юм гэсэн санал байна.

Асуултаа оръё. Энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд дунд байгаа 9 зорилтын 3 дээр байна уу? Энэ амьдралын чанар ба дундад давхарга гэсэн энэ нэг зорилт байгаа юм. Үүний хүрээнд хүрээнд дундад давхаргыг дэмжсэн санхүүжилт хийгдсэн байна. 22 аравны бараг 23 тэрбум төгрөгийн зээл олгогдсон юм байна. 11.8 тэрбум төгрөгийн зээлийн баталгаа гаргажээ. Тэгээд эд нар энэ үр дүнг нь бас жоохон шалгуур үзүүлэлт үр дүнг нь, тайланг нь тавихдаа ямар үр дүн гарсан гэдэг нь жоохон тодорхой байвал зүгээр санагдаад. Энэ дээр зүгээр асуулт байгаа юм.

Энд 1250 ажлын байр шинээр бий болсон. 4226 ажлын байрыг хадгалсан гэж. Тэгэхдээ энэ дундаж давхарга дотор байсан хэчнээн айл өнөөдөр энэ дундад давхаргад орж байдаг юм? Яг нарийн тоо

нь хэд байгаа юм? Тэрнээс энэ хөтөлбөрүүдийг, энэ 2 хөтөлбөр байгаа байхгүй юу. Энэ санхүүжилт хийгдсэн энэ 2 төрлийн санхүүжилтээр хэчнээн нь энэ дундаж давхаргад байсан нь тэндээ үлдсэн юм? Эсвэл дундад давхаргаас доош орлоготой хэчнээн айл нь дундаж давхарга руугаа орж ирсэн юм? Үр дүнд нь. Зарим нь бүүр дундаж давхаргаасаа дээшээ гараад өндөр орлоготой өрх айл болоод явчихсан юм уу? Энэ дээр тодорхой тоо баримт байна уу? Энэ үзүүлэлтээ нарийн хэлбэл их тодорхой сайхан үр дүн нь харагдах юм байна гэж бодож байна.

Хоёрт энэ бүтээн байгуулалтын хэдэн том төсөл байгаа. Энэ одоо мэдээж олон жил ингэж үргэлжилдэг төслүүд. Тэгээд энэ 1 жилийнхээ дотор энэ 22 ондоо том том төслүүд энэ том төслүүдийг нь мэдээж хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа энэ төслүүдийг мэдээж бид нар ярихгүй. Засгийн газрын, гадаад болон өөрийн эх үүсвэр, зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа энэ газрын тос боловсруулах үйлдвэр мэтийн, Дарханы арьс ширний боловсруулах үйлдвэр мэтийн төслүүдийн явцыг та нар юу гэж дүгнэсэн юм бэ?

Ер нь мэдээж энэ бид нар Эдийн засаг, хөгжлийн яамтай болсон. Хөгжлөө төлөвлөдөг бодлоготой болсон. Тэгэхээр зэрэг энэ том төслүүд урьд өмнө дандаа удаан хугацаанд хугацаа хэтэрдэг, төсөв хэтэрдэг, зардал ихтэй араас нь хэл ам их дагуулдаг. Энэ муу талаас нь авч үзэх юм бол бид нар ийм том төслүүд голдуу эцэстээ хэрэгжсэн хойноо сайхан үр дүн авчирдаг, бүгд л их хэрэглэдэг, үр өгөөжөө өгдөг.

Тэгэхдээ энэ удаан хугацаанд гардаг учраас шүүмжлэл их дагуулдаг, голдуу муу үр дүн, муу талаас нь их яригддаг учраас одоо та бүхэн энэ дээр сайн дүгнэлт гаргасан байх. Тэгээд энэ дүгнэлтүүдийг та нар яг тодорхой дүгнэлт хийсэн? Яагаад төсөв хэтэрдэг юм, яагаад хугацаа нь удааширдаг юм?

Тэгээд эд нарыхаа та бүхэн оношилсон юм бол цаашидаа энийг засахын тулд ямар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж энэ төсөл хөтөлбөрүүдийг үр ашигтай богино хугацаанд төлөвлөсөн хугацаандаа төсөвлөсөн төсөв дотроо хэтрүүлэх үр дүнтэй ийм сайхан өгөөжтэй болгож хэрэгжүүлэх юм бэ гэж ямар бодлого тусгаж хэрэгжүүлж ажиллаж байна гэсэн асуулт тавина.

Ц.Цэрэнпунцаг: Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ярих байх.

Ер нь 22 онд бас тийм амаргүй л жил байсан. Гэхдээ Засгийн газрын хувьд хийж дуусгасан ажлууд гэвэл нийтдээ 470, 80-аад километр төмөр зам байж байгаа. 1 нь Гашуунсухайт чиглэлийн төмөр зам байж байна. Мөн Зүүнбаянаас Ханги руу чиглэсэн ийм төмөр замууд энэ 22 онд бүгдээрээ баригдаж дууслаа. Дээр нь бүх аймгийн төвүүд бол автомашины сүлжээгээр бүрмөсөн холбогдсон босоо тэнхлэгийн замууд. Мөн хийгдсэн зэрэг ийм дэд бүтцийн чиглэлийн ажлууд одоо нэлээдгүй бас явагдсан гэдгийг би энд онцолж хэлмээр байна.

Үүнтэйгээ холбогдуулаад улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр тавигдсан нэлээдгүй бас хөрөнгө оруулалтууд хэрэгжээд явж байгаа гэдгийг хэлье. Яг Ганбат дарга та яг юуг нь хариулаадхаач улсын төсвөөс хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлууд, Дарханы за эд нарыхаа бас оруулаад ярьчихъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 1 номер дээр Ганбат даргаа очоод хариулчих. Улсын төсөв гадаадын зээл тусламжаар хийгдэж, ажлын хэсгийн 7 номерын микрофоныг өгье. Том төсөл бүтээн байгуулалтынхаа төслүүдийг сайхан хэлээд өгөөрэй.

Ж.Ганбат: Асуултад хариулъя. Томоохон төслүүдийг бид өнөөдрийг хүртэл явж ирсэн арга бол бид гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр гэдэг ийм байдлаар санхүүжүүлж байсан. Гэхдээ энэ дээр асуудлууд бас үүсэж байна. Хөрөнгийн амаргүй байдал эх үүсвэрийн талд. Жишээ нь газрын тосны боловсруулах үйлдвэр дээр бид нийтдээ Энэтхэгийн хөнгөлөлттэй зээлээр ингээд 17-2025 онд гээд энэ зээлийн төслийг хэрэгжүүлж байгаа. Үүн дээр нийт төслийн өртгөөсөө бид 2023 онд 107.8 тэрбум төгрөгийг бид нар санхүүжүүлнэ гээд ингээд тооцсон. Энэ дээр 23 онд хийгдэх ажлууд нь үйлдвэрийн анхдагч процессын болон дагалдах байгууламж, үйлдвэрийн цахилгаан станц гээд төслийн менежмент гээд ийм байдлаар ажилласан.

Гэхдээ энэ дээр яг хэрэгжилтийн явцад болон нөгөө гаднын Энэтхэгийн бас хөнгөлөлттэй зээл учраас бас эдний Засгийн газрын бас энэ дээр эх үүсвэрээ нэмэлт дайчлах гээд ийм асуудлууд дээр асуудлууд үүсээд байгаа.

Гэхдээ энэ дээр бид энэ асуудлыг саяхан Засгийн газрын хуралдаан дээр яриад үүнийг гүйцэтгэгчийн хувьд бас Эрдэнэс Монголын харьяанд өгөөд энэ дээр бас нэмэлт эх үүсвэрүүдийг цаашид санхүүжилт хийх тийм боловсронгуй болгох талд нь анхаараад ажиллаж байгаа. Бид өнөөдрийг хүртэл явж ирсэн улсын төсөв дээр ингээд томоохон гаднын ингээд Газрын тос боловсруулах үйлдвэрийн Дарханы арьс шир боловсруулах үйлдвэр, Дарханы зам, Азийн хөгжлийн банк гээд, мөн Дарханы зам дээр чинь дахиад Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр ингээ гээд явж байгаа юмнууд дээр бид бас тодорхой хэмжээгээр гүйцэтгэлүүдийг нь шахаад энэ дээр яг хэрэгжилтийн явц гадна, дотно гэхгүй улсын төсөв гаднын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл дээр ханишийн өсөлттэй холбоотой, үнийн

өсөлттэй дарамтууд орж ирж байгаа учраас энэ дээр дээр. Бид бас шийдлүүдээ зөв гаргаад гаднын энэ санхүүжүүлэгч байгууллагуудтай ойлголцоод энэ төслүүдийг аль болох шахаад явж байгаа.

Нөгөө талдаа бид дандаа ингээд гаднын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлээд яваад байгаа гэх дээр нөгөө сая Улсын Их Хурлаар батлагдсан Төрийн түншлэлийн хууль гээд батлагдчихсан. Бид санхүүжилтийн хувьд томоохон төслүүд.

Ер нь цаашид энэ төслөө төр түншлэлээ энэ хуулийн дагуу явуулахаар бэлтгэл ажлаа хангуулаад, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хэрэгжих төслүүдийг энэтэй уялдуулж ингэж явж ирэхгүй бол бид гаднаас зээл тусламжаар санхүүжүүлэх эх үүсвэрүүдээ ярих гэж хугацаа алдах, авсан хойноо бас ийм юун дээрээ үнийн өсөлт энэ тэр үүсээд иймэрхүү байгаа учраас бид одоо эх үүсвэрийн хувьд болон энэ санхүүжилтийн хувьд бид нар төрийн өмчийн түншлэлийн хуулиар энийгээ хэрэгжүүлэх ийм юмнууд дээрээ түлхүү ажиллахаар “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдуулаад энийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.

Нөгөө талдаа бид нарын гол алдаа бол тэр төсөл хэрэгжихэд ингээд бэлэн болчихсон байх ёстой. Тэр төслийн бэлтгэл ажлыг бид маш сайн хангаж энэ салбарын яамнууд яг бэлэн болоод энэ төсөл явахад бэлэн боллоо гэсэн асуудлуудынхаа дараа бид төрийн өмчийн түншлэлийн хуулиар явах юм уу, ямар эх үүсвэрээр явах вэ гэдэг энэ юм. Нөгөө талдаа бас тэр төслийн үр ашгийн хувьд бас тооцож үзэж байх гээд тэгээд энэ дээрээ илүү түлхүү анхаарч ажиллаж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: 1 асуулт дундад давхаргын талаар нь тоо асуусан байгаа хэн хариулах вэ? Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн

дарга Өнөрбаяр дарга хариулах уу? 7 номер дээр хариулъя.

Г.Өнөрбаяр: Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны яам Өнөрбаяр. Нийгмийн дундаж давхаргыг тэлэх бодлого бол зөвхөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны асуудал биш. Бүх төрийн байгууллага, институцийн хүрээнд ярих ёстой. Эдийн засгийн өсөлттэй уялдаж яригддаг асуудал. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт гээд олон салбарын хүрээнд яригдана.

Засгийн газрын хувьд өнгөрсөн жилийн хугацаанд нийгмийн дундаж давхаргыг хамгаалах олон бодлого хэрэгжүүлсэн. Тухайлбал 10 их наядын зээл, КОВИД-ын үеийн нийгмийн хамгааллын бодлогуудыг бас ярих ёстой. КОВИД-ын үед бид нар ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн нийгмийн хамгааллыг сайжруулахын тулд 873.7 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлт, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого бас хэрэгжүүлсэн.

Өнгөрсөн жил бид нар бүх хүүхдэд нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлээд бүх хүүхдэд хүүхдийн мөнгө өгсөн. Нийгмийн зорилтот бүлэгт хүнсний талоны бодлого хэвээрээ үргэлжилж байгаа.

Мөн хүнсний талонд хамрагдаж байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийг бүгдийг нь ажил хөдөлмөрт зуучлах энэ бодлогыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам авч хэрэгжүүлж байгаа.

Өнгөрсөн хугацаанд халамжийн бүх бодлогуудад дүгнэлт хийгээд ажил хөдөлмөр эрхлэх ёстой насны бүх хүмүүстээ бас дүгнэлт хийгээд тухайн хүмүүсийг ажилд зуучлах энэ бодлогыг хэрэгжүүлж байгаа.

Өнгөрсөн жил хувийн хэвшил том бүтээн байгуулалтын салбарын хэмжээнд 50000 орчим ажлын байрны захиалга ирсэн. Үүнээс 29000 ажлын байран дээр зуучлах бодлого одоо бас хэрэгжсэн гэдгийг бас хэлье. Мөн энэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой уялдуулаад манай Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 100 орчим тэрбум төгрөгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогуудыг бас хэрэгжүүлсэн.

Өнгөрсөн жил бид нар түрүүн бас гишүүд асуугаад байна цалин хөлсний нэмэгдэл энэ нийгмийн дундаж давхаргыг хамгаалах бодлоготой бас уялдаж яригдах ёстой. Эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарт ажиллаж байгаа 107000 орчим төрийн албан хаагчдын цалингийн ангилал зэрэглэлийг сайжруулах энэ бодлогыг Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлсэн.

Өнгөрсөн жил бид нар тэтгэвэр авч байгаа хүмүүсийн ахмадуудын тэтгэврийг нэмэгдүүлэх хамгийн багадаа 15-аас дээш хувиар нэмэгдүүлэх бодлогыг Засгийн газрын зүгээс бас авч хэрэгжүүлсэн. Энд 637 орчим тэрбум төгрөгийг бас зарцуулсан гэдгийг хэлэх гэсэн юм. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ерөнхийдөө асуусан асуултад яг тодорхой хариу авсангүй шүү. Ер нь дараа бид нар ажлаа дүгнэхдээ 1 жилийг ч дүгнэх ч бай 4 жил 5 жилээр нь дүгнэх ч бай бид нар энэ тодорхой гарсан үр дүнг нь хэчнээн айлыг дундад давхаргад оруулсан юм, хэд нь ямар ямар орлоготой айлууд нь орсон юм? Бүр тодорхой хэдэн тоо баримт байх ёстой.

Тэгэхээр зэрэг дараагийн энэ үзүүлэлтийг зөвхөн тэдэн ажлын байр бий болгосон, тэдийг хадгалсан гэдэг үзүүлэлтээр биш яг одоо энэ хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд хэчнээн аль яг дундад давхаргатай энэ өрхийн тоонд ороод явчихсан юм гэдгийг бүүр тодорхой. Ийм ийм ажлын байр болоод

ийм орлого нь нэмэгдээд ингээд явсан гээд бид нарт хэлдэг байвал зүгээр байна. Тэгээд тэр дээрээ бид нар дүгнэлтээ хийгээд цаашидаа бас бодлогоо гаргаад явдаг бол одоо үр дүн сайн гарч бид нарын зориод байгаа зорилт, зорилтдоо хүрэхэд бас дөхөлтэй болов уу гэж бодож байна.

Дараа тодорхой тоотой байна шүү. Дараа жилийн бид нар 23 оны ажлыг дүгнэж ярихад би өөр үзүүлэлт дээр бид нар шалгуур үзүүлэлт гаргачихсан үр дүнгээ бас энэ өөр тоогоор бид нар гаргаж харуулаарай. Тэн дээр бид нар тодорхой ярьж гэж бодож байна. Чуулган дээр ч бас асуух байх. Та нар бас чуулган дээр энэ дээрээ хариулттай ирээрэй.

Хоёрт энэ том улсын төсөв энэ гадаадын дээд тусламж гээд аль алийг нь ашиглаад явуулж байгаа энэ Засгийн газраас хэрэгжүүлж байгаа энэ том бүтээн байгуулалтын төслүүд дээр одоо энэ Хөгжлийн яам гарчихсан бодлого гарч байгаа учраас та бүхэн энэ бодлого төлөвлөлтөө маш нарийн хийгээч Энэ зөвхөн манай улсад гардаг асуудал биш. Тэр хөгжсөн, хөгжиж байгаа, ядуу, энэ бүх л улс орны Засгийн газраас хэрэгжүүлж байгаа энэ том төслүүдэд гардаг зовлон юм шиг байна лээ.

Тэгэхээр энэ сайн тэр хөгжсөн орноос нь ч бид нартай адилхан түвшинд яваа хөгжиж байгаа орноос ч гэсэн суралцаад энэ дээр одоо тэр хамгийн түрүүнд тэр төлөвлөлтийг маш нарийн нямбай сайн хийх юм бол бид нар өнөө бушуу туулай борвиндоо баастай гэдэг шиг хам хум юм хийж давхиж ороод л. Тэгээд л хэдэн Их Хурлаар төсвөө батлуулж авахын тулд бага шиг тоо ярьж ороод л, тэгээд л сүүлд нь нөгөө нэгэнт хийгээд эхэлсэн бол нөгөөдхөө хаях аргагүй болгож тавиад л тэгээд л араас нь юм залгаад л ингээд л дуусдаггүй ийм олон жил явдаг ийм л ажлууд болчихдог юм байна лээ.

Тэгэхээр энэ дээр та бүхэн төлөвлөлтөө маш нямбай сайхан хийгээд

явчихдаг бол үр дүн сайн гарах юм шиг байна лээ гэж зүгээр санал хэлэх гэсэн юм. Баярлалаа. Ингээд Доржханд гишүүн асуултаа асууя. Доржханд гишүүний микрофоныг нээе даа.

Т.Доржханд: Баярлалаа. Сайд нар маань бүгдээрээ гараад явчихсан энэ Эдийн засаг, хөгжлийн сайд нь сууж байх шиг байна. Тэгээд энэ эдийн засгийн асуудлаас нь асууя. Тэгээд дараагийн удаа сайд нар нь баймаар байна. Энэ тулгаж бас энэ зузаан материал бас өгмөөргүй байна. Тэгээд өглөө гэхэд бас их цаас харагдаж байна даа бас. Тэгээд нөгөө манайх чинь цахим засаглалтай орон болж байгаа гээд байдаг. Тэгэхлээр энэ бас таарч байна уу үгүй юү?

Тэгэхлээр хэдэн асуулт байна. Энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлтийн 3.Эдийн засгийн бодлого. Үүн дотроо 3.1.3. Банкны салбарын шинэчлэлийг богино хугацаанд хийж, банк санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг өртөг багатай санхүүжилтээр дэмжиж, банкны зээлийн сарын хүүг 1 хувиас хэтрүүлэхгүй болгож эрсдэл даах чадамжтай болгоно.30 хувь гэсэн байна.

Гэтэл одоо бодит байдал дээр банкны хүү ямар байгаа билээ? Хүртээмж ямар байгаа билээ энэ дээр Эдийн засаг, хөгжлийн сайд хариулна байгаа. Ийм бодитой биш тооцоолол хийгээд оруулж ирдэг нь энэ Засгийн газар юм уу, аль эсвэл энэ Монголбанк юм уу? Тэгээд ийм бодитой бус бодлогын арга хэмжээ авч явсан нь үнэн шүү дээ тээ? Тэгээд Монголбанкны тэр буруу бодлогын золиосны үр дүнд маш олон хувийн сектор бол алдагдал хүлээсэн нь үнэн. Инфляцаа барьж чадаагүй нь үнэн, ханшаа алдсан нь бас үнэн. Тэгээд энэ бүх асуудлыг яаж уялдуулж байгаа юм бэ гэдэг юмыг асуучихмаар байх юм.

Хоёр дахь нь болохлоор 3.1.13.Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн хэрэглэгчийн эрх ашгийг

хамгаалсан шинэчлэлийн бодлого хэрэгжүүлнэ. Яг энэ ямар бодлого байгаа юм бэ? Бүүр реформын шинж чанартай ийм бодлого яг юу байсан юм бэ? Тэгээд яагаад 31 хувьтай хийгдэж байгаа талаар бас мэдээлэл өгөөч.

Дараа нь 3.1.17 чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа үйлчилгээ хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана. 37.4. хувь.

Өчигдрийн тэр танай бүлгийн мэдээллээр болохлоор гадаадын хөрөнгө оруулагч нар одоогийн байдлаар хуулийн этгээд хувь хүн нийлээд 15 байна гээд . Сайн цагт бараг 2000 хүрч байсан гээд. Энэ бодит байдал дээр гадаадын хөрөнгө оруулалт бараг 0 байгаа шүү дээ. Тэгэхлээр яаж энэ тоо бас ингээд гараад байна? Тэгээд та бүгд маань бас яаж гаднынхаа хөрөнгө оруулалт бизнесийн салбарыг дэмжих гээд байна гэдгээ бас хэлчихмээр байна.

Дараагийн зүйл нь болохлоор 3.1.20.Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуй нэгжид тусгайлан дэмжих экспортын баталгааны сан байгуулж ажиллана. Ийм сан бид нар ярьсан юм байдаг билүү? Эсвэл Засгийн газрын түвшинд ярьсан юм уу? Бид нар чинь сая баахан сангуудын асуудал, хамгийн сүүлд Хөгжлийн банкны асуудал ингээд яриад энэ маань өөрөө ингээд болдоггүй юм байна. Эрх мэдэлтэй хүмүүс нь хулгай хийчихдэг юм байна, үр ашиггүй зарцуулчихдаг юм байна гэдэг дээр уг нь дүгнэлт хийгээд явж байгаа даа.

Тэгээд энэ хаанаас бас ийм сан гараад ирэв гэдэг дээрх ариулт өгчихмөөр байх юм? Тэгээд ямар учиртай юм, тэгээд хэрэгжилт нь яаж явж байгаа юм бэ гээд.

Сүүлийн асуулт энэ түүхий эдийн биржийн асуудал байна. Тэгээд одоогийн байдлаар 3 сарын 20-ны байдлаар 312000 тонн ийм нүүрсийг гаргасан. Үнийн зөрөө маш өндөр ялгаатай ам нөхцөлөөс илүү 170, 180 ам доллароор зарагдаж байна гэдэг маш сайн. Гэхдээ энэ маань нийт дүнгийнхээ 1 хувьтай л тэнцэх ийм хэмжээнд байдаг. Сая хөрөнгийн бирж дээрээс асууж байхад 6 сая тонныг гаргах зорилттой гээд. Тэгээд энийгээ яаж бид нар ингээд бэхжүүлээд яах билээ? Энэ сайн жишгээ хадгалж явахгүй бол буцаад ухралт хийгээд хуучин нөгөө пирамид сүлжээ рүүгээ ороод, авлига .../минут дуусав./

Н.Энхболд: Хүрэлбаатар сайд.

Ч.Хүрэлбаатар: Эхний асуулт энэ банкны хүүг буулгах тухай асуудал байгаа. Энэ тэгээд 2020 онд хийгдэж байсан бодлогын баримт бичгүүдийн энэ хэрэгжилт л дээ. Гэхдээ сүүлийн 3 жилийн хугацаанд бид нар энэ цар тахалтай холбоотой, дайнтай холбоотойгоор дэлхий нийтээр үнийн өсөлт явагдсаныг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгээд үүнтэй холбоотойгоор дэлхийн улс орнууд өөрсдөө бодлогын арга хэмжээнүүдээ аваад хэрэгжүүлээд явж байна. Зөвхөн Америкийн Нэгдсэн Улс гээд л ингэхэд чинь бодлогын хүүгээ хэд нэмчхэв? 6 удаа нэмчихлээ. Монгол Улс бас хэд 2, 3 ч нэмчихэв үү? Дэлхийн ер нь сая Европын холбооныхон бас бодлогын хүүгээ 0.5 функтээр нэмэх ийм шийдвэр гаргаж байгаа.

Тэгэхээр яг дэлхий дээр улс орнуудын өмнө тулгамдаад байгаа үнийн өсөлттэй тэмцэж байгаа гол арга бол мөнгөний бодлогын л арга хэрэгслүүд байгаа. Тэгэхээр энэ бодлогын хүрээнд бодлогын хүүг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор манайд мөн ялгаа байхгүй. Дагаад энэ хүү өсөх ийм хандлагатай байгаа.

Дээр нь инфляц ийм ний нуугүй хэлэхэд чинь 17 хувьд хүрсэн шүү дээ. Одоо эргээд 13, 12 хувь руу бууж байна. Оны 2 дугаар хагас, эхний хагастаа багтаад 1 оронтой тоо руу орчих болов уу гэсэн ийм бодлого барьж ажиллаж байгаа гэдгийг хэлье. Хэрвээ инфляц буулгаад, буугаад эхлэх юм эхэлбэл бодлогын хууг буулгах боломжтой. Түүнээс наана нь буух боломжгүй. Тэгэхээр энэ ажлын биелэлт нь яг энэ ерөнхий эдийн засгийн бодлоготойгоо уялдаад явж байгаа гэдгийг би хэлье.

Дараагийн асуудал бол энэ биржийн тухай асуудал байгаа. Ер нь нүүрсээ бид нар биржээр зарж байгаа. Тэгэхээр энэ бодлого бол цаашидаа хатуу явна. Харин биржээр зардаг бүтээгдэхүүнээ зөвхөн нүүрсээр хязгаарлахгүй гэж бодож байгаа. Зэсээ зарах ёстой, төмрийн хүдрээ зарах ёстой, жоншоо зарах гээд гэх мэтээр ингээд бүх бүтээгдэхүүнүүдийг ер нь биржээр зардаг болж байгаа ийм шилжилтийг хийх ёстой.

Тэгэхээр Доржханд гишүүн бол ер нь энэ бирж гэдэг юм цаашаа улам л өргөжиж, тэлж, энэ хэвшил дадал болж хувирах ийм бодлого руу хатуу явна гэдгийг хэлье. Засгийн газрын дээр хатуу байгаа.

Мэдээж нөгөө 2 захирал сууж байгаад гэрээнүүд байгуулчихдаг. Тэр сайхан цаг үе рүүгээ буцъя гэж бодож байгаа хүмүүс цөөнгүй байгаа. Аль болохоор саад болохыг бодож байгааг ч хүмүүс бий.

Тийм учраас энэ ажил бол цаашидаа үргэлжлээд хатуу явна гэдгийг хэлье. Гадаадын хөрөнгө оруулалтын хувьд бол ер нь өнгөрсөн хугацаанд бид нар харлаа гадаадын хөрөнгө оруулалтыг татаж хөгжихгүй бол болохгүй гээд. Гадаадын хөрөнгө оруулалт хэрэггүй зөвхөн өөрсдөө хийе гээд ингээд явсан бас цаг хугацаанууд Монголд байгаа шүү дээ. Ингэхээр гадаад өрийн хэмжээ нэмэгдээд эргээд энэ нь

ингээд эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгодог. Эргээд энэ нийт ард түмний үнийн өсөлт, хүүгийн өсөлтөөр төлдөг гэдгийг бид нар бүгдээрээ мэдэрсэн.

Тэгэхээр цаашидаа бид нар энэ хувийн хэвшлийг улам хөгжүүлэх гаднын хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр бодлого бол явна. Энэ дээр өөр дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын туршилагыг хараад ч тэр ер нь улс орноо Монгол Улсыг богинохон хугацаанд хөгжүүлэх зорилгын хүрээнд ч тэр бид тэр хөрөнгө оруулагч нарыг татаж явахаас өөр арга байхгүй гэдгийг би хэлье.

Нийтдээ өнөөдрийг хүртэл Монгол Улсад оруулсан хөрөнгө гаднын хөрөнгө оруулалтын хэмжээ 39.8 тэрбум америк доллар байгаа.

Н.Энхболд: Хүрэлбаатар гишүүний микрофоныг өгье. Дараа нь Сайнзориг 7 номерыг өгчхөөрэй.

Ч.Хүрэлбаатар: Үүнтэй холбоотойгоор энэ гадаадын хөрөнгө, ер нь хөрөнгө оруулалт худалдааны агентлагийг сая байгуулсан. Ингэхээр энэ бизнес эрхлэгчид, бизнест хөрөнгө оруулж байгаа хүмүүс 1 цэгийн үйлчилгээ үзүүлэх, хилээр гарч байгаа бүтээгдэхүүн, орж ирж байгаа бүтээгдэхүүнүүд дээр авдаг янз бүрийн хүнд суртал, үе шат эд нарыг нь аль болохоор бууруулах, багасгах энэ чиглэлийн бодлогыг Засгийн газар баримталж ажиллаж байгаа.

Тэр арьс ширний экспортыг хорьсон 2013 оны шийдвэрийг одоо цуцалсан байж байгаа. Тэгээд эндээс юу харуулж байна вэ гэхээрээ ер нь хааж, боож Монгол Улсад бизнес хөгждөггүй юм гэдгийг л дахиж нотолж байна шүү дээ. Энийг бол бүгдээрээ л мэддэг.

Гэхдээ хааж байгаад тодорхой салбаруудыг хөгжүүлчихье гэдэг ийм бодлоготой цөөхөн хүмүүс байсан. Тэгээд

хүмүүсийн бодлого нь буруу гэдгийг харуулж байгаа.

Цаашидаа ер нь энэ улс орноо хөгжүүлэхийн тулд бид нар аль болохоор шинэлэг зүйлүүд бусад орнуудын улс орноо хөгжүүлж ирсэн туршиллагуудыг л нэвтрүүлж аль болохоор хөнгөн шуурхай, шат дамжлага багатай байж байж энэ тухайн улсад бизнес хөгждөг гэдгийг бид нар мөрдөж ажиллана гэдгийг хэлье.

Экспортын сан гэдгийг экспорт дээр гаргаж байгаа үед даатгалын схемийг ярьж байсан түүнтэйгээ ойлгож болно гэж би хэлье. Экспортын даатгал гэж ойлгож болно.

Н.Энхболд: Доржханд гишүүн нэмж тодруулъя.

Т.Доржханд: Тэгэхлээр Хүрэлбаатар сайдаа энэ түүхий эдийн бирж бол цаашиа бид нар хийгээд явах ёстой. Дан ганц нүүрс дээрээ биш, зэс гээд бусад дээр нь хийх ёстой. Харин энийгээ яаралтай эхлүүлэх хэрэгтэй. Тэгэхлээр энэ нөгөө 7 сарын 1-нд хууль батлуулаад тэрийгээ хараад байна уу? Аль эс үгүй бол цаг хугацааны хувьд наана нь эхлүүлэх тэр ажлаа хийгээд явж байна уу? Энэ дээр мэдээлэл өгөөч.

Хоёрдугаарт болохлоор энэ Экспортыг дэмжих сан гэдэг нь нөгөө... ч гэдэг юм уу яг тэр нөгөө экспорт, импортын даатгалыг нь хангаад түүнээс биш бид нар чинь экспортыг дэмжих импортыг орлох гээд л Хөгжлийн банк байгуулаад тэгээд ямар байдалтай байгаа билээ. Тэгэхлээр гаднаас ч юм уу хөнгөлөлттэй эх үүсвэр олж ирээд зөвхөн тэр хүмүүсийг санхүүжүүлнэ гэдэг зүйлийг биш гэж ойлголоо шүү дээ. Та энэ дээр баталгаажуулаад хэлчхээрэй. Тэгээд энэ гадаад зах зээл

Н.Энхболд: 1 минут нэмээд өгчихье. Дахиад 1 минутын эрх байна. Энэ дэгээрээ энэ 1 юман дээр 2 удаа.

Т.Доржханд: Сангийн яамнаас асуух гээд байгаа юм л даа. Энэ гаднаас эх үүсвэр татах тэр цонх бол маш боломжтой цонх дээр нь амжилттай гаргасан юм байна лээ л дээ. Тэгж бондоо гаргасан. Гэтэл гадаад орчин чинь болохлоор маш хэцүү болчихсон. Бодлогын хүүнүүд өсөөд эхэлж байгаа. Америкт инфляц асуудал болоод үр дүнд нь бодлогын хүүгээ өсгөх, гадаад нөгөө санхүүгийн байгууллагууд дампуурах, хөрөнгийг ингээд татах гээд ийм нөхцөл байдал үүсчхээд байна.

Тэгэхлээр энэ жилийн хувьд бид нар чинь бас тодорхой эх үүсвэрүүдийг төлөх, Хөгжлийн банкны эх үүсвэрүүдийг төлөх гээд асуудлууд байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ чинь нөгөө төсвөөс бид нарт эх үүсвэр байхгүй. Тэгээд хаанаас эх үүсвэр байгаа юм? Байхгүй. Гаднаас л бид нар эх үүсвэр босгож дахин санхүүжилт хувилбар руу орохгүй болдог.

Гэтэл гадаад зах зээлээ орчихсон чинь дахиад цонх үүсэхээргүй ийм нөхцөл байдал байна. Тэгээд энэ дээр Сангийн яамныхан яг яаж шийдэх юм бэ? Тэгэхгүй бол дахиад нөгөө кросс дефолт гэдэг юм руу орчих вий дээ гэдэг.../минут дуусав./

Н.Энхболд: Хүрэлбаатар сайд хариулах уу? Ганбат дарга хариулах уу? Сайнзориг дарга наана чинь сууж байгаад хариулаадаг. Тэр 7 номерын микрофон дээр очоорой.

Б.Сүх-Очир: Доржханд гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сүх-Очир. Таны хэлсэнтэй яг 100 хувь санал нийлж байна. Бид нар 21, 22, 23, 24 он бол хамгийн их гадаад өр төлбөр төлөх жилүүд байгаа. Энэ дотор ялангуяа энэ 23 он бол бидний 2017 онд гаргасан “Гэрэгэ” бондын 600 сая ам долларыг төлөх жил байсан. 23 онд, 24 онд бид нар “Хуралдай” бондын төлбөрийг төлөх ёстой. Өмнө бол бид нар өрийн дахин санхүүжилтийн арга хэмжээг яг цэвэр өрийн зохицуулалтын арга хэмжээг 2019,

20, 21 онуудад *Nomad, century* гэдэг зохион байгуулалттайгаар хийж байсан.

Тэгээд ер нь бол 11, 12 онд бол яг манайх шиг улсын хувьд боломж олдоогүй. В зэргэлэлтэй улсын хувьд бол яг бонд гаргах ямар ч боломж байгаагүй. 1 сард бол яах аргагүй цонх үе гарч ирсэн. Өөрөөр хэлбэл бүх хөрөнгө оруулалтын *fin*-ууд маань өөрсдөө яг мөнгөө энэ жил хаашаа хуваарилах вэ гээд хуваарилалтаа хийж эхэлж байсан үе дээр Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн яам, Монголбанк хамтраад өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байгаа.

Үүгээр бол 650 сая ам долларын *century 2 project*-ыг хэрэгжүүлээд энэ жил төлөх ёстой байсан “Хуралдай” бондынхоо асуудал, “Гэрэгээ” бондынхоо асуудлыг бүрэн шийдчихсэн. Тэгэхээр энэ жил бол яг Засгийн газрын зүгээс бол хамгийн том төлбөр 5 сард төлөгдөх ёстой байсан 500 сая ам долларын “Гэрэгээ” бондын асуудлаа бол шийдчихсэн байгаа юм.

Таны асуулттай холбоотой Хөгжлийн банкны 2 том төлбөр байгаа. 10 сард 510 сая долларын “Сэргэн мандалт” бонд, 12 сард 30 тэрбум иений “Самурай” бонд гээд.

Өнгөрсөн жилүүдэд Хөгжлийн банкны хувиас бол эх үүсвэрийг татан төвлөрүүлээд 2022 оны 12 сард “Чингис” бондын хамгийн сүүлчийн төлбөрийг төлж байгаатай зэрэгцээд “Самурай” бондын эх үүсвэрээ бүрэн цуглуулчихлаа одоо төлөхөд бол асуудалгүй гэдэг бол анансим-даа хийсэн байгаа. Энийгээ бол Монголбанкттай иений своп хэлцлээ хийгээд өөрөөр хэлбэл иенээ ч бас 30 тэрбум иенийгээ бүрдүүлчихсэн байгаа юм. Яах аргагүй тэрний урд тал дээр төлөгдөх ёстой 500 сая ам долларын “Сэргэн мандалт” бонд бол бид нарын хувьд бол бас нэлээн хүнд даалгавар байгаа.

Гэхдээ зах зээлийн нөхцөл байдал өөрөө пээдийн хүү өсөөд байхаар таатай нэг зүйл нь гадаад зах зээл дээр манай бондуудын өгөөж нь өсөөд, хоёрдогчийн үнэ нь бол ингээд унаад ирж байгаа юм. Тэр үед бол бас боломжоороо бол Хөгжлийн банк буцаан худалдан авалтыг хийж байгаа. Хөгжлийн банк болон Сангийн яаман дээр ажлын хэсэг байгуулагдаад энэ жилийн 10 сард төлөгдөх 500 сая ам долларыг хэрхэн дахин санхүүжилт хийх вэ гэдэг дээр ажиллаж байгаа. Банкнуудтайгаа ярилцаад явж байгаа. Хөрөнгө оруулалтын банкттайгаа.

Н.Энхболд: Батсуурь гишүүн асуултаа асууя.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн жил Засгийн газрын тэргүүн орон нутагт ажлаад, ард иргэдтэй уулзаад, иргэдээс санал, асуулга хийгээд ингээд газар дээр нь 4, 5-н асуудлыг шийдэхээр ингэж зарласан байгаа юм. Тэгээд энэ 5 асуудлыг 23 оны төсөвт үндсэндээ эхлүүлнэ, санаа зовох зүйл байхгүй ингээд ер нь бас нүүрсний экспорт Засгийн газар хөдөөгийн хөрөнгө оруулалт эдгээр зүйлийг хасахгүйгээр дорвитой арга хэмжээнүүдийг авна гээд ингээд орон нутгаар явсан.

Тэгээд Сүхбаатар аймагт 22 оны 7 сарын 2, 3-ны өдрүүдэд ажиллахдаа 5 зүйлийн асуудлыг бас амлаж ард иргэдэд эрэмбэлж байгаад 10, 15 асуудлаас эхний 5-ыг нь шийдье гэж ингэж асуудлыг шийдсэн байгаа юм.

Гэтэл нөхцөл байдал төсөв батлагдах үед 23 оны төсөв дээр шинээр хөрөнгө оруулалт байхгүй гээд ингээд хойшлуулсан. Тэгээд энэ асуудал ер нь Эдийн засаг, хөгжлийн яам бусад яамнууд дээр яаж хийгдэх бэ? Энэ Засгийн газрын тэргүүний эрэмбэлж энэ асуудлуудыг зайлшгүй шийднэ гэсэн энэ 5 асуудал ер нь ямар түвшинд явж байгаа бэ?

Нэгт нь дулааны цахилгаан станцын 20 мегаваттын өргөтгөлийн гаднах шугам, сүлжээ 2 дугаар хэлхээний өргөтгөлийн Баруун-Урт суман дээр хийнэ.

Хоёрт нь 4.8 тэрбум аймгийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн өргөтгөл 10000 киловаттын дэд станцын барина, 3.2 тэрбум төгрөг. Дарьганга хүүхдийн зусланг орчин үеийн стандартад нийцүүлсэн энэ асуудлыг иж бүрнээр нь шийднэ гээд 11 тэрбум төгрөг, зүүн бүсийн аялал жуулчлалыг нэг маршрутад оруулах зорилгоор Баруун-Урт, Сүхбаатар сум, бүр жанжны нутаг гэж оруулсан байгаа юм. Буйр чиглэлийн 61.9 км урт зам, 69 тэрбум төгрөг. Бичигтийн боомт олон улсын байнгын ажиллагаатай боомтыг дэмжих зорилгоор үйлдвэрлэлийн бүсийг барьж байгуулах энийг Баруун-Урт дээр гээд 3.8 тэрбум төгрөг гээд ингээд нийтдээ 10 гаруй асуудлаас эхний 5-ыг нь шийдвэрлэнэ гээд ингэсэн байгаа юм.

Тэгээд үүнд гүйцэтгэлийн төлөвлөгөө юунууд байхгүй байх юм. Энэ ер нь цаашид хэрэгжих эд үү, хэрэгжихгүй эд үү? Засгийн газрын тэргүүний хувьд бол протокол юмыг нь харахад бол Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр холбогдох яамнуудад нь өгчихсөн байж байдаг. Орон нутагт бол санаа зовох зүйл байхгүй ийм зүйл бол бүрэн хийгдэнэ энэ байтугай зүйлүүдийг бүх аймгуудад хийхгүй бол бид нар эдийн засгийн хямралаас гарч чадахгүй юм гэж хэлсэн байдаг юм. Одоо энэ 23 оны төсөвт суугаагүй цаашид яах ёстой бэ гэдэг асуудлын хариуг авъя. Тэгээд тодруулъя.

Н.Энхболд: Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд Хүрэлбаатар сайдын микрофон.

Ч.Хүрэлбаатар: Бид нар 22 онд хийсэн ажлуудын биелэлтийг ярьж байгаа. 24 оны жилийн төлөвлөгөөг Засгийн газар дээр ярьчихаад тэгээд Улсын

Их Хуралтай ярьчихаад 5 сарын 1-нээс өмнө өргөн мэдүүлнэ. Тэр үед ярья.

Н.Энхболд: Батсуурь гишүүн тодруулъя.

Ж.Батсуурь: 22 онд ингээд амласан амлалтууд энэ төлөвлөгөөнд яаж суусан юм? Одоо ямар нөхцөл байдалтай байна уу л гэж асуугаад байна л даа.

Н.Энхболд: Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Сая хариулчихлаа л даа. 24 оны жилийн төлөвлөгөө дээр одоо Засгийн газар суугаад ажиллаж байгаа. Тэгээд хуулиараа 5 сарын 1-нээс өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ёстой. Тэр үед ярьсан нь дээр. Тэгэхгүй бол 22 оныг 21 онд баталчихсан төлөвлөгөөний биелэлт ярьж байна шүү дээ. 21 онд баталсан төлөвлөгөөний биелэлтийг одоо бол.

Н.Энхболд: Батсуурь гишүүн дахиад тодруулъя.

Ж.Батсуурь: 22 оны 7 сарын 2-нд Ерөнхий сайдын хэлсэн тэр зүйлүүд яагаад суугаагүй юм бэ л гэж хэлээд байгаа юм. Тэгэнгүүт та 24 оны юм ярихаар ярилцъя гээд ингээд асуугаад байгаа юм.

Н.Энхболд: Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Харин 24 онд хийх ажлуудыг бид нар 5 сарын 1-нээс өмнө өргөн мэдүүлнэ гээд ярьж байна шүү дээ. Бид нар чинь өмнө нь одоо 20 онд баталсан, 21 онд баталсан баримт бичгүүдийн биелэлтийг яриад сууж байна шүү дээ одоо.

Н.Энхболд: 22 оны амлалт яачхав л гээд байна л даа.

Баярлалаа. Өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтраад Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 5 жилийн үндсэн чиглэл 2020-24 онд хийх ажил, үүний дотор 22 онд хийх ёстой байсан ажлуудын гүйцэтгэлийн талаар Засгийн газрын тайлан, түүнд гаргасан аудитын дүгнэлтийг сонсож, танилцлаа. Хуулиараа бол Байнгын хороод танилцлаа гэсэн байдлаар энэ асуудал төгсдөг. Гэхдээ үүн дээр бид нар цаашидаа анхаарах зүйлүүд байн.

Ер нь хуучин энэ жилийн төлөвлөгөө 3, 4 жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэл энэ тэрийг бол яриад л өнгөрдөг байсан юм. Яг үнэн энэ талаар бас хэд хэдэн гишүүд нэлээд тодорхой шүүмжлэлтэй хандаж, ярьж энэ Баттөмөр гишүүн хэллээ, Ганибал гишүүн хэллээ, Ганболд гишүүн, сая Батсуурь гишүүн ярьж байна. Одон жил яригдаж байгаад одоо өөрчлөлт орж эхэлж байгаа юм.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар улс орны хөгжлийн төлөвлөлт, түүний гүйцэтгэл, түүнд тооцох хариуцлагын талаар оруулсан нэг чухал заалт юу гэхээр энэ төлөвлөлт тогтвортой байх ёстой, гүйцэтгэл нь тогтвортой байх ёстой. Ямар ч төр засаг гарсан урт болоод, дунд хугацааны төлөвлөсөн зүйлүүд залгамж чанар, тогтвортой байдлаа хадгалаад үргэлжилж байх ёстой гэсэн ийм хуулийн зохицуулалтыг Үндсэн хуульдаа хийсэн.

Одоо ямарч Засгийн газар байсан түүрүү түүрүүчийн үеийнх шиг энэ хуучин дэмий юм байсан юм одоо энийг болиод өөр юм цоо шинээр эхлүүлнэ гээд явах боломжууд нэлээд хаагдсан. Яг энэ үндсэн дээр хэлэлцэх, дүгнэлт гаргах асуудалдаа ч онцгой анхаарч Улсын Их Хурал үүний дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль гэж гаргасан. Засгийн газар дээр энэ Засгийн газрын үйл

ажиллагааны хяналтыг хянаж байх, гүйцэтгэлийг хянаж байх тусгай биеэ даасан нэгж байгуулаад ингээд ажиллаж байгаа юм.

Эд нарын үр дүн юу байх ёстой бэ гэхээр цаашидаа бид нар зүгээр сонсоод өнгөрдөг биш үүний дагуу арга хэмжээ авдаг, жилийн төлөвлөгөө яаж биелэв, 4 жилийн гүйцэтгэлд ямархуу байж уу, энэ гүйцэтгэл сайн байвал цаашидаа яах уу, муу бол хэн хариуцах юм гэдэг юмыг нь тодорхой яриад, хариуцлага гэдгийг нь тодорхой яриад хариуцлага тооцдог энэ тогтолцоо руу орох ёстой юм.

Тэгэхээр юуны өмнө хяналт шалгалтын хуульдаа бараг миний бодож байгаа дээр Байнгын хорооны гишүүд бодно биз. Ийм тайлан, аудитын илтгэлийг сонсчихоод араас нь тодорхой чиглэл өгдөг, арга хэмжээ авдаг ийм зохиуцаалтад орох хэрэгтэй. Тэгэхгүй бол үндсэндээ сонсоод өнгөрчхөж байгаа юм. Яах вэ, Их Хурлаас тогтоол гаргах болно.

Дараа дараагийн энэ тайлангууд оруулж ирэхдээ Засгийн газар өнөөдөр Хүрэлбаатар сайдын хэлсэн шиг бид нар яамдаараа гүйцэтгэлээ ярьсан, тодорхой хүмүүстээ, тодорхой яамнууд дээр ажил нь дутуу явж байвал хариуцлага тооцох асуудал бас яригдаж байгаа гэж хэлсэн. Энэ их сайн мэдээ байна. Энийг бид нар бас харж байх болно. Зориуд анхааралдаа авлаа шүү гэдгийг хэлсэн.

Ингээд цаашидаа бид нар дахиад хэлэхэд зүгээр ингээд сонсоод өнгөрдөг биш Засгийн газраас асуудлаа оруулж ирэхдээ бид нар ажлаа дүгнэж үзээд, гүйцэтгэлээ гаргаад энэ тал дээр хангалтгүй ажилласан Засгийн газрын гишүүд, холбогдох хүмүүст ийм хариуцлага тооцож байгаа гэдэг үгтэйгээ, хэрэв тийм юмтай орж ирэхгүй бол Их Хурал дээр хэлэлцээд тэрнийхээ дагуу шаардлагатай гэж үзвэл ийм ийм хүмүүс дээрээ хариуцлага тооц гэсэн хүсэлт байдаг юм уу, шаардлага чиглэл

өгдөг ийм зохицуулалт уу орох нь зүйтэй гэсэн ийм бодолтой байна.

Энэ дээр манай хоёр Байнгын хороо хамтраад хууль санаачлалдаг юм уу яадаг юм хамтраад ярилцах хэрэг гарах байх.

Тэгэхгүй бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орчихоор хариуцлагын тухай, эрх үүргийн тухай нарийвчилсан зохицуулалтын тухай яриад эхэлчихсэн байхад одоо урьдынх шиг зүгээр жилийн төлөвлөгөө, 4 жилийнхээ төлөвлөгөөний гүйцэтгэлийг зүгээр л яриад л орхидог хуулиудын дагуу өмнөх жилүүдийн тайлан, танилцуулгыг сонсож байгаагүй юм байна. Сая бид нар эхнээс нь аваад нэгдүгээрт 22 оныхоо дүнг, хоёрдугаарт өссөн дүнгээр ерөнхийдөө тоонуудаа танилцуулчихлаа. 4 жилийн ажлын гүйцэтгэл өссөн дүнгээрээ 39 орчим хувьтай яваа юм байна. Аль аль нь.

23 оны гүйцэтгэл гараад 24 онд Засгийн газар тайлангаа тавих үед бас энэ зүйлүүд одоо бол 60 орчим хувьтай оных нь гүйцэтгэл явж байгаа. Сайн ажил бас нэлээн өндөр түвшинд гүйцэтгэл нь гарах байх гэсэн байр суурийг Засгийн газар илэрхийлж байна. Ийм үг хэлчихье.

Саяын хэлэлцсэн асуудалтай холбогдуулан дахиад нэмж үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл хоёр Байнгын хороодын ажлын хэсгүүд нийлээд хэлэлцсэн юугаа бүгдийг нь их сайн тусгаж оруулаарай. Нэлээн дэлгэрэнгүй хийж байгаад хооронд нь нэгтгээд нэгдсэн дүгнэлт гаргаад ингээд чуулганд танилцуулна. Чуулганд Цэрэнпунцаг дарга танилцуулна.

Хэлчихлээ, хэлчихлээ, өмнөх жилүүдийн юм ингээд өссөн дүнгээр сонссонд тооцсон шүү гэдгийг хэлчихлээ.

Хамтарсан хуралдаан дууслаа. Хуралдаанд оролцсон гишүүдэд баярлалаа.

байж ийм байж таарахгүй гэж ингэж бодож байна.

Ингээд өнөөдрийн хэлэлцүүлсэн дүнг Улсын Их Хурлын чуулганд бид нар танилцуулна. Чуулганд асуудлаа Цэрэнпунцаг дарга танилцуулчаарай. Хоёр Байнгын хороо нийлж байгаад хэлэлцсэн талаараа санал, дүгнэлтээ гаргаад явчихна.

Байнгын хорооны ажлын албанаас бас санал ирж байна. Урьд нь энэ гарсан

Дараа нь Эдийн засгийн байнгын хороо хуралдаантай юм байна. Гишүүд нь бүртгэлдээ ороорой. Баярлалаа.

14.39 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ: Д.ОТГОНДЭЛГЭР